



БАНКНЫ САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар хот
2019 он

ГАРЧИГ

Хуудасны
дугаар

Төв банк (Монголбанк)-ны тухай хууль	4
Банкны тухай хууль	29
Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль	77
Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль	87
Үндэсний төлбөрийн системийн тухай хууль	104
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль	126



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨВ БАНК (МОНГОЛБАНК)-НЫ ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Төв банк (Монголбанк)-ны бүрэн эрх, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн мөнгөний бодлогыг Төв Банк (Монголбанк)-наас хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төв Банк (Монголбанк)-ны тухай хууль тогтоомж

Төв Банк (Монголбанк)-ны тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Өрийн удирдлагын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

/Энэ зүйлд 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

2¹ дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.

/Энэ зүйлийг 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3 дугаар зүйл. Төв Банк (Монголбанк)-ны эрх зүйн байдал

1. Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг Монгол Улсын Төв Банк гэнэ. Монгол Улсын Төв Банкныг Монголбанк гэж нэрлэнэ. Монголбанкны төв нь Монгол Улсын нийслэлд байрлана.

/Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

2. Монголбанк нь төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд бөгөөд тогтоосон загвараар хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Монголбанк өөрийн билэгдэл тэмдэгтэй байж болно.

4 дүгээр зүйл. Монголбанкны үндсэн зорилт

1. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2. Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

5 дугаар зүйл. Монголбанкны үйл ажиллагааны чиглэл

1. Монголбанк энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зорилтыг хэрэгжүүлэхдээ дараахь чиглэлийн үйл ажиллагааг эрхэлнэ:

1/мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах;

2/мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;

3/Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх;

4/банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих;

5/үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих;

6/гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах;

7/банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

8/макро зохистой бодлого хэрэгжүүлэх.

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын мөнгөн тэмдэгт

6 дугаар зүйл. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах онцгой эрх

1. Монголбанк Монгол Улсын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах онцгой эрх эдэлнэ.

2. Мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэх, хуурамч мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргахыг хориглоно.

7 дугаар зүйл. Мөнгөн тэмдэгтийн нэгж, хэлбэр

1. Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн албан ёсны нэгж нь төгрөг мөн. Нэг төгрөг зуун мөнгөтэй тэнцэнэ.

2. Монгол Улсын мөнгөн тэмдэгт нь цаасан дэвсгэрт болон зоосон хэлбэртэй байна. Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн хэв загварыг Улсын Их Хурал батална.

8 дугаар зүйл. Төлбөрийн хууль ёсны хэрэгсэл

1. Монголбанкнаас гүйлгээнд гаргасан төгрөг нь өөрийн нэрлэсэн дүнгээрээ Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх төлбөр тооцоонд хэрэглэгдэх төлбөрийн хууль ёсны хэрэгсэл мөн.

2.Төгрөгийг орлох төлбөрийн бусад хэрэгслийг Монголбанкны зөвшөөрлөөр төлбөр тооцоонд хэрэглэнэ.

/Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

9 дүгээр зүйл. Мөнгөн тэмдэгттэй холбогдсон Монголбанкны үйл ажиллагаа

1. Монголбанк мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, гүйлгээнээс татах замаар гүйлгээнд байгаа мөнгөн тэмдэгтийн зохистой бүтцийг хангах үйл ажиллагаа явуулна.

2. Монголбанк мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, түүний нөөцийг бий болгох, хүчин төгөлдөр эсэхийг тодорхойлох, гэмтэж муудсаныг солих, устгах ажлыг эрхлэн зохион байгуулна.

3. Гэмтэж муудсан мөнгөн тэмдэгт солих журмыг Монголбанк тогтооно. Монголбанкны зөвшөөрөлгүйгээр мөнгөн тэмдэгт устгахыг хориглоно.

9¹ дүгээр зүйл. Мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдэхтэй тэмцэх

1. Мөнгөн тэмдэгтийн хуурамч эсэхийг Монголбанк тогтооно.

2. Хуурамч мөнгөн тэмдэгтийг Монголбанк устгана.

3. Мөнгөн тэмдэгтийн хуурамч эсэхийг тогтоох, хуурамч буюу хуурамч байж болзошгүй мөнгөн тэмдэгтийн талаархи мэдээллийг хүлээн авах, хуурамч мөнгөн тэмдэгтийг устгахтай холбогдсон журмыг Монголбанк тогтооно.

/Энэ зүйлийг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Монголбанкны үйл ажиллагаа

10 дугаар зүйл. Мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх

1. Монголбанк төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ.

2. Монголбанк дараагийн жилд баримтлах төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, жил бүрийн 10 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн барих бөгөөд түүнд дараахь асуудлыг тусгасан байна:

1/ тайлант оны төрийн мөнгөний бодлогын хэрэгжилтийн явц, санхүүгийн зах зээлийн байдал, түүнд нөлөөлсөн хүчин зүйл, шалтгааныг тайлбарласан дүгнэлт;

/Энэ заалтад 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2/ Монголбанкнаас дараагийн жилд баримтлах мөнгөний бодлогын зорилт, мөнгөний бодлогод нөлөөлж болох төгрөгийн ханшийн өөрчлөгдөх хандлага, санхүүгийн зах зээлд нөлөөлж болох хүчин зүйлсийн талаархи төсөөлөл.

/Энэ хэсгийг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

11 дүгээр зүйл. Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл

1. Монголбанк төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ дараахь арга, хэрэгслийг ашиглаж болно:

1/ банкны заавал байлгах нөөц, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох;

2/ банкинд зээл олгох, санхүүгийн хэрэгсэл ашиглах;

3/ хүүгийн нэгдсэн бодлого явуулах;

4/ нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах;

5/ банкнаас олгох зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийх.

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

12 дугаар зүйл. Банкны заавал байлгах нөөц

1. Монголбанк иргэн, хуулийн этгээдийн банкин дахь харилцах данс, хадгаламжийн үлдэгдэл болон Монголбанкнаас тогтоосон банкны бусад пассивын дүнгийн тодорхой хувийг бэлэн нөөцийн байдлаар заавал байлгахыг банкнаас шаардана.

/Энэ хэсэгт 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2. Монголбанк банкны заавал байлгах нөөцийн хувь, хэмжээг гучин хувиас дээшгүй байхаар тогтоох бөгөөд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хугацаа, төрлөөс хамааруулан ялгаатай тогтоож болно.

/Энэ хэсгийг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3. Банкны бэлэн нөөц нь тухайн банкны кассад байгаа бэлэн мөнгө ба

Монголбанкин дахь харилцах дансны үлдэгдлийн хэлбэрээр байж болно.

4. Монголбанк банкны заавал байлгах нөөцийг хангасан хэсэгт ногдох бэлэн нөөцөд хүү төлж болно.

5. Монголбанк заавал байлгах нөөцийг дутагдуулсан банкинд торгууль ногдуулна. Торгуулийн дээд хязгаар нь тухайн үед Монголбанкнаас банкинд олгох хамгийн өндөр хүүтэй зээлийн хүү дээр таван нэгж хувийг нэмсэнээс илүүгүй байна.

6. Банкны заавал байлгах нөөцийг тогтоох, тооцох, хяналт тавих журмыг Монголбанк тогтооно.

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

13 дугаар зүйл. Банкинд зээл олгох, санхүүгийн хэрэгсэл ашиглах

1. Монголбанк мөнгөний зах дахь мөнгөн хөрөнгийн нөөцийн илүүдэл, дутагдлыг зохицуулах зорилгоор банкинд зээл олгож, санхүүгийн хэрэгсэл ашиглаж болно.

2. Банкинд олгох зээлийн нөхцөл, санхүүгийн хэрэгсэл ашиглах журмыг Монголбанк тогтооно.

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

14 дүгээр зүйл. Хүүгийн нэгдсэн бодлого явуулах

Монголбанк нь өөрийн зээл, үнэт цаасны хүү болон хямдруулалтын хувиар дамжуулан банкны хүүгийн нэгдсэн бодлого явуулна.

15 дугаар зүйл. Нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах

1. Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ үнэт цаас гаргах, түүнийг худалдан авах, худалдах, Засгийн газрын үнэт цаас, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Монголбанкнаас зөвшөөрсөн бусад үнэт цаасыг мөнгөний зах дээр худалдах, худалдаж авах замаар нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй.

/Энэ зүйлийг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

16 дугаар зүйл. Банкнаас олгох зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийх

Монголбанк энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 1-ээс 4-т заасан мөнгөний бодлогын хэрэгслийг хангалтгүй гэж үзсэн тохиолдолд банкнаас иргэн, хуулийн этгээдэд олгох зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийж болно.

/Энэ зүйлд 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

17 дугаар зүйл. Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх

Монголбанк Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэхдээ дараахь үйл ажиллагааг явуулж болно:

1/зохих нөхцөлийг тусгасан гэрээний дагуу төрийн сангийн нэгдсэн дансыг Сангийн сайдын хүсэлтээр өөр дээрээ байршуулж, Засгийн газрын төлбөр, түүнтэй холбогдох төлбөр тооцоог гүйцэтгэх;

/Энэ заалтад 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2/ Засгийн газраас гаргасан үнэт цаасыг Засгийн газрын хүсэлтээр бусад этгээдэд зуучлан борлуулах ба төрийн мөнгөний бодлогын зорилт, зах зээлийн тухайн үеийн нөхцөл байдалд нийцэж байвал түүнийг худалдан авах, худалдах;

/Энэ заалтад 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

3/ Засгийн газрын болон түүнээс баталгаа гаргасан хуулийн этгээдийн гадаадаас авсан зээлийн төлбөрийн хуваарийг баримтлан төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдлийн хэмжээнд багтаан төлбөр тооцоо гүйцэтгэх;

/Энэ заалтад 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

4/ хууль тогтоомжид нийцсэн зуучлалын бусад үйл ажиллагаа эрхлэх.

5/Өрийн удирдлагын тухай хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа.

/Энэ заалтыг 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

18 дугаар зүйл. Засгийн газарт зээл олгох

1.Монголбанк улсын төсвийн улирлын чанартай орлого, зарлагын зөрүүг нөхөхөд зориулж тухайн санхүүгийн жил дуусахаас өмнө төлөгдсөн байх нөхцөлтэйгөөр Засгийн газарт зээл олгох буюу Засгийн газрын богино хугацаатай үнэт цаасыг худалдан авч болно.

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

2. Тухайн санхүүгийн жилийн түр хугацааны зээлийн үлдэгдлийн нийт хэмжээ нь дотоодоос төсөвт сүүлийн гурван жилд орсон орлогын дунджийн арван хувиас хэтрэхгүй байна. Дотоодоос төсөвт орох орлогод Засгийн газар өөрийн активыг зарж борлуулсны орлого болон дотоодын зээллэг, үнэт цаас гаргаснаар олох орлогыг хамааруулахгүй.

/Энэ хэсэгт 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

3.Засгийн газраас гаргасан үнэт цаасыг Монголбанк худалдан авсан бол түүнийг Засгийн газарт олгосон зээлийн үлдэгдэлд оруулж тооцно. Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан нээлттэй зах зээлийн үйл ажиллагааны хүрээнд богино хугацаанд буцаан худалдах нөхцөлтэй худалдан авсан Засгийн газрын урт хугацаатай үнэт цаасыг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан түр хугацааны зээлийн үлдэгдлийн нийт хэмжээнд оруулахгүй.

/Энэ хэсэгт 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/

/Энэ хэсэгт 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

4. Засгийн газрын гадаадаас авсан зээл, тусламжийн хөрөнгийг түүний зөвшөөрөлгүйгээр Монголбанк эзэмшиж, зохицуулж үл болно.

/Энэ хэсгийг 1998 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

5. Засгийн газарт зээл олгох журмыг энэ хуульд нийцүүлэн Монголбанк тогтооно.

/Энэ хэсгийн дугаарыг 1998 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчилсөн/

19 дүгээр зүйл. Банкны үйл ажиллагаанд хяналт тавих

1. Монголбанк хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгоор банк байгуулах зөвшөөрөл болон банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, банкны өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах, үйл ажиллагааг нь зохицуулах, албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон дүрэм, журам, заавар, аргачлал болон холбогдох бусад шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

2. Банк байгуулах, үйл ажиллагаа явуулах болон холбогдох бусад зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг хүчингүй болгох, банкны удирдлага, зохион байгуулалтын үндсэн зарчмыг тогтоох, хязгаарлалт хийх, шаардлага тавих, хяналт шалгалт хийх, банк, банкны нэгдэлд албадлагын арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох хуулиар зохицуулна.

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

19¹ дүгээр зүйл. Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих

1. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, татгалзах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

/Энэ зүйлийг 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

19² дугаар зүйл. Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл ажиллагаанд хяналт тавих

1. Хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавина.

/Энэ зүйлийг 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/

20 дугаар зүйл. Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих

1. Монголбанк Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, зохицуулж, хяналт тавина.

2. Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд холбогдсон харилцааг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар зохицуулна.

/Энэ зүйлийг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

20¹ дүгээр зүйл. Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зээл олгох

1. Монголбанк эцсийн зээлдүүлэгчийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварт нь түр хугацааны хүндрэл үүссэн, өөрийн үйл ажиллагааны үр дүнд уг хүндрэлээс гарч, зээлийг хугацаанд нь эргэн төлөх боломжтой, төлбөрийн чадвартай банкинд энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан Монголбанкны хүлээн зөвшөөрөх актив хөрөнгийн барьцаатай зээл олгож болно.

2. Монголбанк энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зээлийн нийт хэмжээг тодорхойлж, нэг банкинд олгох зээлийн хэмжээг тухайн банкны зээлжих чадварын хязгаарт багтаан тогтооно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан Монголбанкны хүлээн зөвшөөрөх актив хөрөнгийн жагсаалтыг Монголбанк баталж, нийтэд мэдээлнэ.

4. Монголбанк бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн тохиолдолд Банкны тухай хуульд заасны дагуу банкинд зээл олгож болно.

5. Банкнид зээл олгох нийтлэг журмыг энэ хуульд нийцүүлэн Монголбанк тогтооно.

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

21 дүгээр зүйл. Гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж, удирдах

/Энэ зүйлийн гарчигт 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

1. Монголбанк эзэмшин, удирдаж байгаа гадаад валютын улсын нөөцийн гадаад төлбөрийг түргэн гүйцэтгэх чадвар, найдвартай байдлыг хангах үүрэгтэй. Зөвхөн эдгээр үүрэг бүрэн биелсэн нөхцөлд гадаад валютын улсын нөөцийг ашиглан санхүүгийн зах зээл дээр арилжаалагдах хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх замаар орлогыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж болно.

/Энэ хэсэгт 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2. Монголбанкин дахь гадаад валютын улсын нөөц дараахь төрлийн активаас бүрдэнэ:

1/ гадаад орны банк, санхүүгийн байгууллагад хадгалж байгаа мөнгөжсөн алт;

2/ бэлэн ба бэлэн бус хэлбэрээр байгаа чөлөөтэй хөрвөдөг гадаад валют;

3/ чөлөөтэй хөрвөдөг гадаад валютаар чөлөөтэй төлөгдөх вексель;

4/ гадаад орны Засгийн газар, төв банк, олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан буюу баталгаажуулсан чөлөөтэй хөрвөдөг гадаад валютаар нэрлэсэн, түүгээр төлөгдөх бүх төрлийн үнэт цаас;

/Энэ заалтад 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

5/ олон улсын хэмжээнд гадаад валютын нөөцөд тооцогдох бусад актив.

3. Монголбанк гадаад валютын улсын нөөцийг удирдахдаа энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гадаад валютын нөөцийн бүрэлдэхүүн хэсгийг харилцан чөлөөтэй

хөрвүүлэх, худалдах, худалдан авах үйл ажиллагаа явуулж болно.

/Энэ хэсэгт 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

4. Монголбанк чөлөөтэй хөрвөдөг гадаад валют, түүнтэй адилтгах хэрэгслийг төгрөгөөр худалдах, худалдаж авахдаа төгрөгийн тогтвортой байдлыг хангана.

5. Гадаад валютын улсын нөөц нь Улсын Их Хурлаас тогтоосон доод хэмжээнээс багассан эсхүл гадаад валютын бодлогыг хэрэгжүүлэх болон улсын гадаад төлбөр тооцоог шуурхай явуулах боломж алдагдсаныг Монголбанк тодорхойлсон нөхцөлд Монголбанк Засгийн газартай хамтран холбогдох арга хэмжээ авна.

22 дугаар зүйл. Гадаад валютын зохицуулалт

1. Монголбанк гадаад валютын зохицуулалтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.

2. Монголбанк гадаад валюттай харьцах төгрөгийн ханшны бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхдээ ханш нь чөлөөтэй бөгөөд бодитой байх, төгрөгийн тогтвортой байдал болон үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зарчмыг баримтална.

22¹ дүгээр зүйл. Макро зохистой бодлого хэрэгжүүлэх

1. Монголбанк мөнгөний бодлогын хэрэгжилт болон банк, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг тодорхойлж, үнэлэн түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор макро зохистой бодлогыг боловсруулж, энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэгслийг ашиглан хэрэгжүүлнэ.

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

23 дугаар зүйл. Монголбанкны үйл ажиллагаанд хориглох зүйл

1. Монголбанкнаас дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/ иргэн, хуулийн этгээдэд санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх;

2/ ашиг олох зорилгоор хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө худалдан авах, худалдах;

3/ Засгийн газар болон банк, Хадгаламжийн даатгалын болон Ирээдүйн өв сан корпораци, Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан шууд оролцогч, оператороос бусад хуулийн этгээд, иргэний мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалах, төлбөр тооцоо хийх, зээлийн үйл ажиллагаа эрхлэх;

/Энэ заалтад 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтад 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

4/ хуулийн этгээдийн дүрмийн санд хувь оруулах, үнэт цаас худалдан авах, худалдах.

/Энэ хэсэгт 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

5/ Засгийн газар, банкнаас бусад хуулийн этгээд, иргэнд зээл, төлбөрийн болон банкны баталгаа гаргах;

/Энэ заалтыг 2003 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн хуулиар нэмсэн/

6/ хуулийн этгээд, иргэний дотоод, гадаадаас авах зээлийг дэмжих зорилгоор алт болон нөөц активыг барьцаалах;

/Энэ заалтыг 2003 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн хуулиар нэмсэн/

7/хуульд зааснаас бусад тохиолдолд хүн, хуулийн этгээд, тухайлсан банкинд эдийн засгийн буюу арилжааны давуу байдал бий болгосон, эдийн засгийн тодорхой салбарт зориулсан тэнцлийн болон тэнцлийн гадуурх аливаа хэлцэл, гүйлгээ хийх.

/Энэ заалтыг 2003 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

2. Монголбанк дараахь үйл ажиллагаа явуулах нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасанд хамаарахгүй:

1/ үүрэг гүйцэтгэх хугацаа нэг жилээс дээш хэтэрсэн тохиолдолд авлага барагдуулах зорилгоор боломжтой хугацааны дотор худалдах нөхцөлтэйгээр энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2,4-т заасан хөрөнгө, үнэт цаасыг худалдан авах;

/Энэ заалтад 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

2/ нийт дүнгээрээ өөрийн хөрөнгийн гурван хувиас хэтрүүлэхгүйгээр дангаараа хадгаламжийн даатгал, экспортын санхүүжилт, төлбөр харилцан суутгах үйл ажиллагаа, автоматжуулалт, банкны мэдээлэл боловсруулалт эрхэлдэг болон мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхтэй шууд холбоотой хуулийн этгээдийн хувьцааг эзэмших;

3/ өөрийн ажилтныг Төрийн албаны тухай хуульд зааснаас дордуулахгүйгээр ажиллах нөхцөл, баталгаагаар хангах, ажилтанд хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тусламж үзүүлэх, зардлыг гаргах.

/Энэ заалтад 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

4/ банкны төлбөрийн чадварт гарсан хүндрэл нь банкны тогтолцоо, төлбөр тооцооны тогтолцооны шинж чанартай эрсдлийг үүсгэж болзошгүй болсон гэж үзэж Монголбанк онцгой дэглэм тогтоосон.

/Энэ хэсгийг 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

5/санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Хадгаламжийн даатгалын корпорацид хуульд заасны дагуу зээл олгох.

/Энэ заалтыг 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ заалтад 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

6/татварын хууль тогтоомжийн дагуу арилжааны банкнаас мэдээлэл гаргуулах талаар шаардлага хүргүүлж, албадлагын арга хэмжээ авах.

/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Монголбанкнаас үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд болон банканд тавих хяналт

/Энэ бүлгийн нэрэнд 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

24 дүгээр зүйл. Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд болон банканд хяналт тавих Монголбанкны бүрэн эрх

/Энэ зүйлийн гарчигт 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

1. Монголбанк нь банкны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд банкны үйл ажиллагааг хянан шалгах, банканд албадлагын арга хэмжээ авах, үндэсний төлбөрийн системийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд хяналт тавих, арга хэмжээ авах эрхтэй.

/Энэ хэсгийг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

/Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2. Монголбанкны хяналт шалгалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн томилсон хянан шалгагч, хянагч хэрэгжүүлнэ.

/Энэ хэсэгт 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

3. Монголбанк энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан албадлагын арга хэмжээний хүрээнд онцгой дэглэм тогтоосон үед санхүү, банкны тогтолцоог эрсдэлээс хамгаалах зорилгоор зээл олгож болно.

/Энэ хэсгийг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/

25 дугаар зүйл. Монголбанкны хянан шалгагчийн бүрэн эрх

1. Монголбанкны хянан шалгагч банкны тухай хууль тогтоомж, төрийн мөнгөний бодлого болон Монголбанкны гаргасан дүрэм, журам, Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд банкнаас хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, шалгалт хийнэ. Хянан шалгагч нь улсын байцаагчийн эрх эдэлнэ.

/Энэ хэсэгт 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

2. Монголбанкны хянан шалгагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, тэдгээрт аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, төлбөр тооцооны төлөөлөгч, гэрээт төлөөлөгчийн болон банкны байр, тасалгаа, бусад холбогдох газарт нэвтрэн орох;

/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2/үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, тэдгээрт аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, төлбөр тооцооны төлөөлөгч, гэрээт төлөөлөгч, банкны данс бүртгэл, тайлан, тэнцэл, санхүүгийн баримт, тоног төхөөрөмж, шаардлагатай бусад зүйлд хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа

гаргуулж авах, асуулт тавьж, хариулт авах;

/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3/шаардлагатай магадлагаа, баримтын хуулбарыг төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, тэдгээрт аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, төлбөр тооцооны төлөөлөгч, гэрээт төлөөлөгч, банкны харилцагч, хэрэглэгч, иргэн, хуулийн этгээд, банк, санхүүгийн болон бусад байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

/Энэ заалтад 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

4/ хуулийн этгээд, иргэний банкны үйл ажиллагаатай холбогдох баримтыг шалгаж үзэх;

/Энэ заалтад 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

5/үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, тэдгээрт аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, төлбөр тооцооны төлөөлөгч, гэрээт төлөөлөгч, банк, түүний үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх;

/Энэ заалтад 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

6/ хууль тогтоомж зөрчсөн нь гэмт хэргийн шинжтэй байвал холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

7/Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй буюу зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санг бүрэн байгуулаагүй банкны гишүүнд ногдол ашиг хуваарилахыг зогсоох.

8/үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, тэдгээрт аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, төлбөр тооцооны төлөөлөгч, гэрээт төлөөлөгч, банкны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа тоног төхөөрөмж, программ хангамжид нэвтрэх, тэдгээрээс банкны үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээ, мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр хувилан авах.

/Энэ заалтыг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3.Монголбанкны хянан шалгагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь баталгаагаар хангагдана:

1/хянан шалгагчаас эрх хэмжээнийхээ хүрээнд тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл түүнийг биелүүлснээс банк, гуравдагч этгээдэд учирсан хохирлыг Монголбанк, түүний хянан шалгагч хариуцахгүй байх;

2/хянан шалгагчийг хуулиар хүлээлгэсэн албан үүрэгтэй нь холбоотойгоор заналхийлэх, сүрдүүлэх, амь бие, эрүүл мэндэд нь халдах аливаа хууль бус үйлдлээс хянан шалгагч, түүний гэр бүлийн гишүүдийг төр хамгаалах;

3/хянан шалгагч үүргээ гүйцэтгэх үедээ эрүүл мэнд нь хохирсон буюу амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний гэр бүлд Монголбанкнаас тогтоосон журмын дагуу тэтгэвэр, тэтгэмж, зардлыг олгох.

/Энэ заалтыг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/

25¹ дүгээр зүйл. Монголбанкны хянагч

1. Монголбанкнаас томилсон хянагч нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ томилогдсон хугацаандаа банкны өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэх болон удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, Монголбанкинд тайлагнах;

2/ банкны хувь нийлүүлэгчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд саналын эрхгүйгээр оролцох, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар зөвлөгөө өгөх;

3/ банк хууль тогтоомж зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах;

4/ энэ хуульд заасан хянан шалгагчийн бүрэн эрх.

/Энэ зүйлийг 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

25² дугаар зүйл. Монголбанкны хянан шалгагч, хянагчийн хяналт шалгалт хийхээс татгалзах үндэслэл

1. Монголбанкнаас томилсон хянан шалгагч, хянагч нь дараахь нөхцөлд хяналт шалгалт хийхээс татгалзана:

1/үндэсний төлбөрийн системийн тухайн оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, тэдгээрт аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, төлбөр тооцооны төлөөлөгч, банканд сүүлийн хоёр жилийн хугацаанд ажиллаж байсан;

/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2/гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн /хамт амьдардаггүй эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, хүргэн, бэр/ нь удирдах болон эрх бүхий албан тушаал /хувь нийлүүлэгч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, захирал, түүний орлогч, ерөнхий нягтлан бодогч ба түүнтэй адилтгах албан тушаал/-д ажилладаг банкинд.

/Энэ зүйлийг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/

25³ дугаар зүйл. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавих хяналтыг хэрэгжүүлэх

1. Монголбанк нь зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавих хяналтыг энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.

2. Монголбанк нь зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаатай холбогдон гарсан аливаа гомдлыг хянан шалгах, мэдээллийг засч, үнэн зөв болгох үүргийг холбогдох этгээдэд өгнө.

3. Монголбанк нь зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлтийг жил бүр авч хянана.

/Энэ зүйлийг 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

ТАВДУГААР БҮЛЭГ

Монголбанкны удирдлага

26 дугаар зүйл. Монголбанкны удирдлага

1. Монголбанкийг Улсын Их Хурлаас томилогдсон Ерөнхийлөгч толгойлж үйл ажиллагаагаа Улсын Их Хурлын өмнө хариуцан тайлагнана. Монголбанкны Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын даргын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

2. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нарыг Монголбанкны Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

3. Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг томилохдоо түүний эдийн засаг, банк, санхүү, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүй, ажлын туршлагыг харгалзана.

4. Монголбанкны Ерөнхийлөгчийн эзгүйд Тэргүүн дэд ерөнхийлөгч, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгчийн эзгүйд Дэд ерөнхийлөгч тус тус орлон ажиллана.

5. Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийн цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүрийг Улсын Их Хурал батална.

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

6. Улсын Их Хурал Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг дор дурдсан тохиолдолд албан тушаалаас нь чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ:

1/ арилжааны банкны хувьцаа эзэмшигч болсон;

2/ Монголбанкны эрх ашигт харш үйлдэл /эс үйлдэл/ гаргасан;

3/ биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзэж, уг албан тушаалаас чөлөөлж өгөхийг хүссэн;

4/ үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн;

5/ гэмт хэрэг үйлдсэнийг нь шүүх тогтоосон;

6/ ашиг сонирхлын бусад зөрчил үүссэн.

7. Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нар үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш нэг жилийн дотор банкны удирдах албан тушаалд ажиллахыг хориглоно.

8. Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа тэдгээрийг томилсон өдрөөс эхэлж, Улсын Их Хурлаас дараагийн Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг томилсноор дуусгавар болно.

/Энэ хэсгийг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/

27 дугаар зүйл. Монголбанкны хороо

1. Монголбанк нь Мөнгөний бодлогын хороо, Банкны хяналт шалгалтын хороотой байна.

2. Монголбанкны Ерөнхийлөгч энэ хуулийн 27³ дугаар зүйлийн 4, 27⁴ дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад асуудлаар зөвлөх эрх бүхий зөвлөл байгуулж болно.

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

27¹ дүгээр зүйл. Монголбанкны Хяналтын зөвлөл

1. Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын санал, зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын багц болон Монголбанкнаас санхүүгийн тайлангаа Улсын Их Хурал, олон нийтэд тайлагнаж, мэдээлж байгаа байдал, Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих эрх бүхий орон тооны бус Хяналтын зөвлөл ажиллана. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурал тогтооно.

2. Хяналтын зөвлөл нь төрийн мөнгөний бодлоготой холбоотой асуудлаар шийдвэр гаргахад аливаа хэлбэрээр оролцохгүй.

3. Хяналтын зөвлөл нь дарга, 6 гишүүнээс бүрдэнэ. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны санал болгосноор Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаатай томилж, чөлөөлнө.

4. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн нь банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн чиглэлээр мэргэшсэн, эдгээр салбарын ажлын дадлага туршлагатай, ёс зүйн хувьд төлөвшсөн, дараахь шаардлагыг хангасан хүн байна:

1/ Монгол Улсын 30-аас дээш насны иргэн, ял шийтгэлгүй;

2/ банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн мэргэжлээр магистрын болон түүнээс дээш зэрэг, цолтой.

5. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр банк, санхүү, эдийн засгийн салбарын асуудал хариуцсан төрийн байгууллагад өмнө нь ажиллаж байсан хүнийг томилж болно.

6. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, төрийн улс төрийн бусад албан тушаалтан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, төрийн захиргааны албан тушаалтан, Монголбанкны удирдах албан тушаалтныг томилж үл болно.

7. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь дараахь тохиолдолд чөлөөлж болно:

1/ биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзэж, уг ажлаас чөлөөлж өгөхийг хүссэн;

2/ үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн;

3/ гэмт хэрэг үйлдсэнийг нь шүүх тогтоосон;

4/ ашиг сонирхлын зөрчил үүссэн.

8.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг энэ хуулийн 27¹ дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд чөлөөлж үл болно.

9. Хяналтын зөвлөл нь энэ хуулийн 27¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийг дараахь хүрээнд хэрэгжүүлнэ:

1/ Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааг тогтоосон журмын дагуу авч хэлэлцэх;

2/ Монголбанкны дотоод аудитын газрын хянан шалгагч болон тус банкны санхүүгийн тайланд аудит хийсэн байгууллагын аудитортой харилцаж, санал солилцох;

3/ шаардлагатай гэж үзвэл Монголбанкны үйл ажиллагаа, менежментийн аливаа асуудал, тодорхой гүйлгээнд шалгалт, аудит хийлгэх санал гаргах;

4/ Монголбанк энэ хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хуралд тайлан, танилцуулга хүргүүлэх үед өөрийн үйл ажиллагааны тайланг хүргүүлж байх.

/Энэ зүйлийг 2003 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн хуулиар нэмсэн./

27² дугаар зүйл.Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл

1.Монгол Улсын санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахтай холбоотойгоор тогтолцооны шинжтэй эрсдэлийг илрүүлэх, хянах, бууруулах талаар хэлэлцэж, гишүүдийн үйл ажиллагааг уялдуулах чиг үүрэг бүхий Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана.

2.Зөвлөлийн бүрэлдэхүүнд Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирал орно.

3.Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байна.

4.Зөвлөлийн дүрмийг зөвлөлийн гишүүд хамтран батална.

5.Зөвлөл нь дараахь асуудлыг хэлэлцэнэ:

1/хууль тогтоомжийн хүрээнд харилцан солилцох мэдээ, мэдээлэл;

2/санхүүгийн тогтолцооны тогтвортой, тэнцвэрт байдалд нөлөөлж болзошгүй эрсдэлтэй, аюултай нөхцөл бий болсон тохиолдолд хамтарсан дүн, шинжилгээ хийх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох;

3/хямралаас сэргийлэх, хямралыг даван туулах үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт, зохион байгуулалт;

4/банкийг дахин хөрөнгөжүүлэх асуудал, түүний нөхцөл;

5/хуульд заасан бусад.

6.Зөвлөлийн ажлын албаны үүргийг Монголбанк хэрэгжүүлнэ.

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

27³ дугаар зүйл. Мөнгөний бодлогын хороо

1.Мөнгөний бодлогын хороо долоон гишүүнтэй байх бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаатай томилсон орон тооны бус дөрвөн гишүүнээс бүрдэнэ.

2.Орон тооны бус гишүүн дараахь шалгуурыг хангасан байна:

1/банк, санхүү, эдийн засгийн чиглэлийн их дээд сургууль, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагад мэргэжлээрээ 10-аас дээш жил, үүний таваас доошгүй жилд макро эдийн засгийн бодлого, судалгаа шинжилгээний чиглэлээр ажилласан туршлагатай;

2/Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа банкны эрх бүхий албан тушаалтан, банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд, холбогдох этгээд биш;

3/ашиг сонирхлын зөрчилгүй.

3.Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнийг уг хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөхөд энэ хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг нэгэн адил баримтална.

4.Мөнгөний бодлогын хороо дараахь асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэнэ:

1/төрийн мөнгөний бодлогын төсөл;

2/мөнгөний бодлогын хэрэгслийн хүүг тогтоох;

3/банкны заавал байлгах нөөцийн хэмжээ, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хувь, хэмжээг тогтоох.

5.Мөнгөний бодлогын хорооны үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байна.

6.Мөнгөний бодлогын хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргах бөгөөд санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

7.Мөнгөний бодлогын хороо жилд дөрвөөс доошгүй удаа хуралдана. Монголбанкны Ерөнхийлөгч, эсхүл хорооны гурваас доошгүй гишүүн санал гаргасан бол ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

8.Мөнгөний бодлогын хорооны шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд түүнд хуралдаан даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

27⁴ дүгээр зүйл.Банкны хяналт шалгалтын хороо

1.Банкны хяналт шалгалтын хороо нь банкинд хяналт тавих Монголбанкны бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараахь асуудлыг хэлэлцэж, зөвлөмж гаргана:

1/банкны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, банкны үйл ажиллагааг хуульд заасны дагуу зохицуулах, банкинд авах албадлагын арга хэмжээтэй холбоотой дүрэм, журам, заавар, аргачлал, бусад шийдвэрийн төсөл;

2/банкинд хийсэн хяналт шалгалтын тайлан;

3/банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хуульд заасны дагуу банк, Хадгаламжийн даатгалын корпорацид зээл олгох санал.

2.Банкны хяналт шалгалтын хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

28 дугаар зүйл. Монголбанкны Ерөнхийлөгчийн бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх баталгаа

1. Монголбанкны Ерөнхийлөгч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ Монголбанк, түүний салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг зохицуулан удирдах, Мөнгөний бодлогын хороог удирдах, төлөөлөх, ажиллах журмыг батлах;

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

2/хууль тогтоомж, Мөнгөний бодлогын хорооны тогтоолд үндэслэн, Банкны хяналт шалгалтын хорооны зөвлөмжийг харгалзан шийдвэр гаргах, арга хэмжээ авах;

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

3/ Улсын Их Хурлын Байнгын Хороо, Засгийн газар, холбогдох бусад байгууллагатай шууд харилцаж Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд өөрийн байр суурийг илэрхийлэх;

4/ энэ хуулийн гурав, дөрөвдүгээр бүлэгт тодорхойлсон Монголбанкны үйл ажиллагааг явуулахад шаардлагатай тохиолдолд Засгийн газар буюу банкны нэрийн өмнөөс өөрийн хөрөнгийн хэмжээнд багтаан зээл, төлбөрийн болон банкны баталгаа гаргаж болно.

/Энэ заалтад 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтыг 2003 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

5/ Монголбанкнаас үзүүлсэн ажил, үйлчилгээнд авах шимтгэл, олгосон зээлийн хүүгийн болон худалдан авах үнэт цаасны өгөөжийн хувь, хэмжээг тогтоох;

/Энэ заалтад 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

6/ Монголбанкны зохион байгуулалтын бүтцийг тогтоох;

/Энэ заалтыг 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

7/ банкны гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөхөд түүний мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвар зэрэг асуудлаар банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдтэй зөвшилцөх, шаардлагатай гэж үзвэл гүйцэтгэх захирлыг өөрчлөх тухай банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд зөвлөмж өгөх, банкны тухай хууль тогтоомжид заасан үндэслэлээр түдгэлзүүлэх, чөлөөлөх;

/Энэ заалтад 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

8/ төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай асуудлын талаар Засгийн газарт мэдээлэх, түүнтэй хамтарч шийдвэр гаргах;

9/ төрийн мөнгөний бодлогын хэрэгжилт, санхүүгийн зах зээлийн байдлын талаар Монголбанкны дүгнэлт, саналыг Улсын Их Хурал, Засгийн газарт улирал тутам танилцуулах;

10/ банкны шийдвэр банкны тухай хууль тогтоомж, Монголбанкны шийдвэртэй харшилж байвал түүнийг хүчингүй болгох;

11/ банкны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх арга хэмжээ авах;

12/ энэ хууль болон банкны тухай хууль тогтоомжийн биелэлтийг иргэн, хуулийн этгээдэд шалган танилцаж, хуульд заасан арга хэмжээг авах, биелэлтийг нь бүрэн хангуулах талаар даалгавар өгч, гүйцэтгүүлэх;

/Энэ заалтад 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

13/ банкны өөрийн хөрөнгийн зохистой хэмжээг хангах зорилгоор түүний бүтэц, хэмжээг өөрчлөх;

/Энэ заалтыг 1998 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

14/ Монголбанкны ажилтны ёс зүйн дүрмийг батлах;

/Энэ заалтыг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/

15/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

/Энэ заалтын дугаарыг 1998 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчилсөн/

/Энэ заалтын дугаарыг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчилсөн/

2. Монголбанкны Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь баталгаагаар хангагдана:

1/ төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд тохирсон цалин авч, шаардлагатай бусад хангамж эдлэх;

2/ уналга, холбооны хэрэгслээр хангагдах;

3/ гадаадад зорчих, байх хугацаанд дипломат эрх ямба, дархан эрх эдлэх;

4/ хуулиар тогтоосон бусад баталгаа.

3. Монголбанкны Ерөнхийлөгчийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол энэ тухай Улсын Их Хурлын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд Монголбанкны Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл ногдуулах, гэр орон, уналга, албан тасалгаа, биед нь нэгжлэг хийхийг хориглоно.

4. Монголбанкны Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд улс, орон нутгийн албан дайчилгаанаас чөлөөлөгдөнө.

5. Монголбанкны Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд хуулиар хариуцуулсан үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаалыг хавсран эрхэлж болохгүй.

6. Монголбанкны Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болоход түүнийг тодорхой ажил, албан тушаал эрхлүүлэх, тийм боломжгүй бол чөлөөлөгдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд амьдралын түвшинг нь бууруулахгүй байх арга хэмжээг Улсын Их Хурал авна.

28¹ дүгээр зүйл. Монголбанкны ерөнхий менежерийн бүрэн эрх

1. Монголбанкны ерөнхий менежер нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ Монголбанкны орон тоо, цалингийн санг тогтоох, ажилтныг ажилд томилох, чөлөөлөх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах;

2/ хуульд заасан бусад бүрэн эрх

/Энэ зүйлийг 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн/

29 дүгээр зүйл. Монголбанкны албан тушаалтны үйл ажиллагаанд хориглох зүйл

1. Монголбанкны албан тушаалтан дараахь үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

1/ иргэн, хуулийн этгээдийн ашиг сонирхлыг төлөөлөх;

/Энэ заалтад 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2/ өөртөө болон гэр бүл, төрөл төрөгсөд, ажил төрлийн болон бусад танил хүмүүст ашигтай давуу байдал бий болгох;

3/ банк, иргэн, хуулийн этгээдийн дансны үлдэгдэл, түүний гүйлгээ, тэдгээрийн хоорондын гэрээ, хэлцэл, банкны үйл ажиллагааны талаархи албан баримтыг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад мэдээлэх, танилцуулах;

4/ хууль тогтоомжоор хориглосон бусад үйл ажиллагаа.

2. Монголбанкны албан тушаалтан, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн нь албан үүргийнхээ дагуу олж авсан мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш ч задруулж үл болно.

/Энэ хэсгийг 2003 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3. Монголбанкны Зөвлөлийн гишүүн үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш нэг жилийн дотор банкны удирдах албан тушаалд ажиллахыг хориглоно.

/Энэ хэсгийг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Монголбанкнаас бусадтай харилцах

30 дугаар зүйл. Монголбанк Улсын Их Хуралтай харилцах

1. Монголбанк төрийн мөнгөний бодлого, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө, зээлийн байдлын талаар Улсын Их Хуралд улирал тутам танилцуулна.

2. Төрийн мөнгөний бодлогод тодорхойлсон үзүүлэлт нь Монголбанкны үйл ажиллагаанаас үл шалтгаалан эдийн засагт бий болсон нөхцөл байдлаас хамааран

хэрэгжээгүй тохиолдолд энэ талаар Улсын Их Хуралд танилцуулна.

3. Монголбанк санхүүгийн тайлангаа аудитын санал, дүгнэлт болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийн хамт жил бүр Улсын Их Хуралд танилцуулна.

/Энэ хэсэгт 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

4. Улсын Их Хурал Монголбанкны үйл ажиллагаа хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, энэ хуулийн 27¹ дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 4 дэх заалт, 30 дугаар зүйлийн 1-3 дахь хэсэгт заасан тайлан, танилцуулгатай танилцах бөгөөд ингэхдээ төрийн мөнгөний бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нь оролцохгүй.

/Энэ хэсгийг 2003 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

31 дүгээр зүйл. Монголбанкнаас Засгийн газартай харилцах

1. Монголбанкнаас Засгийн газартай харилцах үйл ажиллагаа нь энэ хуулийн 17, 18 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар зохицуулагдана.

2. Монголбанк Засгийн газраас хараат бус байна.

3. Засгийн газрын шийдвэр төрийн мөнгөний бодлогод харшилж байвал Монголбанк энэ талаар Засгийн газарт мэдэгдэнэ.

4. Монголбанкны Ерөнхийлөгч Монголбанк болон банкны үйл ажиллагаатай холбогдох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхэд зөвлөх эрхтэй оролцож болно.

5. Монголбанк мөнгөний статистик мэдээлэл болон жилийн тайлангаа Засгийн газарт хүргүүлнэ.

6. Засгийн газраас аливаа хэлбэрээр Монголбанкинд чиглэл өгөх, хуульд зааснаас бусад асуудлаар гэрээ, хэлцэл байгуулахыг хориглоно.

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

7. Монголбанк энэ хуулийн 15, 18 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд Засгийн газарт шууд болон шууд бусаар зээл олгох, Засгийн газрын урт, богино хугацаат үнэт цаасыг анхдагч, эсхүл хоёрдогч захаас болон шууд худалдан авахыг хориглоно.

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

31¹ дүгээр зүйл. Монголбанкнаас Санхүүгийн зохицуулах хороотой харилцах

1. Монголбанк нь Санхүүгийн зохицуулах хороо болон санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах гурван талт харилцан ойлголцлын санамж бичиг үйлдэнэ.

2. Монголбанк Санхүүгийн зохицуулах хороотой харилцахдаа энэ хуулийн 31¹ дүгээр зүйлийн 1-д заасан санамж бичгийг удирдлага болгоно.

/Энэ зүйлийг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

32 дугаар зүйл. Монголбанкнаас банктай харилцах

1. Монголбанк энэ хуулийн 12, 13, 16, 19, 20 дугаар зүйл болон банкны тухай хууль тогтоомжийн дагуу банктай харилцана.

2. Монголбанк хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа банкны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй.

33 дугаар зүйл. Монголбанкны гадаад харилцаа

1. Монголбанк төрийн мөнгөний бодлого, банкны үйл ажиллагааны талаар олон улсын банк, гадаадын банк, санхүү, зээлийн байгууллагатай Монгол Улсын ашиг сонирхолд нийцүүлэн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харилцаж ажиллана.

2. Монголбанк өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газар хоорондын хуралдаан, зөвлөлгөөнд Монгол Улсыг төлөөлөн оролцож болно.

3. Монголбанк зохих гэрээний дагуу гадаад улсын Засгийн газар, төв банк, Монгол Улс гишүүнээр нь элссэн олон улсын байгууллагад банкны үйлчилгээ үзүүлж болно.

4. Монголбанк олон улсын байгууллагад гишүүнээр элсэх, гадаадын банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллаж болно.

5. Монголбанк Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэхдээ Монгол Улс гишүүнээр нь элссэн олон улсын байгууллагатай хийх гүйлгээг энэ хуулийн 17 дугаар зүйлийн 3-т заасны дагуу гүйцэтгэнэ.

34 дүгээр зүйл. Монголбанкны мэдээлэл

1. Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх хэрэгслүүдэд гарсан өөрчлөлтийг тухай бүр нь, мөнгө, зээл, санхүүгийн зах зээлийн байдлыг улирал тутам нийтэд мэдээлж байна.

2. Монголбанк мөнгөний статистик мэдээллийг сар тутам гаргана.

3. Монголбанк энэ зүйлийн 1,2 дахь хэсэгт заасан мэдээллийг гаргахад шаардагдах мэдээ, тайлан, үзүүлэлтийг банк, иргэн, хуулийн этгээдээс гаргуулан авах эрхтэй.

/Энэ хэсэгт 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

4. Монголбанк хууль тогтоомжийн дагуу статистикийн мэдээлэл, тайланг хэвлэлд нийтлүүлж болно.

5. Хуульд өөрөөр заагаагүй бол Монголбанк Засгийн газартай байгуулсан гэрээ, хэлцлийн талаархи мэдээллийг тухай бүр нийтэд мэдээлнэ.

/Энэ хэсгийг 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/

6. Монголбанкны Ерөнхийлөгчийн нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан эрх зүйн акт болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг нийтэд мэдээлнэ.

/Энэ хэсгийг 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/

7. Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийн цалингийн хэмжээ нийтэд ил тод байна.

/Энэ хэсгийг 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/

ДОЛДУГААР БҮЛЭГ

Монголбанкны өөрийн хөрөнгө, орлогын хуваарилалт

35 дугаар зүйл. Өөрийн хөрөнгө

1. Монголбанк үйл ажиллагаагаа явуулахад хүлээх үүргийн баталгаа болгох зорилгоор өөрийн хөрөнгөтэй байна. Өөрийн хөрөнгө нь дүрмийн сан, ерөнхий нөөцийн сан, дахин үнэлгээний сан, бусад сан, цэвэр орлогоос бүрдэнэ.

36 дугаар зүйл. Дүрмийн сан.

1. Монголбанкны дүрмийн сан таван тэрбум төгрөгөөс доошгүй байх бөгөөд энэ хэмжээг гагцхүү хуулиар өөрчилнө.

/Энэ хэсэгт 2001 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2. Монголбанкны дүрмийн сангийн хэмжээг энэ зүйлийн 1 дэх хэсэг болон Монголбанкны саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

37 дугаар зүйл. Монголбанкны цэвэр орлогыг тодорхойлох

1. Монголбанкны санхүүгийн жилийн цэвэр орлогыг тодорхойлохдоо дараах зарчмыг баримтална:

1/ нийт орлого, зарлагыг зохих журмын дагуу хуримтлуулж тооцсон байх;

2/ чанаргүй зээл болон активын хорогдол, нийгмийн хөгжлийн арга хэмжээнд зориулан нөөцийн санг зохих журмын дагуу урьдчилан байгуулсан байх;

3/ зохих аргачлалын дагуу актив, пассивыг дахин үнэлсэн байх.

4/ гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн ханшийн зөрүүнээс үүссэн цэвэр ашгийг холбогдох санд хуваарилах;

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

5/ тухайн санхүүгийн жилд гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн ханшийн зөрүүнээс үүссэн цэвэр алдагдлыг дахин үнэлгээний сан болон ерөнхий нөөцийн сангаас хааж, хүрэлцэхгүй тохиолдолд зөрүүг хуримтлагдсан алдагдлын дансанд үлдээх.

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан орлого, зарлагыг хуримтлуулан тооцох, нөөцийн сан байгуулах, актив, пассивыг дахин үнэлэх журам, аргачлалыг Монголбанк тогтооно.

4. Актив, пассивыг дахин үнэлэхэд гарсан үнэлгээний цэвэр зөрүүг Монголбанкны цэвэр орлогын тооцоонд хамааруулахгүй.

/Энэ хэсгийг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

38 дугаар зүйл. Монголбанкны цэвэр орлогыг хуваарилах

1. Монголбанкны цэвэр орлогыг дор дурдсан дарааллаар хуваарилна:

1/ дөчөөс доошгүй хувийг ерөнхий нөөцийн санд шимтгэх;

2/ энэ хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу байршуулсан Засгийн газрын өрийн бичгийг буцааж төлбөр хийх;

/Энэ заалтыг 1998 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

3/ энэ хэсгийн 1-д заасан гүйлгээг хийсний дараа үлдэх хэсгийг улсын төсөвт шилжүүлэх.

/Энэ заалтад 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтад 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2-/Энэ хэсгийг 1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

38¹ дүгээр зүйл. Монголбанкны алдагдлыг нөхөх

1. Монголбанкны пассив нь актив хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд Засгийн газар үнэт цаас гаргах замаар уг зөрүүг нөхөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

/Энэ зүйлийг 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/

НАЙМДУГААР БҮЛЭГ

Монголбанкны бүртгэл, санхүүгийн тайлан

39 дүгээр зүйл. Монголбанкны санхүүгийн жил

Монголбанкны санхүүгийн жил нь хуанлийн жилтэй адил байна.

40 дүгээр зүйл. Монголбанкны санхүүгийн тайлан

1. Монголбанк олон улсын нягтлан бодох бүртгэлийн жишгийн дагуу санхүүгийн тайлан гаргана.

/Энэ хэсэгт 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

2. Монголбанк жил бүр санхүүгийн тайлангаа баталгаажуулна.

/Энэ хэсэгт 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

41 дүгээр зүйл. Санхүүгийн тайлангийн бүрдүүлбэр

1. Монголбанкны санхүүгийн тайлан нь тэнцэл, орлого, зарлагын тайлан, бусад холбогдох тайлан, нэмэлт тайлбар, тодруулгаас бүрдэнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад заалт

42 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

43 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 01 сарын 18 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

БАНКНЫ ТУХАЙ (Шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь банк байгуулах зөвшөөрөл олгох, түүнийг хүчингүй болгох, банкны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоох, банк болон банкны нэгдлийн үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрт албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Банкны тухай хууль тогтоомж

2.1. Банкны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

/Энэ хэсэгт 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд банкны тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2¹ дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

2¹.1. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд тусгайлан зааснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

/Энэ хэсгийг 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“банк” гэж хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээдийг;

3.1.2. “холбогдох этгээд” гэж доор дурдсан этгээдийг:

3.1.2.а.банкны нэгдлийн оролцогч;

3.1.2.б.банк, банкны нэгдлийн оролцогчийн хувьцааны тав ба түүнээс дээш хувийг эзэмшдэг хувь хүн, хуулийн этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд;

3.1.2.в.хувьцааных нь тав болон түүнээс дээш хувийг банк эзэмшдэг хуулийн этгээд;

3.1.2.г.хувьцааных тав болон түүнээс дээш хувийг банкны эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд эзэмшдэг хуулийн этгээд;

3.1.2.д.банк, банкны нэгдлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд;

3.1.2.е.банкны эрхлэх үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг банктай нэгдмэл сонирхолтой этгээд;

3.1.2.ё.эрх бүхий албан тушаалтных нь чиг үүргийг банкны эрх бүхий албан тушаалтан давхар гүйцэтгэдэг хуулийн этгээд;

3.1.2.ж.банкны саналын эрхтэй хувьцааны арав болон түүнээс дээш хувийг эрх бүхий албан тушаалтан нь эзэмшдэг хуулийн этгээд;

3.1.2.з.энэ заалтад заасан этгээдтэй нэгдмэл сонирхолтой бусад хувь хүн, хуулийн этгээд;

3.1.2.и.Монголбанкнаас холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

3.1.3.”банкинд бүтцийн өөрчлөлт хийх” гэж банкны бүтэц, зохион байгуулалт, хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцэд өөрчлөлт оруулах, түүнийг нэмэгдүүлэх буюу хорогдуулах зэргээр санхүүгийн байдлыг нь сайжруулж, алдагдлыг багасгах зорилгоор удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн болон холбогдох бусад цогцолбор арга хэмжээ авахыг;

3.1.4.“банкийг өөрчлөн байгуулах” гэж хууль тогтоомжид заасан журмын дагуу банкийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөхийг;

3.1.5.”банкны актив, пассив, өөрийн хөрөнгө” гэж олон улсын стандартад нийцүүлэн Монголбанкнаас баталсан нягтлан бодох бүртгэлийн журамд тодорхойлсон зүйлийг;

3.1.6. “банкны нэгдэл” гэж нэг хуулийн этгээд нь нөгөө хуулийн этгээдтэй холбогдох этгээд бөгөөд тэдгээрийн аль нэг нь банк байх тус тусдаа хуулийн этгээдийг;

3.1.7. “банкны нэгдлийн оролцогч” гэж энэ хуулийн 3.1.6-д заасан нөхцөлийг хангах хуулийн этгээдийг;

3.1.8. “нэгдсэн хяналт шалгалт” гэж банкны нэгдлийн оролцогчийн санхүүгийн үйл ажиллагаанд дангаар болон нэгдсэн байдлаар хяналт шалгалт хийхийг;

3.1.9. “өөрийн хөрөнгийн хүрэлцээ” гэж банк нь санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг;

3.1.10. “өөрийн хөрөнгийн шаардлага” гэж Монголбанкнаас тогтоосон, энэ хуулийн 3.1.9-д заасан өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хэмжээг;

3.1.11. “санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллага” гэж Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, тэдгээртэй адил чиг үүрэг бүхий гадаадын байгууллагыг;

3.1.12. “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж банкны хувьцааны тав ба түүнээс дээш хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа этгээд, эсхүл банкны бодлого, шийдвэр болон удирдлагад нөлөөлөхүйц хувьцаа эзэмшигчийг;

3.1.13. “банкны нэгж” гэж банкны салбар, төлөөлөгчийн газар, тооцооны төв, тооцооны касс зэрэг хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг.

3.1.14. “банкны нэгдлийн толгой компани” гэж банкны нэгдэл болон түүнд хамаарах оролцогчийг удирддаг компанийг;

3.1.15. “хэвийн бус үйл ажиллагаа” гэж Монголбанкнаас тогтоосон шалгуураар өндөр эрсдэлтэй гэж тооцсон банкны аливаа үйл ажиллагааг;

3.1.16. “банкны нөхцөлт удирдлага” гэж Монголбанкны хяналт шалгалтаар төлбөрийн чадвар муудаж байгаа нь тогтоогдсон бол тухайн банкны хэвийн үйл ажиллагааг хангах, санхүүгийн байдлыг нь сайжруулах зорилгоор банкны удирдлага, зохион байгуулалт, санхүү, үйл ажиллагаатай нь холбогдуулан хуульд заасны дагуу Монголбанкнаас авч хэрэгжүүлэх цогц арга хэмжээг;

3.1.17. “эцсийн өмчлөгч” гэж банкны үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг, эсхүл өөрийн энэ эрхээ бусдаар төлөөлүүлэн гүйцэтгүүлдэг, эсхүл банкны хувьцааг нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр дамжуулан эзэмшиж байгаа, тухайн хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан буюу банкны хувьцаа, үйл ажиллагаанаас үүсэх үр шимийг хүртэх эрх бүхий өмчлөгч этгээдийг;

3.1.18. “банкны үндсэн үйл ажиллагаа” гэж зах зээлд эзлэх хувь хэмжээ, үйл ажиллагааныхаа хэлхээ холбооноос хамаарч аливаа саатал нь банкны тогтолцооны тогтвортой байдлыг алдагдуулж, улсын эдийн засагт бодит сөрөг нөлөө үзүүлж болзошгүй банкны үйл ажиллагааны чиглэлийг;

3.1.19. “харилцан хамаарал бүхий этгээд” гэж хуулийн этгээдийн хөрөнгийн

өмчлөл, удирдлага, хяналт, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцдог, эдийн засгийн нэгдмэл ашиг сонирхолтой зэрэг шалгуураар хоорондоо харилцан хамааралтай гэж Монголбанкнаас тогтоосон хүн, хуулийн этгээдийг;

/Эдгээр заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

4 дүгээр зүйл. Банкны төрөл

4.1.Банк нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлөөр төрийн, хувийн болон холимог; үүсгэн байгуулагдсан хэлбэрээр хязгаарлагдмал хариуцлагатай, хувьцаат; үйл ажиллагаа явуулах хэлбэрээр нийтлэг ба төрөлжсөн байж болно.

5 дугаар зүйл.Банкны үйл ажиллагаанд үл нөлөөлөх

5.1.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Монголбанк, төрийн бусад байгууллага банкны үйл ажиллагаанд оролцохгүй бөгөөд удирдлага, шийдвэрт нь хууль бусаар нөлөөлж болохгүй.

5.2.Банк төрийн хүлээх үүргийг хариуцахгүй, өөртөө тухайлан хүлээгээгүйгээс бусад тохиолдолд банкны хүлээх үүргийг төр хариуцахгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

6 дугаар зүйл. Банкны эрхлэх үйл ажиллагаа

6.1.Банк Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа эрхэлнэ:

- 6.1.1.мөнгөн хадгаламж;
- 6.1.2.зээл;
- 6.1.3.төлбөр тооцооны үйлчилгээ;
- 6.1.4.өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах;
- 6.1.5.гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
- 6.1.6.үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
- 6.1.7.үнэт зүйл хадгалах;
- 6.1.8.гадаад төлбөр тооцоо хийх;
- 6.1.9.үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;
- 6.1.10.санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа;
- 6.1.11.зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах;
- 6.1.12.хууль тогтоомжоор хориглоогүй бөгөөд Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээ.

6.2.Банк Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа эрхэлнэ:

- 6.2.1.санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- 6.2.2.итгэлцлийн үйлчилгээ;
- 6.2.3.даатгалын зуучлагч;
- 6.2.4.андеррайтерын үйлчилгээ;
- 6.2.5.кастодиан;
- 6.2.6.факторингийн үйлчилгээ;

6.3.Банк энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авахдаа дараахь баримтыг бүрдүүлэн Монголбанкинд ирүүлнэ:

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

6.3.1.энэ хуулийн 6.1, 6.2-т заасан үйл ажиллагааны тодорхой төрлийг эрхлэх тухай хүсэлт;

6.3.2.тухайн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт;

6.3.3.ажлын байр, техник, тоног төхөөрөмжийн хангалт;

6.3.4.үйл ажиллагааг эрхлэхэд хэрэглэгдэх программ хангамж;

6.3.5.ажлын байр, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан талаархи баримт бичиг;

6.3.6.бизнес төлөвлөгөө.

6.4.Банкны нэгдлийн бусад оролцогч Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авах тухай бүр Санхүүгийн зохицуулах хороо Монголбанкны саналыг урьдчилан авна.

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

7 дугаар зүйл. Банкинд хориглох үйл ажиллагаа

/Энэ зүйлийн гарчигт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

7.1. Банк, энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2.1-6.2.6-д зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглох бөгөөд зээлийн барьцаалсан эд хөрөнгийг зээлийн төлбөр төлүүлэх, өр барагдуулах зорилгоор түр эзэмших болон өмчлөх, үйл ажиллагааны зардлаа нөхөх зориулалтаар хөлслүүлэх, түрээслүүлэх, худалдах үйл ажиллагаа үүнд хамаарахгүй.

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

7.2.Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хянан шалгах зөвлөл, ажилтанд хориглоно:

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

7.2.1. тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

7.2.2. Монголбанк, түүний хянан шалгагч, Монголбанкны улсын байцаагчийн эрх бүхий албан тушаалтан хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан;

/Энэ заалтад 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

7.2.3. шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл авлигатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шаардлагаар, түүнчлэн тагнуулын байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах шаардлагаар тэдгээрийн удирдлагын хүсэлтийг мөрдөгчийн саналыг прокурор зөвшөөрсөн;

/Энэ заалтад 2011 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

/Энэ заалтад 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

7.2.4. Монгол Улсын хуулийг зөрчсөн нь нотлогдсон бол олон улсын хуулийн байгууллага, Монгол Улстай эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан гадаад улсын Засгийн газар хүсэлт гаргасан;

7.2.5. Санхүүгийн зохицуулах хороо өөрийн олгосон тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор шаардсан болон тус хорооны байгуулсан гэрээ, харилцан ойлголцлын санамж бичгээр хүлээсэн үүргийн дагуу гадаад улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргасан.

7.2.6. хуульд заасны дагуу зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгсөн.

/Энэ заалтыг 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

7.2.7. эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн төлбөр төлөгчийн дансны мэдээлэл авахаар шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан хүсэлтийг шийдвэр гүйцэтгэх албаны дарга зөвшөөрсөн.

/Энэ заалтыг 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/

7.2.8. Гааль, татварын алба тодорхой харилцагчийн гааль, татварын өр төлбөрийг төлүүлэхээр хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан.

/Энэ заалтыг 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ заалтад 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

/Энэ заалтын “өр, төлбөрийг төлүүлэхээр” гэсний дараа “болон татварын хяналт шалгалт хийхээр” гэж 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

7.2.9. Хадгаламжийн даатгалын корпорацийн хянан шалгагч Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан.

/Энэ заалтыг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

7.2.10. Татварын зорилгоор мэдээлэл харилцан солилцох талаарх Монгол

Улсын олон улсын гэрээний дагуу татварын албаны шаардсан Татварын ерөнхий хуулийн 18.1.2-т заасан мэдээллийг.

/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

7.3.Банкнаас олгосон зээлийн талаархи банк хоорондын мэдээлэл, зээлийн мэдээллийн санд холбогдох хууль, гэрээнд заасны дагуу өгөх мэдээлэл, энэ хуулийн 37, 38 дугаар зүйлд заасан тайлан, мэдээлэл болон банк, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн хооронд солилцсон мэдээлэл энэ хуулийн 7.2-т заасан нууцад хамаарахгүй.

7.4.Энэ хуулийн 7.1-д зааснаас гадна банк дараахь үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

7.4.1.дангаараа буюу бусадтай хамтран санхүүгийн зах зээл дээр ноёрхох, өөр хоорондоо, эсхүл гуравдагч этгээдэд шударга бусаар давуу байдал бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах, ийм үйл ажиллагаанд оролцох;

7.4.2.банк, банкны нэгдлийн оролцогчийн өмнө зээл болон бусад хэлбэрээр хүлээсэн санхүүгийн үүрэг нь анх тохиролцсон гэрээнээс хугацаа хэтэрсэн тохиолдолд тухайн санхүүгийн үүрэг хүлээгч, түүнтэй холбогдох этгээдэд андеррайтерын үйлчилгээ үзүүлэх;

7.4.3.андеррайтерын үйлчилгээ үзүүлэхдээ үнэт цаас гаргагч болон түүнтэй холбогдох этгээдэд зээл, түүнтэй адилтгах санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, баталгаа, баглан даалт гаргах;

7.4.4.банкны нэгдлийн оролцогчийн андеррайтер хийж байгаа үнэт цаасыг худалдан авах;

7.4.5.андеррайтер хийж байгаа үнэт цаасаа банкны нэгдлийн оролцогчид шууд буюу шууд бус хэлбэрээр худалдах, түүнтэй холбогдсон аливаа үйл ажиллагаа явуулах;

7.4.6.банк болон банк бус санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлтэй хуулийн этгээдэд андеррайтерын үйлчилгээ үзүүлэх;

7.4.7.энэ хуулийн 19.1-д заасан шаардлагыг хангаагүй хуулийн этгээд, иргэн тухайн банкинд хүлээсэн санхүүгийн өр төлбөрөө барагдуулахаас өөрөөр аливаа гүйлгээг Монголбанк зөвшөөрснөөс бусад тохиолдолд хийх;

7.4.8.өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх;

7.4.9.улс төрийн аливаа нам, эвсэлд хандив өгөх.

8 дугаар зүйл.Банкны зар сурталчилгаа

8.1.Банкнаас хийх зар сурталчилгаа нь түүний тухайн үеийн үйл ажиллагааг үнэн зөв тусгасан, хууль тогтоомжид нийцсэн байна.

8.2.Монголбанк нь банкны зар сурталчилгааг дараахь агуулгатай гэж үзвэл хориглоно:

8.2.1. тухайн банкнаас нийтэд мэдээлсэн санхүүгийн тайлан нь түүний санхүүгийн бодит байдалтай зөрчилдөж байвал;

8.2.2. хууль тогтоомжид нийцээгүй.

9 дүгээр зүйл. Мөнгөн хадгаламж

9.1. Банк Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид “иргэн” гэх/, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгийг тэдгээрийн хүсэлтийн дагуу гэрээний үндсэн дээр хадгалж, түүнд хүү төлж болно.

9.2. Банкинд мөнгөн хөрөнгө хадгалах болон хадгаламжийн даатгалд даатгуулахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

10 дугаар зүйл. Зээл

10.1. Банк иргэн, хуулийн этгээдэд өөрийн болзол, нөхцөлийн дагуу зээл олгож болох бөгөөд зээлийн хүүг өөрөө тогтооно.

10.2. Банк хугацаандаа төлөгдөөгүй зээл, хүүгийн төлбөрт зээлдэгчийн өмчлөлд байгаа эд хөрөнгө, хувьцаа, түүний ногдол ашгийг гэрээ болон шүүхийн шийдвэрийн үндсэн дээр авч болох бөгөөд энэ нь энэ хуулийн 17.4-т заасанд хамаарахгүй.

10.3. Банкны зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

11 дүгээр зүйл. Төлбөр тооцооны үйлчилгээ

11.1. Банк өөрийн харилцагчид төлбөр тооцооны бүх төрлийн үйлчилгээг түүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үзүүлнэ.

11.2. Банк харилцагчийн даалгавраар түүний харилцах дансны үлдэгдэлд багтаан мөнгөн хөрөнгийг шилжүүлэх гүйлгээ хийх бөгөөд шүүх болон банкны эрх хүлээн авагчийн шийдвэр, эсхүл үл маргах журмаар төлөх тухай харилцагчийн гарын үсэг бүхий гэрээ, төлбөрийн баримтыг үндэслэн гүйлгээ хийснийг харилцагчийн даалгавраар гүйлгээ хийсэнд тооцно.

11.3. Төлбөр тооцооны үйлчилгээний хөлсийг банк өөрөө тогтооно.

11.4. Банк нь банк хоорондын гүйлгээгээ Монголбанк дахь харилцах дансаараа дамжуулан хийнэ. Монголбанкнаас зөвшөөрсөн тохиолдолд Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасны дагуу төлбөр тооцооны төлөөлөгч дээр байршуулсан дансаар гүйлгээгээ дамжуулж болно.

/Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

11.5. Банкны төлбөр тооцооны үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

11.6. Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын орлогыг олгох үйлчилгээнд төлбөр тооцооны үйлчилгээний хөлс тооцохгүй.

/Энэ хэсгийг 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/

11.7. Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлд заасан албан татвар, төлбөр, хураамж төвлөрүүлэх гүйлгээнээс арилжааны банк үйлчилгээний хөлс тооцохгүй.

/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2020 оны 01

дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

12 дугаар зүйл.Баталгаа, батлан даалт гаргах

12.1.Банк энэ хуулийн 17.1-17.3-т заасан хязгаарлалтын хүрээнд гуравдагч этгээдэд гэрээний дагуу баталгаа, батлан даалт гаргаж болно.

13 дугаар зүйл.Үнэт зүйлийн хадгалалт

13.1.Банк иргэн, хуулийн этгээдийн үнэт зүйлийг /хадгалуулагчийн хувьд үнэт зүйл/ хадгалах үйлчилгээг эрхлэхдээ хадгалалтын гэрээний нөхцөлийг хууль тогтоомжид нийцүүлэн өөрөө тогтооно.

14 дүгээр зүйл.Гадаад валютын төлбөр тооцоо

14.1.Гадаад валют, түүгээр илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авахтай холбогдсон банкны үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

15 дугаар зүйл.Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах

15.1.Энэ хуулийн 17.4-т заасан хязгаарлалтын хүрээнд хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдах үнэт цаас гаргах, барьцаалах, худалдах, худалдан авахтай холбогдсон банкны үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

15.2.Банк мөнгөний зах зээл дээр арилжаалагдах нэг жил хүртэлх хугацаатай үнэт цаасыг Монголбанкны зөвшөөрлөөр гаргах буюу худалдаж, худалдан авч, барьцаалж болох бөгөөд энэ нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд хамаарахгүй.

16 дугаар зүйл.Банкинд тавих шаардлага

16.1.Банк дараахь шаардлагыг хангаж ажиллана:

16.1.1.заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу зохих хэмжээ, хэлбэрээр хангахын зэрэгцээ хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх;

16.1.2.өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу биелүүлэх;

16.1.3.харилцагч хэд хэдэн банкаар үйлчлүүлэхэд хязгаарлалт тавихгүй байх;

16.1.4.харилцагчийн зөвшөөрөлгүйгээр харилцах данснаас нь зарлагын гүйлгээ хийхгүй байх ба энэ заалт нь хууль тогтоомжид заасан хугацаанд татварын өрөө барагдуулаагүй татвар төлөгчийн харилцагч банк дахь дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс татварын өрийг үл маргах журмаар гаргуулахад хамаарахгүй;

16.1.5.тухайн банкнаас үзүүлэх үйлчилгээний урьдчилсан нөхцөл болгож тухайн банкны нэгдлийн оролцогч, өөрийн салбар, төлөөлөгчийн газар болон бусад үйлчилгээгээр үйлчлүүлэхийг харилцагчаас шаардахгүй байх.

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

16.2.Банк өөрийн үйл ажиллагааны тухай мэдээллийг Монголбанкнаас тогтоосон бүртгэлийн зарчим, жишгийн дагуу харилцагч этгээдэд үнэн зөвөөр гаргаж өгнө.

17 дугаар зүйл.Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалт

17.1.Банкнаас аливаа этгээд, түүнтэй холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалт, бусад хэлцлийн нийлбэр дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй.

17.2.Банкнаас гаргах баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байна.

17.3.Банкнаас холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалт, бусад хэлцлийн дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн таван хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас тус тус хэтэрч болохгүй бөгөөд ийнхүү олгохдоо дараахь шаардлагыг баримтална:

17.3.1.зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалт, бусад хэлцэлд тавих шаардлага, хүү, нөхцөл нь тухайн банкны үйл ажиллагааны ердийн шаардлага, хүү, нөхцөлөөс хөнгөлөлттэй байж болохгүй;

17.3.2.тухайн банкны хувьцааг барьцаалан зээл олгохгүй, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө үүсгэхгүй, баталгаа, батлан даалт гаргахгүй байх;

17.3.3.олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгийн төлөгдөх хугацаа болон гаргасан баталгаа, батлан даалт, бусад хэлцлийн дуусах хугацаа нь зургаагаас дээш сараар хэтэрсэн, эсхүл тухайн этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийт дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн таван хувиас хэтэрсэн бол уг этгээд банкны удирдах үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцохгүй байх.

17.4.Энэ хуулийн 17.5-д зааснаас бусад тохиолдолд банкны худалдан авах үнэт цаасны нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй бөгөөд нэг компанийн гаргасан хувьцааны 10 хувиас дээшгүй байна. Үүнд Засгийн газар, Төв банкны үнэт цаас, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн хувьцаа хамаарахгүй.

17.5.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авах нийт дүн банкны өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтэрч болохгүй.

17.6.Монголбанк энэ хуулийн 17.1-д заасан хязгаарлалтыг тооцохдоо олон улсын зээлжих зэрэглэлийг тогтоогч байгууллагын “А”-аас доошгүй үнэлгээ бүхий санхүүгийн байгууллагаас гаргасан баталгаа, батлан даалттай, тэдгээртэй эрсдэл хуваах хэлцлийн дагуу баталгаажсан активыг хамруулахгүй байж болно.

17.7.Энэ хуулийн 17.1-17.5-д заасан хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журмыг Монголбанк батална.

17.8.Банк үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш нэг жилийн хугацаанд банкны

хувьцаа эзэмшигчид зээл олгохыг хориглоно.

17.9.Банкнаас холбогдох этгээдтэй хийх хэлцэл нь банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй байж болохгүй бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд холбогдох хуульд заасан шаардлага, журмыг баримтална.

17.10.Энэ хуулийн 17.8, 17.9 -д заасныг зөрчсөн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

17.11.Банк энэ хуулийн 17.1-17.5-д заасан хязгаарлалтыг хэтрүүлсэн бол Монголбанк уг хэтрүүлсэн дүнг тухайн банкны өөрийн хөрөнгөөс хасаж тооцно.

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БАНК БАЙГУУЛАХ, БАНКИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ

18 дугаар зүйл.Банк үүсгэн байгуулах

18.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд /төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд/, төрийн бус байгууллага, тэдгээртэй холбогдох этгээдээс бусад хуулийн этгээд, иргэн банк үүсгэн байгуулж болох бөгөөд энэ нь Засгийн газар банк үүсгэн байгуулахад хамаарахгүй.

18.2.Банк, түүний салбар байгуулах, гадаад улсад банк, банкны салбар байгуулахад Монголбанкны зөвшөөрөл авна.

19 дүгээр зүйл.Банк үүсгэн байгуулагчид тавих шаардлага

19.1.Банк үүсгэн байгуулагч дараахь шаардлагыг хангасан байна:

19.1.1.банк үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд бол тухайн улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлан, мэдээгээ жил бүр, эсхүл түүнээс богино хугацаанд тайлагнадаг байх;

19.1.2.төрийн эрх бүхий байгууллагаас тухайн хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалт хийдэг байх;

19.1.3.санхүүгийн тайлан, мэдээгээ Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагаар, эсхүл Монголбанкны хүлээн зөвшөөрсөн, олон улсад нэр хүнд бүхий аудитын байгууллагаар жилд нэгээс доошгүй удаа баталгаажуулдаг байх;

19.1.4.банкны хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгө нь тухайн этгээд, түүнтэй холбогдох этгээдийн санхүүгийн тайлангаар тодорхойлогдсон, хууль ёсны үйл ажиллагааны орлого байх;

19.1.5.энэ хуулийн 36¹ дүгээр зүйлд заасан шалгуурыг хангасан байх.

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

20 дугаар зүйл.Банк үүсгэн байгуулахад бүрдүүлэх баримт бичиг

20.1.Банк үүсгэн байгуулагч болон банкны хувьцаа эзэмшигч нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16.1 дэх хэсэг,20 дугаарзүйлд заасан баримт бичгээс гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсэгт 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

20.1.1.банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл;

20.1.2.банк үүсгэн байгуулах гэрээ /нэг үүсгэн байгуулагчтай бол хамаарахгүй/;

20.1.3.үүсгэн байгуулах банкны дүрэм;

20.1.4.банк байгуулах эдийн засгийн үндэслэл;

20.1.5.үүсгэн байгуулагч болон тухайн банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн нэр, хаяг, тэдгээрийн холбогдох этгээдийн үйл ажиллагааны сүүлийн гурван жилийн, энэ хуульд заасан шаардлагыг хангасан аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

20.1.6.Монголбанкнаас баталсан маягтын дагуу бүрдүүлж өгсөн банкны эрх бүхий албан тушаалтан, боловсон хүчин, техник, тоног төхөөрөмж, ажлын байрны талаархи тодорхойлолт;

20.1.7.банкинд хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасны дагуу бүрдүүлж өгсөн баримт бичгийг дутуу буюу тодорхой бус гэж үзвэл Монголбанк эдгээр баримт бичгийн хүрээнд нэмэлт материал шаардах эрхтэй бөгөөд банк үүсгэн байгуулагч, банкны хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтантай холбоотой асуудлаар хуулийн байгууллагаас тодорхойлолт, лавлагаа гаргуулан авч болно.

/Энэ хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

20.3.Банк үүсгэн байгуулагч, банкны хувьцаа эзэмшигч, тэдгээртэй холбогдох этгээд нь энэ хуульд заасан шаардлагыг хангах нотлох баримт бичгийг тухайн этгээд бүртгэгдсэн улсын эрх бүхий төрийн байгууллага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар нотлуулсан байх бөгөөд эдгээр баримт бичиг нь банк үүсгэн байгуулах баримт бичгийн бүрэлдэхүүн хэсэг болно.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

20.4.Банк үүсгэн байгуулах, банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах, банкны хувьцааг эзэмшихэд зөвшөөрөл олгох харилцааг энэ хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн Монголбанкны журмаар зохицуулна.

21 дүгээр зүйл.Банкны дүрэм

21.1.Банкны үйл ажиллагаа эрхлэх этгээдийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2-т зааснаас гадна дараахь зүйлийг тусгана:

21.1.1.хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;

21.1.2.банкны удирдлага, зохион байгуулалтын бүтэц;

21.1.3.хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам.

/Энэ заалтад 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

21.2.Банкны дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг энэ тухай шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор Монголбанкинд бүртгүүлнэ.

22 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалттай банк, банкны салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд тавих шаардлага

22.1.Гадаадын хөрөнгө оруулалттай банк, банкны салбар, төлөөлөгчийн газар байгуулах хуулийн этгээд энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангахын зэрэгцээ мөн хуулийн 20 дугаар зүйлд зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлж Монголбанкинд өгнө:

22.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр банк, банкны салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай гадаадын банк, санхүүгийн байгууллагын гаргасан шийдвэр;

22.1.2.харьяалах улсын эрх бүхий төрийн байгууллагын Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн шийдвэр;

22.1.3.холбогдох бусад хууль тогтоомжид заасан баримт бичиг.

22.2.Хуульд заасны дагуу байгуулагдсан гадаадын хөрөнгө оруулалттай банк, банкны салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд тавих нэмэлт шаардлагыг Монголбанкны журмаар тогтооно.

23 дугаар зүйл.Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгох

23.1.Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл, бусад баримт бичгийг Монголбанк хянахдаа дараахь шаардлага хангасан эсэхийг тогтооно:

23.1.1.банкны үйл ажиллагааг тогтвортой, үр ашигтай явуулахад хүрэлцэхүйц хэмжээний мөнгөн хөрөнгөөр бүрдүүлсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй эсэх;

23.1.2.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, банкны гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтны мэдлэг, боловсрол болон туршлага нь банкны үйл ажиллагааг үр ашигтай, шударгаар явуулахад хангалттай эсэх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь энэ хуулийн 32.1, 33.3, 34.2-т заасан шалгуурыг тус тус хангасан эсэх;

23.1.3.тухайн банк үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх эсэх;

23.1.4.банкинд хувь нийлүүлэх мөнгөн хөрөнгө нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан, хууль ёсны үйл ажиллагаанаас бий болсон хөрөнгө болохыг нотлох хангалттай баримт бичиг бүрдүүлсэн эсэх.

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

23.1.5.банк байгуулах нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх

үйл ажиллагаатай аливаа байдлаар холбоотой эсэх, эсхүл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг нэмэгдүүлэх эсэх.

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

23.2.Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг Монголбанк энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, мөн хуулийн 20 дугаар зүйлд заасан баримт бичгийн бүрдлийг хянасны эцэст хүлээн авах бөгөөд хэрэв нэмэлт материал шаардлагатай бол уг нэмэлт материалыг бүрдүүлж өгсөн өдрийг өргөдөл хүлээн авсан өдөрт тооцно.

23.3.Монголбанк нь банк байгуулах тусгай зөвшөөрөл олгох эсэх шийдвэрийг энэ хуулийн 20.1-д заасан өргөдлийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор гаргаж, энэ тухай банк үүсгэн байгуулагчид гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

23.4.Банк нь банк байгуулах тусгай зөвшөөрөл авснаас хойш тухайн зөвшөөрлөөр авсан үйл ажиллагаагаа хэвийн явуулсан тохиолдолд Монголбанк энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг зохих журмын дагуу өгч болно.

24 дүгээр зүйл.Банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах

24.1.Монголбанк дараахь нөхцөлд банк байгуулах тусгай зөвшөөрөл, банкны хувьцааг эзэмших зөвшөөрөл олгохгүй:

24.1.1.энэ хуулийн 18-22, 23.1, 36 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй;

/Энэ заалтад 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

24.1.2.банкны дүрэм хууль тогтоомжтой зөрчилдсөн;

24.1.3.байгуулах банк нь шаардлага хангахуйц хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлэх боломжгүй нь тогтоогдсон, хувь нийлүүлэх хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт бичгийг шаардлагын дагуу бүрэн гүйцэд ирүүлээгүй болон бүрдүүлсэн баримт бичиг нь хуурамч, хувьцааны төлбөрийг зээлийн эх үүсвэрээр бүрдүүлсэн, тухайн банкны эрх бүхий албан тушаалтнаар ажиллах этгээд энэ хуульд заасан шалгуурыг хангаагүй;

24.1.4.холбогдох бусад хууль тогтоомж, санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрт нийцээгүй.

24.1.5.банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхгүй бол хамгийн их хувьцаа эзэмшиж байгаа этгээд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, нийт дүн, хэмжээний талаархи мэдээллийг Монголбанкинд ирүүлээгүй.

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

25 дугаар зүйл.Банкийг бүртгэх

25.1.Энэ хуулийн 18-22 дугаар зүйлд заасан журмын дагуу Монголбанкнаас

тусгай зөвшөөрөл авсан банк улсын бүртгэлд бүртгүүлнэ.

25.2.Банкны салбар байгуулахад Монголбанкнаас зөвшөөрөл авах бөгөөд түүнийг тусгайлан бүртгэхгүйгээр толгойлох банкных нь зөвшөөрөлд тэмдэглэнэ.

25.3.Банкийг улсын бүртгэлд бүртгэсэн тухай нийтэд мэдээлнэ.

26 дугаар зүйл.Банкны нэр

26.1.Банкны нэр нь түүний оноосон нэр болон “банк” гэсэн үгнээс бүрдэнэ.

26.2.Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй байгууллага “банк” гэсэн нэр хэрэглэхийг хориглоно.

26.3.Банкны нэр, байршлыг Монголбанкны зөвшөөрөлтэйгээр өөрчилнө.

26.4.Банкны нэгж нь толгойлох банкны оноосон нэрийг хэрэглэнэ.

27 дугаар зүйл.Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

27.1.Монголбанк нь банк байгуулах тусгай зөвшөөрлийг дараахь үндэслэлээр хүчингүй болгож нийтэд зарлана:

27.1.1.хуульд заасны дагуу банкийг татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;

27.1.2.энэ хуулийн 67.2-т заасан үндэслэл бий болсон;

27.1.3.банк байгуулахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь банкийг бүртгүүлснээс хойш илэрсэн;

27.1.4.банкийг улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш нэг жилээс дээш хугацаанд банкны үйл ажиллагаа эрхлээгүй;

27.1.5.банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн;

27.1.6.банк энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй, шаардлагыг биелүүлээгүй нь банкны үйл ажиллагаа, төлбөрийн чадварыг алдагдуулахад хүргэх ноцтой нөхцөл байдал үүсгэсэн.

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

27.1.7.энэ хуулийн 7.2.8, 7.2.10-т заасан харилцагчид хамаарах мэдээллийг татварын албанд гаргаж өгөөгүй үйлдэл нь харилцагчийн татвар төлөхөөс зайлсхийх, зугтах нөхцөл болсон нь тогтоогдож, энэ зөрчил хоёр ба түүнээс дээш удаа давтагдсан бол.

/Энэ заалтыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

27.2.Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор банкны үйл ажиллагаа эрхлэх талаар урьд олгосон бүх зөвшөөрөл хүчингүй болно.

27.3.Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон буюу зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд дахин зөвшөөрөл хүсэх тухай баримт бичгийг нэг жилийн дотор Монголбанк хүлээж авахгүй.

27.4.Энэ хуулийн 27.1-т зааснаас бусад үндэслэлээр Монголбанк банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд энэ талаархи Монголбанкны

шийдвэрийг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөл 30 хоногийн дотор банкны хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах бөгөөд тухайн хурлаас банкныг татан буулгах тухай шийдвэр гаргана.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

28 дугаар зүйл. Банкныг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгах үндсэн нөхцөл

/Энэ зүйлийн гарчигт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

28.1. Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд банкныг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулж, татан буулгаж болно.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

28.2. Банкныг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай шийдвэрт өөрчлөн байгуулах, татан буулгах комисс, банкны бүртгэлд байгаа эд хөрөнгө, үнэт зүйлсийг нягтлан шалгах эрх бүхий хянан шалгах комисс, тэдгээрийн бүрэлдэхүүнийг томилох болон аудитыг сонгох тухай тусгасан байна.

28.3. Банкныг өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл авахад хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш гурав хоногийн дотор дор дурдсан баримт бичгийг Монголбанкинд хүргүүлнэ:

28.3.1. банкныг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;

28.3.2. банкныг өөрчлөн байгуулах, татан буулгах шаардлага, хэлбэр, нөхцөл, хугацааг заасан баримт бичиг, тухайн банкнаас үйл ажиллагаагаа дуусгавар болгохтой холбогдуулан авах арга хэмжээ, тэдгээрийн хугацаа, үе шат, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

28.3.3. банкныг өөрчлөн байгуулсны үр дүнд байгуулагдах хуулийн этгээдийн зохион байгуулалт эрх зүйн хэлбэр, байршил, банкны эрхлэх үйл ажиллагааны төрөл, бизнес төлөвлөгөө, өөрчлөн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, тайлан тэнцлийн төсөөллийн тухай шаардлагатай бусад мэдээлэл;

28.3.4. банкныг өөрчлөн байгуулснаас гарах санхүүгийн үр дүнгийн тооцоо, өөрчлөн байгуулсны дараа байгуулагдах банкны эхлэлтийн тайлан тэнцэл.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

28.4. Монголбанк нь банкныг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор уг асуудлыг шийдвэрлэж, нийтэд мэдээлнэ.

28.5. Монголбанк энэ хуулийн 28.3-т заасан баримт бичгийг хүлээн авсан өдрийг тооцохдоо энэ хуулийн 23.2-т заасныг баримтална.

28.6. Монголбанкнаас банкныг өөрчлөн байгуулах зөвшөөрөл олгосны дараа банкныг өөрчлөн байгуулах ажиллагаа эхэлнэ.

28.7. Банк түүнийг өөрчлөн байгуулах талаар гарсан шийдвэрийг хадгаламж эзэмшигч, харилцагч, зээлдэгч нарт Монголбанкнаас зөвшөөрөл авснаас хойш гурав хоногийн дотор мэдэгдэнэ.

28.8.Банкийг нийлүүлэх, нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулахад Монголбанк зуучлагчийн үүрэгтэй оролцож болно.

28.9.Дараахь нөхцөл байдлын аль нэг нь бүрдсэн тохиолдолд Монголбанк нь банкныг өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгохоос татгалзана:

28.9.1.энэ хуулийн 28.3-т заасан баримт бичгийг дутуу бүрдүүлсэн;

28.9.2.энэ хуулийн 28.3-т заасан баримт бичиг нь хууль тогтоомж зөрчсөн;

28.9.3.энэ хуулийн 19, 20, 36 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй;

28.9.4.харилцагчийн эрх ашиг, банк, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлнө гэж Монголбанк үзсэн.

28.10.Монголбанк банкныг өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгохоос татгалзсан бол хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг хүчингүй болсонд тооцно.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

28.11.Монголбанкны зөвшөөрлийг үндэслэн хууль тогтоомжид заасан журмын дагуу банк татан буугдана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БАНКНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

29 дүгээр зүйл.Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал

/Энэ зүйлийн гарчигт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

29.1.Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд нэг хувьцаа эзэмшигчтэй банкны хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигч өөрөө, төрийн өмчит банкны хувьд Засгийн газар, түүнээс эрх олгосон этгээд тус тус хэрэгжүүлнэ.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

29.2.Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

29.2.1.банкны дүрэм батлах, уг дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;

29.2.2.хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх;

/Энэ хэсгийн "29.2.3"-г 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар хассан бөгөөд 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

29.2.4.банкныг өөрчлөн байгуулах;

29.2.5.банкныг татан буулгах;

29.2.6.банкны жилийн үйл ажиллагааны талаархи төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг хэлэлцэж батлах;

29.2.7.аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаархи төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

29.2.8.энэ хуулийн 32.3-т заасан Монголбанкны мэдэгдлийг хүлээн авсны үндсэн дээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, чөлөөлөх;

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

29.2.9.төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийг тогтоох, хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоох;

29.2.10.банкны хянан шалгагч /хянан шалгах зөвлөл/-ийн асуудлыг Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн дагуу зохицуулах.

29.3.Энэ хуулийн 19, 36 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй хуулийн этгээд, иргэний банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт өгсөн саналыг хүчингүйд тооцох бөгөөд энэ тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчдийн саналын олонхиор хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг хүчин төгөлдөр болсонд тооцно.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

29.4.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол банкны хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, мэдээлэл хүргэх, шийдвэр хүчин төгөлдөр болох зэрэг бусад асуудлыг Компанийн тухай хуулийн 60-74 дүгээр зүйлээр зохицуулна.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

30 дугаар зүйл. Монголбанкны санаачилгаар банкны хувь хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай

/Энэ зүйлийн гарчигт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

30.1.Банкны тухай хууль тогтоомжийн дагуу албадлагын арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа тохиолдолд шаардлагатай гэж үзвэл банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Монголбанк, түүний томилсон бүрэн эрхт төлөөлөгч зарлан хуралдуулж болно.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

30.2.Банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг хурал хуралдахаас 30 хоногийн өмнө зарлах ба банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлыг энэ хугацаанаас өмнө зарлан хуралдуулж болно.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

30.3.банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлсэн тохиолдолд бүрэн эрхт төлөөлөгчийн саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

/Энэ хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

30.4.Монголбанк эрх хүлээн авагч томилсон тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахгүй.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

31 дүгээр зүйл.Банкны төлөөлөн удирдах зөвлөл

31.1.Банк төлөөлөн удирдах зөвлөлтэй байна.

31.2.Хувьцаат компанийн хэлбэрээр байгуулагдсан банкны төлөөлөн удирдах зөвлөл ес ба түүнээс дээш, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр байгуулагдсан банкны төлөөлөн удирдах зөвлөл тав ба түүнээс дээш гишүүнтэй байна.

31.3.Банкны төлөөлөн удирдах зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.3.1.банкны стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах;

31.3.2.Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцөн банкны гүйцэтгэх удирдлагыг томилох;

31.3.3.гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

31.3.4.хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

/Энэ заалтад 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

31.3.5.энэ хуулийн 29.2.6, 29.2.7-д заасан асуудлаар дүгнэлт гарган хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлэх;

/Энэ заалтад 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

31.3.6.банкны дотоод аудитын нэгжийг гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулж, түүний төсөв, орон тоог батлах, удирдлага, ажилтныг томилох, үйл ажиллагааны журмыг тогтоох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

31.3.7.банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоож хэрэгжилтэд хяналт тавих;

31.3.8.банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хамарсан зохистой хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

31.3.9.энэ хуулийн 37, 38 дугаар зүйлд заасан санхүүгийн тайлан, бусад мэдээллийг нийтэд мэдээлэх явцад хяналт тавих.

31.4.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг банкны дүрмээр зохицуулах бөгөөд уг журамд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний дараахь үүргийг заавал тусгана:

31.4.1.хууль тогтоомж болон дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил, үүргээ хариуцлагатай биелүүлэх;

31.4.2.банкны эрх ашгийг хувийн болон өөрийг нь сонгосон этгээдийн эрх ашгаас дээгүүр тавих;

31.4.3.нууцаар ашиг хүртэхгүй байх;

31.4.4.сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн үед төлөөлөн удирдах зөвлөлд мэдээлдэг байх;

31.4.5.банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй байх.

31.5.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдуулах, шийдвэр хүчин төгөлдөр болох зэрэг бусад асуудлыг Компанийн тухай хуулийн 76-79 дүгээр зүйлээр зохицуулна.

31.6.Банк хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын саналын эрхийн тооллогын баримт бичгийн баталгаажуулсан хувийг хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр гарснаас хойш 45 хоногийн дотор Монголбанкинд хүргүүлнэ.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

31.7.Банкны дотоод аудитын нэгж нь банкны бодлого, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагаанд мөрдөх журмын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан зөв эсэхэд хяналт тавьж, актив хөрөнгийг хамгаалан үр ашгийг дээшлүүлэх чиг үүрэгтэйгээр банкны төлөөлөн удирдах зөвлөлд ажлаа тайлагнах зарчмаар ажиллана.

32 дугаар зүйл.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

32.1.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн дараахь шалгуурыг хангасан байна:

32.1.1.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

32.1.2.гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

32.1.3.ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банкныг удирдахад харшлахгүй байх;

32.1.4.санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын эрх бүхий албан тушаалтан бол сонирхлын зөрчилгүй, банкны шийдвэр гаргах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөргүй байх;

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

32.1.5.зөрчлийн улмаас банк ба банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх;

32.1.6.санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх.

/Энэ заалтад 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

32.1.7.дээд боловсролтой, банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүй, мэдээллийн технологи, компанийн засаглалын чиглэлээр мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс таваас доошгүй жил банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаал хашсан туршлагатай байх.

/Энэ заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

32.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь тухайн банкны хувьцаа эзэмшигч байж болно.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

32.3.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд нь энэ хуулийн 32.1-д заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг банкнаас бичгээр урьдчилан ирүүлсэн мэдээлэлд үндэслэн Монголбанк тогтоож, энэ тухай банкинд мэдэгдэнэ.

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

33 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн

33.1.Банкны төлөөлөн удирдах зөвлөлд нэг буюу түүнээс дээш хараат бус гишүүн байна.

33.2.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журмыг Монголбанк тогтооно.

/Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

33.3.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь энэ хуулийн 32.1.1-32.1.6-д зааснаас гадна дараахь шалгуурыг хангасан байна:

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

33.3.1.банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн чиглэлээр дээд боловсролтой, мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүний таваас доошгүй жилд банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан туршлагатай;

33.3.2.тухайн банк, түүний нэгдлийн оролцогчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч биш байх;

33.3.3.тухайн банк, түүний нэгдлийн оролцогчид сүүлийн таван жилийн хугацаанд эрх бүхий албан тушаалтан, сүүлийн гурван жилийн хугацаанд бусад ажилтнаар тус тус ажиллаж байгаагүй;

33.3.4.тухайн банкны үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтээс хамаарч урамшуулал авч байгаагүй, авдаггүй байх;

33.3.5.банкны үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлагад хяналт тавихад саад учруулах аливаа нөхцөл байдал үүсээгүй байх;

33.3.6.төрийн, улс төрийн болон төрийн жинхэнэ албан тушаал хашдаггүй байх;

33.3.7.эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон байх;

33.3.8.энэ хуулийн 33.3.2-33.3.3-г заасан этгээдийн холбогдох этгээд биш байх.

/Энэ заалтад 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

33.4.Банкны томоохон харилцагчийг тодорхойлох журмыг Монголбанк тогтооно.

33.5.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь аудитийн болон эрсдэлийн удирдлагын хороонд ажиллаж, эдгээр хорооны асуудал болон

Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө.

33.6.Аудитын болон эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журмыг төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

34 дүгээр зүйл.Банкны гүйцэтгэх удирдлага

34.1.Банкны гүйцэтгэх удирдлага гэрээний үндсэн дээр ажиллах бөгөөд дараахь шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөнө:

34.1.1.банк, банкны харилцагчийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүр тавих;

34.1.2.үүрэг гүйцэтгэх явцад олж авсан банк, банкны харилцагчийн талаархи мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

34.1.3.өөрт нь болон өөртэй нь холбогдох этгээдэд тухайн банкттай бизнесийн харилцаанд орсон этгээдийн санхүүгийн үр дүнг сонирхох шалтгаан байгаа бол сонирхлын зөрчил байна гэж үзэж, энэ тухайгаа төлөөлөн удирдах зөвлөлд бичгээр мэдэгдэх;

34.1.4.хувийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй байх;

34.1.5.хууль тогтоомж, банкны дүрэмд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;

34.1.6.банкны ажилтан албан үүргээ сонирхлын зөрчилгүйгээр гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх;

34.1.7.банкны хэвийн ажиллагааг хангахуйц дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, түүнд үнэлэлт, дүгнэлт өгч байх.

34.2.Гүйцэтгэх удирдлага нь энэ хуулийн 32.1.1-32.1.6-д заасан шалгуураас гадна дараахь шалгуурыг хангасан байна:

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

34.2.1.банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүний таваас доошгүй жилд банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай;

34.2.2.банк, банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнтэй сонирхлын зөрчилгүй, нэгдмэл сонирхолтой этгээд биш байх;

34.2.3.бусад банк, түүний нэгдэл, эсхүл банкттай харилцан хамаарал бүхий санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан биш байх;

34.2.4.Монголбанкны эрх бүхий албан тушаалтнаар сүүлийн хоёр жилийн хугацаанд ажиллаагүй байх;

34.2.5.мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхээ хасуулаагүй байх;

34.2.6.банкны хууль тогтоомж, Монголбанкны шийдвэрийг ноцтой зөрчиж

байгаагүй.

34.3. Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хорооны гишүүн байхыг хориглох бөгөөд гүйцэтгэх захирлыг сонгох, томилох, чөлөөлөх, түүний бүрэн эрхийг тогтоох, хяналт тавихтай холбоотой асуудлаар шийдвэр гаргахад саналын эрхгүй байна.

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

ТАВДУГААР БҮЛЭГ БАНКНЫ ХӨРӨНГӨ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Нэгдүгээр дэд бүлэг Банкны хөрөнгө, санхүүгийн тайлан

35 дугаар зүйл. Банкны өөрийн хөрөнгө

35.1. Банк өөрийн хөрөнгөтэй байх бөгөөд банкны өөрийн хөрөнгийг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монголбанкны хамтран баталсан нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу тодорхойлно.

/Энэ хэсэгт 2010 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

35.2. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээг эдийн засгийн байдал, мөнгөний ханшны өөрчлөлт, банкны төлбөрийн чадвар, эрхлэх үйл ажиллагааны онцлогийг харгалзан Монголбанк тогтооно.

35.3. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлт хангагдах нөхцөлд ногдол ашиг хуваарилж болно.

/Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

35.4. Банк өөрийн хөрөнгийн хэмжээг ашиг, алдагдлаараа буюу зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санг илүү, дутуу байгуулсан хэсгээрээ нэмэгдүүлж, эсхүл хорогдуулж тодорхойлно.

35.5. Банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмыг Монголбанк санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах бөгөөд банк активыг энэхүү журмын дагуу ангилж, эрсдэлийн сан байгуулна.

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

35.6. Энэ хуулийн 35.5-д зааснаас бусад актив, үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн санг байгуулах, зарцуулах журмыг Монголбанк тогтооно.

35.7. Энэ хуулийн 35.5, 35.6-д зааснаас бусад санг байгуулах журмыг банк өөрөө тогтооно.

35.8. Банкны хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр банкны алдагдал болон бусад хариуцлагыг хүлээнэ.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

36 дугаар зүйл. Банкны хувьцааг эзэмших зөвшөөрөл олгох

36.1. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт орохоор бол банк энэ талаар тухай бүр нь Монголбанкинд бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

/Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

36.2. Аливаа этгээд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт орохоор бол хувьцааны өмчлөх эрх шилжихээс өмнө, банк хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах бол тухайн банк энэ талаар Монголбанкинд бичгээр мэдэгдэж урьдчилан зөвшөөрөл авна.

36.3. Монголбанк банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт орох, хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч, энэ хуулийн 19 дүгээр зүйл, 20.1.5, 20.1.7, 20.3-т заасан шаардлага, 36¹ дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан, баримт бичиг бүрэн гүйцэд бүрдсэнээс хойш 60 хоногийн дотор зөвшөөрөл олгох эсэх тухай шийдвэр гаргаж энэ талаар банкинд мэдэгдэнэ.

/Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

36.4. Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт Монголбанкны зөвшөөрөлгүйгээр нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон нь хяналт шалгалтаар тогтоогдсон, эсхүл энэ хуулийн 36.12-т заасныг зөрчсөн бол уг этгээдийн тухайн хувьцааны саналын болон ногдол ашиг авах эрхийг түдгэлзүүлж, хувьцааг сүүлд авсан дарааллаар 30 хоногт багтаан хуульд заасан хязгаарлалтад хүрэх хэмжээнд албадан худалдахыг Монголбанк шаардах бөгөөд Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас нэмж гарган худалдсан бол зөвшөөрөл аваагүй хувьцааны тоонд ногдох хэмжээг банкны өөрийн хөрөнгөөс хасч тооцно.

36.5. Энэ зүйлд тогтоосон шаардлага нь, мөн хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан банк байгуулах, банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас эзэмших иргэн, хуулийн этгээд, тэдгээрийн холбогдох этгээдэд нэгэн адил хамаарна.

/Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

36.6. Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь хувьцаат компанийн хэлбэрээр байгуулагдсан банкны хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн талаархи дэлгэрэнгүй мэдээг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу ирүүлнэ.

36.7. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах, шинээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, худалдах, шилжүүлэх журмыг Монголбанк тогтооно.

36.8. Хувьцаат компани болох банкны хувьд хувьцаагаа нийтэд санал болгох болон энэ хуулийн 36.7-д заасан журмыг Монголбанк Санхүүгийн зохицуулах хороотой хамтран тогтооно.

36.9. Банкны хувьцаа эзэмшигч нь Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг банкинд буцаан худалдахыг хориглоно.

36.10.Иргэн, хуулийн этгээд бусдын нэрийг ашиглан банкны хувьцааг шууд бус хэлбэрээр эзэмшихийг хориглоно.

36.11.Энэ хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдсан банкны хувьцааг Монголбанк зөвшөөрснөөс бусад этгээдэд худалдахыг хориглоно.

36.12.Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно.

36.13.Банкны гаргасан хувьцааг худалдан авах хөрөнгө нь мөнгөн хөрөнгө байх бөгөөд энэ хуульд заасны дагуу өр төлбөр, хоёрдогч өглөг, хувьцаанд хамаарах бусад үнэт цаасыг хувьцаанд хөрвүүлэхэд энэ шаардлага хамаарахгүй.

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

36.14.Банк нь хувьцааны эцсийн өмчлөгчийг тодорхойлсон мэдээлэл, холбогдох баримт бичгийг Монголбанкинд ирүүлэх бөгөөд эцсийн өмчлөгч өөрчлөгдөх бүрд уг мэдээллийг шинэчилж ирүүлнэ.

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

36¹ дүгээр зүйл.Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид тавигдах шалгуур

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

36¹.1.Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч дараахь шалгуурыг хангасан байна:

36¹.1.1.тухайн этгээд нь дампуурлын хэргийн хариуцагч, эсхүл хариуцагч хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бус байх;

36¹.1.2.эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг үйлдэж байгаагүй;

36¹.1.3.санхүүгийн чадавхтай байх, банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдал үүсгэхгүй байх;

36¹.1.4.нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол тухайн банкны нэгдэл нь Монголбанкнаас хяналт шалгалт хийх боломж бүхий бүтэцтэй байх;

36¹.1.5.тухайн хувьцааны эцсийн өмчлөгчийг нотолсон хангалттай баримт ирүүлсэн байх.

37 дугаар зүйл.Санхүүгийн тайлан

37.1.Банкны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэлдэхүүнтэй байна.

/Энэ хэсгийг 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

37.2.Банк, банкны нэгдлийн бусад оролцогчийн санхүүгийн тайлан болон банкны нэгдлийн нэгдсэн тайлан нь дараахь шаардлагыг хангасан байна:

/Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

37.2.1.санхүүгийн тайлангийн үзүүлэлт нь олон улсын жишгийг үндэслэн Монголбанкнаас тогтоосон нягтлан бодох бүртгэлийн зарчимд нийцсэн байх;

37.2.2.санхүүгийн тайланг энэ хуулийн 37.2.1-д заасны дагуу үнэн зөв гаргасан гэдгээ албан ёсоор нотолсон баримт бичиг үйлдэн он, сар, өдрийг тэмдэглэж, банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлага, холбогдох бусад эрх бүхий албан тушаалтан гарын үсгээ зурж, тамга, тэмдэг дарсан байх;

37.3.Банк нь санхүүгийн сар бүрийн байдлаар дараа сарын 10-ны өдрийн дотор, банк, банкны нэгдлийн оролцогч буюу банкны толгой компани нэгдсэн буюу тусдаа тайланг улирал бүрийн байдлаар дараа улирлын эхний сарын дотор Монголбанкинд гаргаж өгнө.

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

37.4.Банк, банкны нэгдлийн бусад оролцогчийн санхүүгийн тайлантай холбогдсон нэмэлт нотлох баримтыг Монголбанк тухайн этгээдээс шаардах эрхтэй

/Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

37.5.Банкны нэгдлийн нэгдсэн тайлан гаргах журмыг Монголбанк Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтооно.

37.6.Банк нь банк, санхүүгийн үйл ажиллагааны талаархи мэдээллийн санг давагдашгүй хүчин зүйл, бусад аюулаас сэргийлэх зорилгоор архивын биет болон цахим хэлбэрээр стандартын дагуу хадгалах нөөц төвтэй байна.

38 дугаар зүйл.Банкны санхүүгийн тайлан, бусад мэдээллийг нийтэд мэдээлэх

38.1.Банк нь энэ хуулийн 37.2-т заасан шаардлагыг хангасан улирлын санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын дотор, аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд хэвлэлээр мэдээлж байна.

38.2.Энэ хуулийн 38.1-д заасан тайлангаас гадна дараахь мэдээллийг нийтлэх, өөрийн цахим хуудсанд байрлуулах зэргээр шийдвэр гарснаас хойш тав хоногийн дотор банк нийтэд мэдээлнэ:

38.2.1.банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлагын гарын үсгээр баталгаажуулсан ажлын тайлан;

38.2.2.хуулийн этгээдийн зохион байгуулалт-эрх зүйн хэлбэр, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн;

/Энэ заалтад 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

38.2.3.санхүү, бүртгэлийн тогтолцоо, дотоод хяналт;

38.2.4.нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, түүний орлогч, ерөнхий нягтлан бодогч, банкны нэгжийн удирдлага, хяналтын зөвлөлийн гишүүдийн нэр;

38.2.5.банкийг өөрчлөн байгуулах хэлбэр, хугацаа, хэрэгжүүлэх арга, шинээр үүсэх хуулийн этгээдийн зохион байгуулалт-эрх зүйн хэлбэр, байршил, банкны эрхлэх үйл ажиллагааны төрөл, санхүүгийн үйл ажиллагааны үндсэн баримтын тухай;

38.2.6.банкны холбогдох этгээдэд олгосон зээл, гаргасан аккредитив, бусад үүрэг, ажил, үйлчилгээ;

38.2.7.банкны эрсдэлийг тодорхойлоход шаардлагатай гэж Монголбанкнаас үзсэн бусад мэдээлэл.

38.3.Монголбанк нь банкнаас нийтэд мэдээлсэн, цахим хуудсанд байрлуулсан санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв эсэхэд хяналт тавьж, зохих журмыг баримтлаагүй, буруу, алдаатай нийтэлсэн бол залруулахыг шаардаж биелэлтэд хяналт тавьж ажиллана.

38.4.Энэ хуулийн 38.2.5-д заасан мэдээллийг Монголбанкнаас өөрчлөн байгуулах зөвшөөрөл авсны дараа нийтэд мэдээлнэ.

39 дүгээр зүйл.Банкны санхүүгийн тайлан, бусад шаардлагатай мэдээг тайлагнах

39.1.Банк, банкны нэгдлийн оролцогч, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь санхүүгийн тайлан, санхүүгийн анхан шатны баримт, тэдгээрийг нотлох баримт, хууль тогтоомжийн дагуу банкны удирдлагын үйл ажиллагааны талаар бүрдүүлбэл зохих баримт, мэдээ, мэдээлэл болон санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа тоног төхөөрөмж, түүний программ, дэд программ хангамж, тэдгээрийн байршлын талаархи дэлгэрэнгүй жагсаалт, тэдгээрт нэвтрэх нууц түлхүүрийг Монголбанк, Монголбанкны хянан шалгагчид саадгүй, бүрэн гүйцэд, үнэн зөв гарган өгч, хяналт шалгалтын үйл ажиллагааг бие даасан, хараат бусаар явуулах нөхцөлөөр хангана.

39.2.Банкны удирдлага, банктай холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь Монголбанкны хянан шалгагчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоогоор хангана.

39.3.Монголбанк, түүний хянан шалгагчийн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд шаардсан баримт, мэдээ, мэдээлэл байхгүй бол банктай холбогдох этгээд, банкны эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь энэ тухайгаа албан бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

40 дүгээр зүйл.Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулах

40.1.Банк, банкны нэгдлийн бусад оролцогчийн нь санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт бичгээ аудитын байгууллага /аудитор/-аар жилд нэгээс доошгүй удаа шалгуулж баталгаажуулна.

/Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

40.2.Аудитын байгууллага /аудитор/ нь баталгаажуулсан санхүүгийн тайлан, баримт бичгийн талаархи дүгнэлтийг тухайн банкны төлөөлөн удирдах зөвлөл, хянан шалгах зөвлөлд танилцуулна.

41 дүгээр зүйл.Аудитын дүгнэлтийг санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагад мэдээлэх

41.1.Аудитын байгууллага /аудитор/ нь өөрийн баталгаажуулсан дэлгэрэнгүй

тайлан, түүний талаархи эцсийн дүгнэлтийн эх хувийг тухайн банк болон Монголбанкинд эхний хагас жилийн дотор хүргүүлнэ.

41.2.Аудитын байгууллага /аудитор/ нь тухайн банкны баримт бичигт үндэслэн дараахь дүгнэлтийг гаргавал энэ талаархи дүгнэлтээ Монголбанкинд тав хоногийн дотор мэдээлнэ:

41.2.1.төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй болсноос ойрын үед санхүүгийн онц хүндрэлтэй байдалд орж болзошгүй байгаа;

41.2.2.тухайн банкны ажилтан өөрийн банкны санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлсөн шударга бус, хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагаанд оролцсон гэж үзсэн.

41.3.Аудитын байгууллага /аудитор/ нь ажил, үүргээ гүйцэтгэх явцад хувьцаат компани болох банкны хувьд энэ хуулийн 41.2-т заасан буюу Компанийн тухай хуульд заасан их хэмжээний, эсхүл сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг зөрчсөн байдал илэрвэл Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороонд тав хоногийн дотор бичгээр мэдээлнэ.

42 дугаар зүйл.Татвар төлөх

42.1.Банк холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар төлнө.

Хоёрдугаар дэд бүлэг Хяналт шалгалт

43 дугаар зүйл.Банкинд хяналт тавих Монголбанкны бүрэн эрх

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

43.1.Холбогдох банк, санхүүгийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь өөрсдийн үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдалтай холбоотой бүхий л баримт материал, тайлан бүртгэл, мэдээ, мэдээлэл холбогдох бусад баримт бичгийг Монголбанкны шаардсанаар гарган өгөх үүрэгтэй.

43.2.Монголбанк дараахь арга хэмжээ авахыг банкнаас шаардах бүрэн эрхтэй:

43.2.1.хуульд заасны дагуу Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн шаардлагыг хангах;

/Энэ заалтад 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

43.2.2.банкны эрсдэлийн төрөл, түвшин, өөрийн хөрөнгийн байдалтай нь уялдуулан банкны активыг ангилах, эрсдэлийн сан байгуулах, зарцуулах талаар тусгай журам тогтоох;

43.2.3.банкны өөрийн хөрөнгийг хууль, Монголбанкнаас тогтоосон банкны өөрийн хөрөнгийн доод хэмжээнээс дээш хэмжээгээр бүрдүүлэх, эрсдэлийн санг нэмэгдүүлэх;

/Энэ заалтад 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

43.2.4.энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх журам тогтоох, холбогдох шийдвэр гаргах, хэрэгжүүлэх;

43.2.5.банкны үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох, банкны үйл ажиллагаанд цаашид алдагдал учруулах эрсдэлтэй банкны нэгжийг татан буулгах, үйл ажиллагааны зарим чиглэлийг бусдад шилжүүлэх талаар банкинд зөвлөмж өгөх;

43.2.6.банкны эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээ авах;

43.2.7.цэвэр ашгаар өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх;

43.2.8.төлбөр түргэн гүйцэтгэх чадварт тусгай шаардлага тавих;

43.2.9.тогтоосон хугацаанд шаардлагатай тайлан, мэдээ, мэдээллийг ирүүлэх, тайлагнах;

43.2.10.хууль, журамд заасан нөхцөл шаардлага, шалгуурыг хангаж ажиллах;

43.2.11.Монголбанкнаас тогтоосон банкны зохистой засаглалын журмын хэрэгжилтийг хангах;

43.2.12.банк нь хууль, Монголбанкнаас тогтоосон журам, бусад шийдвэрийг зөрчсөн бол банкны гүйцэтгэх удирдлагыг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, эсхүл чөлөөлөх талаар төлөөлөн удирдах зөвлөлд хугацаатай үүрэг өгөх, заасан хугацаанд үүргийг биелүүлээгүй бол гүйцэтгэх удирдлагыг албан тушаалаас нь чөлөөлөх.

/Энэ заалтад 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

43.3.Монголбанк шаардлагатай тохиолдолд банкны активт чанарын үнэлгээ, эрсдэлийн сорил хийж, тэдгээрийн үр дүнд үндэслэн өөрийн хөрөнгө, эрсдэлийн санг нэмэгдүүлэх арга хэмжээ авч болно.

43.4.Банкны үйл ажиллагааны бодит байдлыг тодорхойлох зорилгоор энэ хуулийн 43.3-д заасан үнэлгээ, сорилыг хийхэд шаардагдах зардлыг Монголбанк хариуцна.

43.5.Монголбанк Санхүүгийн зохицуулах хороотой хамтран банкны нэгдлийн удирдлага, санхүү, төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, шаардлагыг тогтооно.

43.6.Монголбанк хуульд заасан албадлагын арга хэмжээ авах, хяналт шалгалт хийх журмыг батална.

/Энэ хэсгийг 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./

44 дугаар зүйл.Нэгдсэн хяналт шалгалт хийх

/Энэ зүйлийн дугаарт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

44.1.Монголбанк нь банкны нэгдлийн оролцогчийн үйл ажиллагаанд тусгайлан хяналт шалгалт хийхдээ шаардлагатай гэж үзвэл санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороотой хамтран нэгдсэн хяналт шалгалт хийх бөгөөд түүнд хамрагдах хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгдсэн байдлаар гаргаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

44.2.Нэгдсэн хяналт шалгалтад банкны нэгдлийн оролцогчийг хамруулах, тэдгээрийн санхүүгийн тайлан, холбогдох бусад мэдээллийг гаргаж тайлагнах, хяналт шалгалт хийх харилцааг Монголбанкны Санхүүгийн зохицуулах хороо,

санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталсан журмаар зохицуулна.

44.3.Банкны нэгдлийн оролцогч нь өөр улсад бүртгэгдсэн буюу байршдаг бол Монголбанк тухайн улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагатай гэрээ, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан мэдээлэл солилцох, хамтарсан шалгалт хийх хэлбэрээр хамтран ажиллаж болно.

44.4.Энэ хуулийн 44.1-д заасан нэгдсэн хяналт шалгалтыг дараах байдлаар хийнэ:

/Энэ хэсгийг 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

44.4.1.нэгдсэн хяналт шалгалтад хамруулах шаардлагатай банкны нэгдлийн холбогдох хэсгийг тодорхойлох;

44.4.2.энэ хуулийн 44.4.1-д заасан хэсэгт хамаарах банкны нэгдэлд оролцогчдын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, мэдээлэлд үндэслэн тэдгээрийн санхүү, төлбөрийн чадвар, хоорондын хөрөнгийн урсгал, нэг оролцогчоос нөгөөд оруулсан хөрөнгө, өглөг, авлага, зээл, банкны нэгдлийн оролцогч хоорондын санхүүгийн бусад хэлцэл, гүйлгээний хамаарал болон банкны нэгдлийн хэмжээнд үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлох;

44.4.3.банк, банкны нэгдлийн оролцогч, эсхүл банкны нэгдлийн хэмжээний санхүү, төлбөрийн чадварын байдалд санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас тавьж байгаа зохистой харьцааны болон бусад шаардлагыг хангаж байгаа эсэхийг дангаар нь болон нэгдсэн байдлаар тогтоож, үнэлэлт, дүгнэлт өгөх.

44.5.Банкны нэгдлийн оролцогч нь Монголбанкнаас шаардсан мэдээллийг тогтоосон хугацаанд тухайн нэгдлийн оролцогч банкаар дамжуулан гаргаж өгнө.

45 дүгээр зүйл.Холбогдох этгээд, банкны нэгдлийн бүртгэл

/Энэ зүйлийн дугаарт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

45.1.Банк холбогдох этгээд, түүнд холбогдох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын талаархи мэдээллийн сантай байна.

45.2.Банк энэ хуулийн 45.1-д заасан сангийн мэдээллийг банк үүсгэн байгуулагдсанаас хойш тав хоногийн дотор Монголбанкинд хүргүүлэх бөгөөд энэ сангийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг гурав хоногийн дотор Монголбанкны тогтоосон журмын дагуу ирүүлнэ.

/Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

45.3.Банкны нэгдлийн оролцогч, холбогдох этгээдийн талаархи мэдээлэл болон түүнд оруулсан өөрчлөлт бүрийг өөрчлөлт оруулснаас хойш долоо хоногийн дотор тухайн банкаараа дамжуулан Монголбанкинд тогтоосон журмын дагуу хүргүүлнэ.

45.4.Энэ хуульд нийцүүлэн холбогдох этгээдийн нэгдлийн оролцогчийг тодорхойлох зорилгоор Монголбанк, банкны гаргасан хүсэлтийн дагуу Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээлэл өгнө.

/Энэ хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

/Энэ хэсгийг 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

46 дугаар зүйл. Нэгдсэн хяналт шалгалтад хамрагдахгүй байх нөхцөл

/Энэ зүйлийн дугаарт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

46.1. Монголбанк нэгдсэн хяналт шалгалтын үйл ажиллагаанд банкны нэгдлийн оролцогчийг дараахь тохиолдолд оролцуулахгүй байж болно:

46.1.1. үйл ажиллагааны төрөл, хэмжээ нь банкны санхүү, төлбөрийн чадварын байдалд нөлөө үзүүлдэггүй;

46.1.2. тухайн хуулийн этгээдийг нэгдсэн хяналт шалгалтад хамруулахгүй байх нь нэгдсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа зохих ёсоор хэрэгжүүлэхэд саад болохооргүй.

46.2. Нэгдсэн хяналт шалгалтад хамруулахгүй бол энэ тухай Монголбанк тухайн банк болон банкны толгой компани, тухайн оролцогчид мэдэгдэнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ

Нэгдүгээр дэд бүлэг

Банкны тогтворжуулалт, бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө

/Энэ бүлгийн гарчгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

47 дугаар зүйл. Банкнийг тогтворжуулах болон бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний төлөвлөгөө

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

47.1. Банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, эдийн засгийн тухайн нөхцөл байдлаас шалтгаалан үүсч болох эрсдэлийг урьдчилан тооцож, банкны төлбөрийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалахад чиглэсэн хариу арга хэмжээг тусгаж, төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан тогтворжуулах төлөвлөгөөг тогтоосон хугацаанд Монголбанкинд ирүүлнэ.

47.2. Энэ хуулийн 47.1-д заасан төлөвлөгөө нь тухайн банкны нэгдэл, түүний толгой компани, үйл ажиллагааг хамарсан байна.

47.3. Банкнаас ирүүлсэн тогтворжуулах төлөвлөгөө нь энэ хуулийн 47.1-д заасан шаардлагыг хангаагүй бол Монголбанк өөрчлөлт оруулахыг банкнаас шаардана.

47.4. Банк энэ хуулийн 47.3-г заасны дагуу тогтворжуулах төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулаагүй буюу уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй гэж Монголбанк үзвэл дараахь шаардлагыг банкинд тавина:

47.4.1. банкны эрсдэлийн ерөнхий түвшинг бууруулах;

47.4.2. хувьцаа болон хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах хэлбэрээр банкний дахин санхүүжүүлэх зээл олгох төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах тодорхой арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх;

47.4.3. бизнес төлөвлөгөө, стратегийг өөрчлөх, банкны үндсэн үйл ажиллагааг бэхжүүлэх;

47.4.4.банкны удирдлага, зохион байгуулалтын бүтцийг өөрчлөх;

47.4.5.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад шаардлага.

47.5.Монголбанк банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулж, батална.

47.6.Банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө дараахь агуулгатай байна:

47.6.1.тухайн банк, банкны тогтолцоог хамарсан төлбөрийн чадвар алдагдаж болох нөхцөл байдал, эрсдэлийг тодорхойлсон төсөөлөл;

47.6.2.Энэ хуулийн 47.6.1-д заасан нөхцөл байдлын үед авах бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ.

47.7.Энэ зүйлийн 47.1, 47.5 дахь хэсэгт заасан төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх журмыг Монголбанк батална.

Хоёрдугаар дэд бүлэг “Урьдчилан сэргийлэх арга хэмжээ”

/Энэ гарчгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

48 дугаар зүйл.Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

48.1.Банк нь Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкнаас тогтоосон дүрэм, журам, шийдвэрийг зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй нөхцөл байдал үүссэн, банкны тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй, эсхүл найдваргүй, хэвийн бус үйл ажиллагаа явуулсан бол Монголбанкнаас дараахь арга хэмжээг авна:

48.1.1.зөрчил, дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх;

48.1.2.зөрчил, дутагдлыг арилгах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

48.1.3.тогтворжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг тогтоосон түвшинд хүргэхийг даалгах;

48.1.4.банкны өөрийн хөрөнгийг тогтоосон хугацаанд нэмэгдүүлэхийг үүрэг болгох;

48.1.5.банкны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;

48.1.6.банкны удирдах албан тушаалтны урамшууллын тогтолцоо нь банкны өөрийн хөрөнгийн хангалттай байх түвшинд сөргөөр нөлөөлнө гэж Монголбанк дүгнэсэн бол цалин, урамшууллыг хязгаарлах;

48.1.7.тодорхой үйл ажиллагаа явуулах, хэлцэл гүйлгээ хийхэд Монголбанкаас урьдчилан зөвшөөрөл авахаар тогтоох;

48.1.8.тухайн банкны нэг улирлын нийт активын дундаж хэмжээ нь өмнөх улирлын нийт активын дундаж хэмжээнээс хэтрэхгүй байх, эсхүл активыг төрөлжүүлэхийг даалгах;

48.1.9.хөрөнгө худалдан авах, банкны нэгж байгуулахыг хориглох;

48.1.10.банкны үйл ажиллагаа явуулахыг хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, түдгэлзүүлэх;

48.1.11.хөрөнгө худалдах, банкны нэгжийг татан буулгахыг шаардах;

48.1.12.банкны гүйцэтгэх удирдлагыг албан тушаалаас түдгэлзүүлэх, чөлөөлөх;

48.1.13.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, дуусгавар болгох, чөлөөлөх;

48.1.14.энэ хуулийн 48.1.1-48.1.13-т заасан арга хэмжээг банк биелүүлээгүй бол нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн саналын эрхийг түдгэлзүүлэх;

48.1.15.нөхцөлт удирдлагын арга хэмжээ авах;

48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.

48.2.Монголбанк энэ зүйлд заасан арга хэмжээ авахдаа тухайн зөрчил, дутагдал, үүссэн нөхцөл байдал, шаардлагад тохирсон арга хэмжээ авах зарчмыг баримтална.

48.3.Энэ зүйлд заасан арга хэмжээг авсан нь энэ хууль, бусад хууль тогтоомжоор Монголбанкнаас арга хэмжээ авах, хариуцлага ногдуулах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

48.4.Монголбанк энэ зүйлд заасны дагуу банкинд авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар Хадгаламжийн даатгалын корпорацид мэдэгдэнэ.

Гуравдугаар дэд бүлэг “Банкны нөхцөлт удирдлага”

/Энэ гарчгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

49 дүгээр зүйл.Банкны нөхцөлт удирдлага

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

49.1.Монголбанк нь энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь банкны үйл ажиллагааг сайжруулах, найдвартай тогтвортой удирдлагыг сэргээхэд хангалтгүй гэж үзсэн, эсхүл энэ хуулийн 3.1.16-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд банкинд нөхцөлт удирдлагыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, бүрэн эрхт төлөөлөгчийг томилж болно.

49.2.Монголбанк тухайн банкныг удирдах бүрэн эрхт төлөөлөгч /цаашид “бүрэн эрхт төлөөлөгч” гэх/-ийг нэг жил хүртэл хугацаагаар томилох бөгөөд бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журмыг энэ хуульд нийцүүлэн Монголбанк батална.

49.3.Банкны нөхцөлт удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны зардлыг тухайн банк хариуцна.

50 дугаар зүйл.Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх шийдвэр

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

50.1.Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх тухай Монголбанкны шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

50.1.1.банкны нэр, оршин байгаа газар, хаяг;

50.1.2.банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх болсон үндэслэл;

50.1.3.банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлж эхлэх болон түүний үргэлжлэх хугацаа;

50.1.4.банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалтын жагсаалт;

50.1.5.бүрэн эрхт төлөөлөгчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр.

50.2.Монголбанк банкны нөхцөлт удирдлагын арга хэмжээ авсан тухай шийдвэрийг нийтэд мэдээлж болно.

51 дүгээр зүйл.Бүрэн эрхт төлөөлөгч томилох

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

51.1.Монголбанк өөрийн ажилтныг, эсхүл бусад этгээдийг банкны бүрэн эрхт төлөөлөгчөөр томилж болно.

51.2.Бүрэн эрхт төлөөлөгчийн цалин хөлсийг Монголбанк тогтоож, тухайн банкнаас гаргуулна.

51.3.Бүрэн эрхт төлөөлөгч үйл ажиллагаандаа хууль тогтоомж болон энэ хуультай нийцүүлэн гаргасан Монголбанкны дүрэм, журам, удирдамжийг баримтална.

51.4.Монголбанк бүрэн эрхт төлөөлөгчийг өөрчлөх эрхтэй.

52 дугаар зүйл.Банкны нөхцөлт удирдлагын үед авах арга хэмжээ, бүрэн эрхт төлөөлөгчийн эрх, үүрэг

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

52.1.Монголбанк банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэхдээ дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

52.1.1.тухайн банкны удирдлагын эрх, үүргийг бүрэн эрхт төлөөлөгчид түр шилжүүлэх;

/Энэ заалтад 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

52.1.2.банкны үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг хянаж баталгаажуулах, сайжруулах арга хэмжээ авах.

52.2.Бүрэн эрхт төлөөлөгч дараахь эрх, үүрэгтэй:

52.2.1.тухайн банкны эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар бие даан шийдвэр гаргах;

52.2.2.шаардлагатай гэж үзвэл банкны нөхцөлт удирдлага тогтоосон хугацаанд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй холбогдох үүргийг бүрмөсөн, эсхүл хэсэгчлэн биелүүлэхийг түдгэлзүүлэх;

52.2.3.тухайн банкнаас урьд нь харилцагчтай хийсэн зээл, хадгаламжийн болон бусад гэрээний нөхцөл нь банкны тухайн үеийн ерөнхий нөхцөлөөс өөрөөр тогтоогдож, банкны эрх ашигт сөргөөр нөлөөлсөн гэж үзвэл уг гэрээнд өөрчлөлт оруулах, цуцлах, дуусгавар болгох;

52.2.4.банкны нэрийн өмнөөс гэрээ байгуулах;

52.2.5.банкны нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах;

52.2.6.банкаас ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах, түүнд өөрчлөлт оруулах, шаардлагатай ажилтныг түр хугацаагаар авч ажиллуулах;

52.2.7.банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангах зорилгоор түүний бүтэц, хэмжээг өөрчлөх.

52.3.Бүрэн эрхт төлөөлөгчийн шийдвэрийг тухайн банк, түүний салбар нэгж биелүүлэх үүрэгтэй.

52.4.Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлсэн банкны гүйцэтгэх удирдлага ажлын тайлан, орлогын мэдүүлгээ зохих журмын дагуу бүрэн эрхт төлөөлөгчид гаргаж өгнө.

52.5.Бүрэн эрхт төлөөлөгчийн албан ёсны зөвшөөрөлгүйгээр тухайн банкны нэрийн өмнөөс болон тухайн банкны зардлаар хийсэн ажил, гүйлгээг хүчингүйд тооцно.

52.6.Банкны хэвийн үйл ажиллагаа хангагдсан нөхцөлд Монголбанк нөхцөлт удирдлагыг цуцалж, тухайн банкинд тогтоосон хязгаарлалтыг бүрмөсөн, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгоно.

52.7.Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх үед тухайн банкны дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт хүчинтэй хэвээр үлдэнэ.

52.8.Бүрэн эрхт төлөөлөгч өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас учруулсан хохирлыг хариуцах бөгөөд банкны үйл ажиллагааны ердийн эрсдэлд хамруулж болох хохирол учирсан нь бүрэн эрхт төлөөлөгчид хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

52.9.Бүрэн эрхт төлөөлөгчийн шийдвэрийг тухайн банк, түүний салбар нэгж биелүүлэх үүрэгтэй бөгөөд уг шийдвэрийг дагаж мөрдсөнөөс үүсэх хариуцлагыг Монголбанк хүлээнэ.

Дөрөвдүгээр дэд бүлэг

Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ

/Энэ гарчгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

53 дугаар зүйл.Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах эрх, зарчим

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

53.1.Монголбанк энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах шийдвэр гаргах эрхтэй.

53.2.Монголбанк банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ санхүүгийн тогтвортой байдлыг хангах, шуурхай, үр нөлөөтэй байх, төрөөс гарах зардлыг багасгах, хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах зарчмыг баримтална.

53.3.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ, түүний хэрэгжилт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийн дүн шинжилгээ, хяналтыг Монголбанк

банкны хяналт шалгалтын чиг үүрэг, арга хэмжээнээс тусад нь зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

54 дүгээр зүйл.Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний үндэслэл, хүрээ

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

54.1.Монголбанк нь дараахь үндэслэлээр энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан арга хэмжээг авахаар шийдвэрлэнэ:

54.1.1.банк төлбөрийн чадваргүй болсон, эсхүл төлбөрийн чадваргүй болох гарцаагүй нөхцөл байдал үүссэн;

54.1.2.банкны хэвийн үйл ажиллагааг цаашид хангах боломжгүй болсон тухай Монголбанкны хяналт шалгалтын дүгнэлт гарсан;

54.1.3.бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах нь нийтийн ашиг сонирхлыг хангахад зайлшгүй шаардлагатай.

54.2.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг банк, түүний нэгдлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

54.3.Монголбанк доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь бүрдсэн тохиолдолд энэ хуулийн 54.1.1-д заасан үндэслэл бий болсонд тооцно:

54.3.1.банк хадгаламж эзэмшигч, харилцагч, бусад үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийн мөнгийг тэдний анхны шаардлагаар гарган өгч чадахгүй болсон; эсхүл гаргаж өгөх боломжгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон;

54.3.2.зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүйгээс цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;

54.3.3.банкны пассив нь активаасаа хэтэрсэн, эсхүл ердийн боломжит хугацаанд хэтрэх нь хяналт шалгалтаар тогтоогдсон.

54.4.Монголбанк энэ зүйлд заасан арга хэмжээг авсан тухай шийдвэрээ Хадгаламжийн даатгалын корпораци, Сангийн яаманд мэдэгдэнэ.

55 дугаар зүйл.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хэрэгсэл

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

55.1.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараахь хэрэгслийг ашиглана:

55.1.1.банкны актив, пассивыг шилжүүлэх;

55.1.2.тусгай зориулалтын банк байгуулах;

55.1.3.хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх;

55.1.4.өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлэх.

55.2.Банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах болон энэ хуулийн 55.1-д заасан хэрэгслийг ашиглахад хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахгүй бөгөөд банкны хувьцаа эзэмшигч, үүргийн гүйцэтгэл шаардах эрх бүхий этгээдийн зөвшөөрлийг авах шаардлагагүй.

55.3.Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд энэ хуулийн 55.1.3-т

заасан хэрэгслийг тэргүүн ээлжинд харгалзан үзнэ.

55.4.Монголбанк энэ хуульд нийцүүлэн банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах, хэрэгжүүлэх журмыг батална.

56 дугаар зүйл.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

56.1.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг Монголбанкнаас томилсон Тусгай төлөөлөгч хэрэгжүүлнэ.

56.2.Тусгай төлөөлөгч нь дараахь шаардлагыг хангасан байна:

56.2.1.банкны үйл ажиллагааны мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвартай;

56.2.2.гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байгаагүй;

56.2.3.тухайн банкнаас урьд нь авсан хугацаа хэтэрсэн зээлийн өргүй;

56.2.4.тухайн банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, бусад ажилтантай холбогдох этгээдийн харилцаагүй;

56.2.5.хуулийн этгээд бол өөрийн үйл ажиллагааг хариуцах хангалттай хэмжээний хөрөнгө, санхүүгийн эх үүсвэртэй.

56.3.Тусгай төлөөлөгчийн цалин хөлсийг Монголбанк тогтооно.

56.4.Тусгай төлөөлөгч Монголбанкны шийдвэрийг дагаж мөрдөнө.

56.5.Тусгай төлөөлөгч томилогдсоноор банк, түүний удирдлага, эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх болон банкны хөрөнгийг захиран зарцуулах эрх нь Тусгай төлөөлөгчид шилжинэ.

56.6.Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ 90 хоногийн хугацаатай байна. Энэ хугацааг мөн хугацаагаар хоёр удаа сунгаж болно.

56.7.Тусгай төлөөлөгч нь банкны актив, пассивын үнэлгээг хараат бус, хөндлөнгийн, мэргэжлийн этгээдээр зохих стандарт, шаардлагын дагуу хийлгэнэ.

56.8.Тусгай төлөөлөгч нь энэ хуульд заасан банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна дараахь бүрэн эрхтэй байна:

56.8.1.банкны өр төлбөрийн эргэн төлөгдөх хугацаанд өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх;

56.8.2.банкны байгуулсан санхүүгийн гэрээ, хэлцлийг дуусгавар болгох;

56.8.3.банкинд хөрөнгө оруулахыг тухайн банкны нэгдлийн толгой компаниас шаардах;

56.8.4.энэ хуулийн 69.1-т заасан бусад эрх.

56.9.Тусгай төлөөлөгч нь Монголбанкинд ажлаа хариуцан тайлагнана.

56.10.Тусгай төлөөлөгчийн цалин хөлс, холбогдох бусад зардлыг тухайн банкнаас гаргуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд Монголбанкнаас урьдчилан гаргаж, банкаар нөхөн төлүүлнэ.

57 дугаар зүйл. Банкны актив, пассивыг шилжүүлэх

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

57.1. Тусгай төлөөлөгч банкны актив, пассивыг эрх бүхий банкинд шилжүүлж болно.

57.2. Энэ хуулийн 57.1-т заасан шилжүүлэг хийхдээ энэ хуульд заасны дагуу хийсэн үнэлгээг баримтална.

57.3. Банкны шилжүүлгийг хийхэд шаардагдах санхүүжилтийн нөхцөл, хэлбэр, хэмжээг тусгай төлөөлөгчийн саналыг харгалзан Монголбанк тодорхойлно.

57.4. Банкнийг шилжүүлэх шийдвэр нь тухайн банкны актив, пассив, тэнцлийн гадуурх зүйлтэй холбоотойгоор өмнө байгуулсан гэрээ, хэлцэл, шийдвэрийн зохицуулалтаас үл хамааран хэрэгжинэ.

57.5. Банкнийг шилжүүлсэн нь банкнаас урьд нь бусадтай байгуулсан гэрээ, хэлцлийг хугацаанаас өмнө татгалзах, цуцлах үндэслэл болохгүй.

57.6. Энэ хуулийн 57.1-т заасан арга хэмжээг авахад дараахь нөхцөлийг баримтална:

57.6.1. өр төлбөрт барьцаалагдсан эд хөрөнгийг тухайн өр төлбөр, уг үүргийн гүйцэтгэлийг хангуулах бусад дагалдах эрхийн хамт шилжүүлэх;

57.6.2. хүүгийн своп, валютын своп, валютын опцион болон Монголбанкнаас тодорхойлсон бусад санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийн төлбөр харилцан тооцох, эрх, үүргийг бүхэлд нь шилжүүлэх.

57.7. Энэ зүйлд заасан арга хэмжээний хүрээнд буцаан төлөгдсөн хөрөнгийн хэмжээ нь тухайн банкнийг шууд татан буулгасны үр дүнд буцаан төлөгдөх боломжтой байсан хөрөнгийн хэмжээнээс багассан болох нь тогтоогдсон тохиолдолд тухайн банкнаас төлбөр гаргуулах шаардлага нь бусдад шилжээгүй үүрэг гүйцэтгүүлэгч уг зөрүүгээр нөхөн төлбөр гаргуулахыг шаардах эрхтэй.

58 дугаар зүйл. Тусгай зориулалтын банк байгуулах

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

58.1. Тусгай төлөөлөгч нь банкны бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасан нөхцөл шаардлагын хүрээнд тусгай зориулалтын банк байгуулж болно.

58.2. Тусгай зориулалтын банк байгуулах зөвшөөрлийн хугацаа гурав хүртэлх жил байна.

59 дүгээр зүйл. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

59.1. Банкны алдагдал, өр төлбөрийн хэмжээг бууруулах, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор тусгай төлөөлөгч дараахь арга хэмжээ авч болно:

59.1.1. хувьцаанд хамаарах үнэт цаасыг хувьцаанд хөрвүүлэх;

59.1.2. банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах;

59.1.3.банкны хувьцааг нэгтгэх, хуваах;

59.1.4.банкны алдагдал, өр төлбөрийг бууруулах, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд шаардлагатай бусад.

59.2.Энэ хуулийн 59.1-т заасны дагуу хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны үнийг бууруулснаар тухайн бууралтын хэмжээ эцсийн байх бөгөөд үнэт цаасны эзэмшигч нь бууралттай холбоотой аливаа шаардлага гаргах эрхгүй.

60 дугаар зүйл.Өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлэх

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

60.1.Тусгай төлөөлөгч нь банкныг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл энэ хуулийн 59.2, 57.1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор банкны өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлж болно:

60.2.Энэ хуулийн 60.1-д заасан хөрвүүлэлтэд доор дурдсан өр төлбөрийг хамруулахгүй:

60.2.1.даатгагдсан хадгаламж;

60.2.2.үүргийн гүйцэтгэлийг хангах аргаар баталгаажсан өр төлбөр;

60.2.3.энэ хуулийн 6.1.6, 6.1.7-д заасны дагуу хадгалуулсан, эсхүл хуульд заасны дагуу банкны активаас тусгаарлагдсан хөрөнгөө буцаан авах харилцагчийн авлага;

60.2.4.долоо хоногоос бага хугацаатай, холбогдох этгээдэд хамаарахгүй банкнаас олгосон зээл;

60.2.5.долоо хоногоос бага хугацаатай, төлбөр тооцооны систем, түүний оператороос олгосон зээл;

60.2.6.ажилтны цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, түүнтэй адилтгах бусад төлбөр;

60.2.7.банкинд зайлшгүй шаардлагатай бараа, ажил, үйлчилгээний төлбөр;

60.2.8.тагварын өр, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг;

60.2.9.хадгаламжийн даатгалын корпорацид төлөх төлбөр;

60.2.10.Монголбанкнаас хөрвүүлэхгүй байхаар тогтоосон бусад өр төлбөр.”

60.3.Өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлэх нөхцөл, шалгуур, шаардлага, журмыг энэ хуулийн 55.4-т заасан журмаар тогтооно.

61 дүгээр зүйл.Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

61.1.Банкны тогтолцоо, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банкны бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Засгийн газраас банкныг дахин хөрөнгөжүүлэх, тусгай зориулалтын банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлэх, банкны өрийн хэрэгслийг худалдан авах, зээл олгох, баталгаа гаргах, банкны тогтворжуулалтын санд хөрөнгө оруулах хэлбэрээр

гаргаж болно.

61.2.Энэ хуулийн 61.1-т заасан санхүүжилтийн хэмжээ, олгох нөхцөл, журмыг Монголбанк, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналд үндэслэн Засгийн газар тогтооно.

61.3.Монголбанк нь өөрийн үндсэн зорилтод харшлахгүй гэж үзвэл банкны бүтцийн өөрчлөлтөд зориулан доор дурдсан нөхцөлтэй зээл олгож болно:

61.3.1.хүүгийн тусгайлсан нөхцөлтэй;

61.3.2.90 хоногийн хугацаатай, энэ хугацааг дахин нэг удаа мөн хугацаагаар сунгах боломжтой;

61.3.3.Монголбанкнаас тодорхойлсон хангалттай хэмжээний барьцаатай;

61.3.4.Засгийн газрын баталгаагаар хангагдсан.

62 дугаар зүйл.Банкны тогтворжуулалтын сан

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

62.1.Монголбанк нь банкны санхүүгийн байдлыг сайжруулах, тогтворжуулах, банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийн сан /цаашид “Сан” гэх/-г бүрдүүлж, зохих журмын дагуу дараахь байдлаар зарцуулж болно.

62.1.1.бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авахтай холбогдуулан баталгаа гаргах;

62.1.2.зээл олгох;

62.1.3.хөрөнгө худалдан авах;

62.1.4.тусгай зориулалтын банкинд хөрөнгө оруулалт хийх;

62.1.5.энэ хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигч, үүргийн гүйцэтгэл шаардах эрх бүхий этгээдэд төлбөр төлөх;

62.1.6.банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн дутагдал, зөрүүг нөхөх.

62.2.Сангийн сул чөлөөтэй хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийж болно.

62.3.Монголбанк нь дотоод болон гадаадын үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй, хөрөнгийн удирдлагын туршлагатай, санхүүгийн чадавхитай, найдвартай, мэргэжлийн хуулийн этгээдээр сангийн хөрөнгийн удирдлагыг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

62.4.Сангийн хөрөнгө нь Монголбанкны хөрөнгө, бусад сангаас тусдаа байна.

62.5.Сангийн хөрөнгийг удирдахдаа банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд бэлэн байлгах нөхцөлийг хангана.

63 дугаар зүйл.Сангийн хөрөнгө, өр төлбөр

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

63.1.Сангийн хөрөнгө нь банкнаас төлсөн хураамжаас бүрдэнэ.

63.2.Энэ хуулийн 63.1-т заасан хураамжийн хувь хэмжээ, төлөх хугацааг

Монголбанк тогтооно.

63.3.Сангийн хөрөнгийг банкны системийн нийт хадгаламжийн 1.3 хувьтай тэнцүү байхаар бүрдүүлэх бөгөөд үүний 1 хувь нь банкнаас шилжүүлсэн мөнгөн хөрөнгө, 0.3 хувь нь сангийн онцгой төлбөрт ашиглах зорилго бүхий банкны хөрвөх чадвартай хөрөнгө байна.

63.4.Сангийн өр төлбөрийг сангийн хөрөнгөөр төлнө.

63.5.Банк нь хураамж төлснөөр зургаан сарын дотор хууль, журамд заасан өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шаардлагыг хангахааргүй бол Монголбанк энэ хуулийн 63.2-т заасан хугацаа, хэмжээг өөрөөр тогтоож болно.

64 дүгээр зүйл.Банкнаас сангийн хөрөнгийг бүрдүүлэх онцгой төлбөр

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

64.1.Сангийн хөрөнгө нь банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй бол Монголбанк энэ хуулийн 63.3-т заасан хөрөнгөөс хэтрэхгүй хэмжээний онцгой төлбөрийг банкнаас гаргуулах эрхтэй.

65 дугаар зүйл.Гадаад хамтын ажиллагаа

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

65.1.Монголбанк нь Монгол Улсад болон гадаад улсад үйл ажиллагаа эрхэлдэг аливаа банк, түүний банкны нэгдлийн үйл ажиллагааг хянан зохицуулах эрх бүхий гадаад улсын байгууллагатай хамтран банкны нэгдэлд авах бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга зам, хэлбэрийг тогтоох зорилгоор хамтын ажиллагааны гэрээ, хэлцэл байгуулж болно.

65.2.Энэ хуулийн 65.1-д заасан гэрээ, хэлцэл дараахь агуулгатай байна:

65.2.1.банкны урьдчилсан оролцоо болон банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний талаархи мэдээллийг тухай бүр харилцан солилцох;

65.2.2.банкны үйл ажиллагааг нөхөн сэргээх төлөвлөгөө, түүнд хийсэн дүн шинжилгээг тухай бүр харилцан солилцох;

65.2.3.тухайн банкны Монгол Улс дахь салбар, төлөөлөгчийн газрын удирдлага, хөрөнгийг захиран зарцуулах, бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг харилцан тохиролцож зохицуулах;

65.2.4.энэ хуулийн дагуу авч хэрэгжүүлэх бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний төлөвлөгөөг хамтран боловсруулах.

65.3.Энэ хуулийн 65.2-д заасан мэдээ, мэдээллийг дараахь нөхцөлд харилцан солилцож болно:

65.3.1.солилцох мэдээ, мэдээллийг ашиглах зорилго нь тодорхой байх;

65.3.2.энэ хуулийн 65.3.1-д заасан зорилгоос өөр зорилгоор ашиглах тохиолдолд Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авсан байх;

65.3.3.мэдээ, мэдээллийн нууцлал, түүний хадгалалт, хамгаалалт нь хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байх.

65.4.Монголбанк нь бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг Монгол Улсад үүсгэн байгуулагдаагүй, банкны үйл ажиллагааг нэг болон түүнээс дээш салбараараа дамжуулан эрхэлж байгаа хуулийн этгээдэд тухайн гадаад улсын эрх бүхий байгууллагаар дамжуулан хэрэгжүүлж болно.

65.5.Энэ хуулийн 65.4-т заасан арга хэмжээ нь Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангахад хангалттай бус гэж Монголбанкнаас үзсэн бол Монгол Улс дахь салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, энэ хуульд заасан албадлагын бусад арга хэмжээг авах эрхтэй.

66 дугаар зүйл. Үйл ажиллагааг түр түдгэлзүүлэх

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

66.1.Монголбанк нь бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авч байгаа банктай холбоотой дараахь үйл ажиллагааг түр түдгэлзүүлж болно:

66.1.1.банкинд авах арга хэмжээг хэрэгжүүлж байгаа банкны өмнө байгуулсан гэрээгээр хүлээсэн аливаа үүргийг гүйцэтгэхээс түр чөлөөлөх, зогсоох, түр түдгэлзүүлэх;

66.1.2.банкны хөрөнгөөс үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага хангуулах үйл ажиллагааг түр хугацаагаар хэсэгчлэн буюу бүхэлд нь түдгэлзүүлэх.

66.2.Монголбанк нь дараахь арга хэмжээг хэрэгжүүлж болно:

66.2.1.банкийг банкны зохистой хяналт шалгалтын шаардлагыг хэрэгжүүлэхээс түр чөлөөлөх;

66.2.2.банкны харилцагчтай хийх гүйлгээг зогсоох, гүйлгээ хийж байгаа газар, тооцооны төвийг түр хугацаагаар хаах;

66.2.3.банктай санхүүгийн хэлцэл хийсэн этгээдийн уг хэлцлийг хугацаанаас өмнө дуусгавар болох эрхийг түр түдгэлзүүлэх.

66.3.Энэ хуулийн 66.2-т заасан арга хэмжээг авах хугацаа 90 хоног байх бөгөөд энэ хугацааг хоёр удаа мөн хугацаагаар сунгаж болно.

/Энэ хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ хэсгийг 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

66.4.Банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах, түүнийг хэрэгжүүлэх шийдвэр нь тухайн банктай гэрээ байгуулсан этгээдэд гэрээгээ цуцлах эрх, эрхээ нэмэгдүүлэх давуу байдлыг бий болгохгүй бөгөөд энэ нь банкинд авах арга хэмжээг хэрэгжүүлж эхэлснээс хойш тухайн банкинд зээл олгосон этгээдийн гэрээний дагуу нэмж зээл олгох үүргээсээ татгалзах эрхийг хөндөхгүй.

66.5.Энэ зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлсэн тухайгаа Монголбанк олон нийтэд нэн даруй мэдээлнэ.

66.6.Банкинд авах арга хэмжээ хэрэгжүүлж байгаа банкны хөрөнгийг Монголбанкны зөвшөөрөлгүйгээр зарах, шилжүүлэх, хуваарилах, захиран зарцуулахыг хориглоно.

66.7.Энэ хуульд заасан бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах банкны хувьцаа эзэмшигч, үүрэг гүйцэтгүүлэгч нарын эд хөрөнгийн байдал нь тухайн банкийг

татан буулгаснаас дордохоор байна гэж Монголбанк үзвэл тухайн этгээд нь эд хөрөнгийн байдлаа сэргээхийг шаардах эрхтэй.

67 дугаар зүйл.Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг дуусгавар болгох

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

67.1.Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг Монголбанк дараахь үндэслэлээр дуусгавар болгоно:

67.1.1.банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах үндэслэл арилсан;

67.1.2.бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хэрэгслийг ашиглах шаардлагагүй болсон.

67.2.Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авагдаж байгаа банк нь Монголбанкнаас гаргасан журамд нийцэхүйц хангалттай хэмжээгээр дахин хөрөнгөжснөөс бусад тохиолдолд бүтцийн өөрчлөлтийн авах арга хэмжээ дуусгавар болсон бол банк байгуулах зөвшөөрлийг Монголбанк цуцлана.

67.3.Энэ хуулийн 67.1-д заасны дагуу бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний үр дүнд энэ хуульд заасан банкинд тавигдах шаардлагыг банк хангаж дахин хөрөнгөжсөн бол банкны хувьцаа эзэмшигчид банкны удирдлагын бүрэн эрхийг шилжүүлэх шийдвэрийг Монголбанк гаргах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн саналын эрх сэргэх, банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи бүрдэх хүртэл Монголбанк Төлөөлөн удирдах зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

67.4.Энэ хуулийн 67.2-т заасан шийдвэрт бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэгч этгээдийн бэлтгэсэн бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хэрэгсэл, гарсан зардлыг тусгасан тайланг хавсаргасан байна.

Тавдугаар дэд бүлэг Банкийг татан буулгах

/Энэ бүлгийн гарчгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

68 дугаар зүйл.Банкны эрх хүлээн авагчийг томилох

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

68.1.Монголбанк нь дараахь үндэслэлээр банкны эрх хүлээн авагч томилоно:

68.1.1.энэ хуульд заасан албадлагын арга хэмжээний хүрээнд банк байгуулах тусгай зөвшөөрлийг цуцалсан;

68.1.2.банкинд энэ хуульд заасан бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ хэрэгжүүлэх боломжгүй тухай Монголбанкны шийдвэр гарсан.

68.2.Монголбанкнаас бусад этгээд банкны эрх хүлээн авагч буюу дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх эрхгүй.

68.3.Банкны эрх хүлээн авагч нь банк, түүний эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх болон банкны хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй байх бөгөөд банкны активыг төлүүлэх, өр төлбөрийг барагдуулж, нэхэмжлэгчдийн шаардлагыг хангах,

орлогыг хуваарилах чиг үүрэгтэй байна.

68.4.Монголбанк нь энэ хуулийн 56.2-т заасан шаардлагыг хангасан өөрийн ажилтан, эсхүл бусад этгээдийг банкны эрх хүлээн авагчаар томилно.

68.5.Банкны эрх хүлээн авагчийн цалин хөлсийг Монголбанк тогтоож, банкны эрх хүлээн авахтай холбоотой зардлыг тухайн банкнаас гаргуулна.

68.6.Банкны эрх хүлээн авагч нь банкны эрх хүлээн авагч томилогдсон хугацаа, банк хадгаламжийн үйл ажиллагаа явуулахгүй тухай болон банкны эрх хүлээн авагчаас шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг тусгасан банкнийг татан буулгах тухай шийдвэрийг тухайн банкны бүх салбар, албан газарт нэн даруй байршуулж, олон нийтэд мэдээлнэ.

69 дүгээр зүйл.Банкны эрх хүлээн авагчийн бүрэн эрх

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

69.1.Банкны эрх хүлээн авагч дараахь бүрэн эрхтэй:

69.1.1.банкны хөрөнгийг захиран зарцуулах;

69.1.2.банкнийг төлөөлөх, удирдах;

69.1.3.банкны өр төлбөрийг хязгаарлах, шилжүүлэх, зогсоох;

69.1.4.зээл авах;

69.1.5.банкнаас байгуулсан хөдөлмөрийн болон бусад гэрээг цуцлах;

69.1.6.шаардлагатай ажилтан авах, чөлөөлөх;

69.1.7.банкны нэрийн өмнөөс гэрээ байгуулах;

69.1.8.банкны нэрийн өмнөөс Монголбанкнаас тогтоосон хэмжээг баримтлан төлбөр хийх.

69.1.9.банкнийг татан буулгах арга хэмжээний хүрээнд тухайн банктай холбогдох зарим үйл ажиллагааг үргэлжлүүлэх, зогсоох;

69.1.10.хадгаламжийн хүүгийн хувь хэмжээг тухайн үеийн хадгаламжийн хүүгийн доод хувь хэмжээнээс багагүй байхаар өөрчлөн тогтоох;

69.1.11.банкны хөрөнгө оруулалт хийхээр байгуулсан гэрээг цуцлах, зээлийн хүү, үйлчилгээний хөлсний хувь хэмжээ, хугацаанд өөрчлөлт оруулах;

69.1.12.банкны хадгаламж эзэмшигч, харилцагчид өгөх төлбөрөөс тухайн хадгаламж эзэмшигч, харилцагчдаас авах зээлийн төлбөрийг суутгах;

69.1.13.энэ хуулийн 56.7-д заасан үнэлгээг хийлгэх;

69.1.14.энэ хуулийн 35.8-д заасны дагуу банкны хувьцаа эзэмшигчдэд алдагдлыг хүлээлгэж, тэдгээрийн оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгө, бусад сангаас хасалт хийж санхүүгийн тайланд тусгах.

69.2.Банкны эрх хүлээн авагч банкнийг татан буулгах ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллийг Монголбанкинд хүргүүлж, Монголбанкнаас тогтоосон хугацаанд тайланг тогтмол ирүүлнэ.

69.3.Банкны эрх хүлээн авагч банкны хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.

69.4.Банкны эрх хүлээн авагч томилогдсон өдрөөс хойш 60 хоногийн дотор Монголбанкинд банкны санхүүгийн болон холбогдох бусад тайлан, хөрөнгийн бүртгэл, жагсаалтыг бэлтгэж хүргүүлнэ.

69.5.Хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, бусад ажилтан, хөндлөнгийн аудиторын үйл ажиллагаанд эдийн засгийн гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал илэрсэн бол банкны эрх хүлээн авагч Монголбанкинд нэн даруй мэдэгдэж, тухайн асуудлыг шалгуулж, шийдвэрлүүлэхээр хууль хяналтын холбогдох байгууллагад хандана.

69.6.Банкнаас хийгдсэн төлбөр, шилжүүлэг зарим этгээдийн эрх ашгийг бусдаас илүүд авч үзсэн байх шинжтэй бол банкны эрх хүлээн авах үйл ажиллагаа эхлэхээс өмнөх гурван сарын дотор хийгдсэн төлбөрийг, хэрэв төлбөр хүлээн авагч нь тухайн банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, тэдгээрт холбогдох этгээд байвал банкны эрхийг хүлээн авах үйл ажиллагаа эхлэхээс өмнөх 12 сарын дотор хийгдсэн бүх төлбөрийг доор дурдсанаас бусад тохиолдолд хүчингүйд тооцно:

69.6.1.Аливаа хадгаламж эзэмшигчид төлсөн төлбөр нь тухайн үед Монголбанкнаас тогтоосон нэг хадгаламж эзэмшигчид төлөх хязгаараас хэтрээгүй;

69.6.2.бусдад шилжүүлсэн хөрөнгө нь тухайн үеийн зах зээлийн үнээр төлөгдсөн;

69.6.3.банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтанд олгосон цалин хөлс нь тэдгээрт урьд олгож байсан цалин хөлсний ердийн хэмжээнээс хэтрээгүй шагнал, бусад тусгай нэмэгдэл үүнд хамаарахгүй;

69.6.4.залилах шинжтэйгээс бусад тохиолдолд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор тусгай зориулалтын компанид хөрөнгө шилжүүлсэн.

70 дугаар зүйл.Банкийг татан буулгах арга хэмжээ хэрэгжих нөхцөл

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

70.1.Банкинд эрх хүлээн авагч томилсон бол банкныг албадан татан буулгах арга хэмжээ дараахь нөхцөлийн дагуу хэрэгжинэ:

70.1.1.банкныг албадан татан буулгах шийдвэр гарснаас хойш хугацаанд Банкны гүйцэтгээгүй мөнгөн төлбөрийн үүрэгт хүү, алданги, торгууль тооцохгүй;

70.1.2.банкинд холбогдох иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80.1.1-д заасны дагуу түдгэлзүүлнэ;

70.1.3.банкны эрх хүлээн авагчаас бусад этгээд банкны хөрөнгөөс үл маргах журмаар аливаа шаардлагыг хангуулах эрхгүй;

70.1.4.банкны эрх хүлээн авах үйл ажиллагаа хэрэгжих хугацаанд урьд гарсан шүүхийн шийдвэрийн дагуу тухайн банкны зээлийн барьцаалсан эд хөрөнгө болон актив хөрөнгийг борлуулснаас орох орлогоос үл маргах журмаар төлбөр гүйцэтгэхийг хориглоно.

70.2.Банкийг албадан татан буулгахад хүндрэл учруулж болзошгүй, зарим

этгээдийн эрх ашгийг бусдаас илүүтэйд үзсэн шинжтэй, эсхүл банкны үйл ажиллагааг зохицуулахад болон харилцагч, хадгаламж эзэмшигч, банкинд зээлдүүлэгчийн эрх ашгийг хамгаалахад сөрөг нөлөөтэй, банкны гүйцэтгээгүй үүргээс банкны эрх хүлээн авагч татгалзах эрхтэй.

71 дүгээр зүйл. Мэдэгдэл болон нэхэмжлэл хүргүүлэх

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

71.1. Банкны эрх хүлээн авагч нь банкнаас үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авах хугацааг мэдэгдэл гаргаснаас хойш 60 хоног байхаар тогтоож, томилогдсон өдрөөс хойш хоёр сарын дотор банкны санхүүгийн тайлан, данс мэдээлэлд бүртгэгдсэн үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдэд мэдэгдэж олон нийтэд мэдээлнэ.

71.2. Энэ хуулийн 71.1-д заасан нэхэмжлэл хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш 90 хоногийн дотор банкны эрх хүлээн авагч дараахь шийдвэрийг гаргана:

71.2.1. нэхэмжлэлийн шаардлага хүчин төгөлдөр эсэхэд үндэслэл бүхий эргэлзээ байвал шаардлагыг хүлээн авахаас татгалзах;

71.2.2. банкнаас үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийн шаардлагын хэмжээг тодорхойлж, энэ хуульд заасны дагуу нэхэмжлэлийн дарааллыг тогтоох;

71.2.3. банкний албадан татан буулгах үүднээс банкны эрх хүлээн авагчийн цалин хөлс, зээлдүүлэгчийн нэрс, баталгаажсан нэхэмжлэл бүрийн үнийн дүн болон төлөх төлбөрийн нийт дүнг тусгасан татан буулгах арга хэмжээний төлөвлөгөө батлах;

71.2.4. нэхэмжлэлийн шаардлага болон түүний баталгаажсан хэмжээний талаар нэхэмжлэгч этгээдэд мэдэгдэх.

71.3. Банкны эрх хүлээн авагч нь энэ хуулийн 71.1-д заасан хугацаанд нэхэмжлэлээ ирүүлээгүй этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах эрхтэй.

72 дугаар зүйл. Хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцэл

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

72.1. Банкны эрх хүлээн авагч томилогдсоноос хойш нэг жилийн хугацаанд багтаан дараахь хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар эрх бүхий байгууллагад хандаж болно:

72.1.1. банкны эрх хүлээн авагч томилогдохоос өмнөх нэг жилийн хугацаанд банкинд илт хохиролтой байгуулсан хэлцэл;

72.1.2. банкны эрх хүлээн авагч томилогдохоос өмнөх зургаан сарын дотор банкнаас авлагатай этгээдийн шаардлагыг хангасан аливаа хэлцэл нь тухайн этгээдийн хувьд татан буулгах ажиллагаанаас олж авах байсан хөрөнгийг ихэсгэсэн хэлцэл;

72.1.3. банкны эрх хүлээн авагч томилогдохоос өмнөх нэг жилийн хугацаанд банкнаас холбогдох этгээдтэй хийсэн, банкны төлбөрийн чадвар алдагдахад

нөлөөлсөн хэлцэл.

73 дугаар зүйл.Төлбөр барагдуулах дараалал

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

73.1.Банкны хөрөнгийг худалдан борлуулсны орлогоос нэхэмжлэлийн шаардлагыг хангахад доор дурдсан дарааллыг баримтална:

73.1.1.бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах тухай шүүхийн шийдвэрийг үндэслэн тухайн банкнаас гаргуулж байсан төлбөр;

73.1.2.Монголбанкны болон эрх хүлээн авагчийн үйл ажиллагааны зардал;

73.1.3.Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон хувьцаа эзэмшигч нарын хадгаламжаас бусад Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан даатгагдсан хадгаламж, даатгагдсан хадгаламж эзэмшигчийн шаардах эрхийг шилжүүлсэн авсан Хадгаламжийн даатгалын корпорацийн шаардлага;

73.1.4.Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө;

73.1.5.даатгагдаагүй хадгаламжийн төлбөр;

73.1.6.банкны эрх бүхий албан тушаалтнаас бусад ажилтнуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй цалин хөлс;

73.1.7.Монголбанкны шаардах эрх бүхий төлбөрийн шаардлага;

73.1.8.Засгийн газарт төлөх өр төлбөр, албан татвар;

73.1.9.үүргийн гүйцэтгэлийг хангах аргаар баталгаажаагүй бусад өр төлбөр;

73.1.10.хоёрдогч өглөг.

73.2.Банкны хөрөнгийг худалдаж борлуулсны орлого нь нэхэмжлэлийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол дарааллын эхний төлбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний дараагийн төлбөрийн шаардлагыг хангана.

73.3.Нэг дараалалд орсон хэд хэдэн төлбөрийг нэгэн зэрэг барагдуулах боломжгүй бол тухайн төлбөр бүрийн хэмжээнд хувь тэнцүүлэх замаар нэхэмжлэлийн шаардлагыг хангаж болно.

73.4.Энэ хуулийн 73.1-д заасан төлбөрийг бүрэн барагдуулсны дараа үлдэх хөрөнгийг тухайн банкны хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн эрхийн дагуу хуваарилна.

74 дүгээр зүйл.Банкны эрх хүлээн авах арга хэмжээг дуусгавар болгох, тайлагнах

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

74.1.Банкны бүх хөрөнгийг худалдан борлуулсан, хуваарилсан, шилжүүлсний дараа банкны эрх хүлээн авагч нь банкныг татан буулгах ажиллагааны тайланг Монголбанкинд хүргүүлнэ.

74.2.Монголбанк банкны эрх хүлээн авагчийн тайланг хэлэлцэн баталж, банкны

эрх хүлээн авах арга хэмжээг дуусгавар болгосон бол энэ тухай шийдвэрийг холбогдох шүүхэд хүргүүлж, олон нийтэд мэдээлж банкнийг хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасуулах хүсэлтийг эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

74.3.Энэ хуулийн 74.2-т заасны дагуу олон нийтэд мэдээлснээр банкны эрх хүлээн авагчийн банк, банкнийг татан буулгах үйл ажиллагаатай холбоотой үүрэг дуусгавар болно.

75 дугаар зүйл. Эрх зүйн хамгаалалт

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./

75.1.Банкинд албадлагын арга хэмжээ авах тухай Монголбанкны шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл холбогдогч этгээд шүүхэд гомдол гаргах эрхтэй.

75.2.Гомдол гаргасан нь Монголбанк, энэ хуульд заасан бусад эрх бүхий этгээдийн шийдвэр, үйл ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

75.3.Шүүх энэ хуулийн 75.1-т заасан гомдлыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112.1-т заасан тусгай журмаар хянан шийдвэрлэнэ.

75.4.Банкинд албадлагын арга хэмжээ авсан Монголбанк, бүрэн эрхт төлөөлөгч, тусгай төлөөлөгч, эрх хүлээн авагчийн шийдвэр хууль бус, түүний улмаас гомдол гаргагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн болохыг шүүхээс тогтоосон тохиолдолд уг шийдвэр, түүнд үндэслэн гарсан бусад шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх, түдгэлзүүлэх үндэслэл болохгүй бөгөөд зөвхөн нэхэмжлэгчид учирсан бодит хохирлыг мөнгөн хэлбэрээр холбогдох хуульд заасны дагуу гаргуулахаар шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор банканд хийсэн активын чанарын үнэлгээ, бусад холбогдох хяналт шалгалтын үр дүнд гарсан өөрийн хөрөнгийн дутагдлыг банкны хувьцаа эзэмшигч, бусад хөрөнгө оруулагчаар хангуулах, шаардлагатай бол төрөөс банкнийг дахин хөрөнгөжүүлэх, оруулсан хөрөнгийг удирдах, төсөвт буцаан төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль тогтоомж

2.1.Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль тогтоомж нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Банкны системд нөлөө бүхий, дунд хугацаанд хэвийн үйл ажиллагаа явуулах боломжтой банкны өөрийн хөрөнгийн шаардлагыг хангуулах, төрөөс банкнийг дахин хөрөнгөжүүлэхтэй холбогдох харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Банкны тухай хуульд заасны дагуу банканд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авахтай холбогдох харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

4 дүгээр зүйл.Нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“банкны активын чанарын үнэлгээ” гэж банканд хийх хяналт шалгалтын хүрээнд банкны активын чанарыг бодитой тогтоох зорилгоор хийх үнэлгээг;

4.1.2.“өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагын мэдэгдэл” гэж Монголбанкнаас банканд өөрийн хөрөнгийн шаардлагыг хангуулахаар энэ хуулийн 5.1-д заасны дагуу хүргүүлсэн мэдэгдлийг;

4.1.3.“банкны системд нөлөө бүхий банк” гэж сүүлийн 6 сарын турш банкны системийн нийт активын 5 хувиас дээш хувийг эзэлж байгаа банкийг;

4.1.4.“банкийг шинэчлэх төлөвлөгөө” гэж эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамааран банк өөрийн хөрөнгийн шаардлагыг хангахуйц хэмжээнд нэмэгдүүлэх, цаашид тогтмол ашигтай ажиллах, төрөөс оруулсан хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэх талаарх стратегийг багтаасан гурван жилийн дэлгэрэнгүй бизнес төлөвлөгөөг;

4.1.5.“хамтран ажиллах гэрээ” гэж төрөөс дахин хөрөнгөжүүлж байгаа банк санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан банкийг шинэчлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүлээх үүрэг, хамтын ажиллагааны хүрээ, төрөөс оруулсан хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэх, банкийг шинэчлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг мэдээлэх болон талуудын бусад эрх, үүргийг тодорхойлсон хэлцлийг;

4.1.6.“дунд хугацаанд банкны хэвийн үйл ажиллагаа явуулах боломжтой” гэж банк хэвийн үйл ажиллагаа явуулах замаар 5 жилийн хугацаанд цаашид төрөөс хөрөнгийн дэмжлэггүйгээр ашигтай ажиллахыг;

4.1.7.“нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө” гэж банкны энгийн хувьцаа, түүнтэй дүйцэхүйц давуу эрхийн хувьцаа, цэвэр ашгаас байгуулсан нөөцийн сан, хуримтлагдсан ашиг алдагдал, нэмж төлөгдсөн энгийн хувьцаа, хандивын хөрөнгө;

4.1.8.“хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө” гэж энэ хуулийн 4.1.7-д зааснаас бусад давуу эрхтэй хувьцаа, нэмж төлөгдсөн давуу эрхийн хувьцаа, дахин үнэлгээний нэмэгдэл, нийгмийн хөгжлийн сан, хувьцаанд хөрвөх бусад үнэт цаас.

ХОЁРДУГААР БҮЛЭГ БАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ШААРДЛАГЫГ ХАНГУУЛАХ, ХҮСЭЛТ ГАРГАХ, ХҮСЭЛТИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

5 дугаар зүйл.Банкны өөрийн хөрөнгийн шаардлагыг хангуулах

5.1.Активын чанарын үнэлгээ, бусад холбогдох хяналт шалгалтын үр дүнд банк өөрийн хөрөнгийн шаардлагыг хангаагүй бол Монголбанк энэ талаар банканд нэн

даруй мэдэгдэнэ.

5.2. Монголбанк энэ хуулийн 5.1-д заасан мэдэгдлийг хүргүүлснээс хойш ажлын гурван өдрийн дотор банкны өөрийн хөрөнгийн дутагдлын хэмжээг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдэд хүргүүлнэ.

5.3. Банк энэ хуулийн 5.1-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш өөрийн хөрөнгийн шаардлагыг 6 сарын дотор хангана.

6 дугаар зүйл. Банк өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа

6.1. Банк Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн шаардлагыг төр, төрийн өмчит хуулийн этгээдээс бусад хөрөнгө оруулагчдаас банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг энгийн хувьцаа, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг энгийн хувьцаанд хөрвөх давуу эрхийн хувьцаагаар нэмэгдүүлнэ.

6.2. Банк өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр гаргасан нэг болон хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд тооцогдох санхүүгийн хэрэгслийг шууд болон шууд бусаар өөрөө худалдаж авах, санхүүжүүлэхийг хориглоно.

6.3. Банк энэ хуульд заасан өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр гаргасан нэг болон хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд тооцогдох санхүүгийн хэрэгслийг зээл, эсхүл ямар нэг үүрэг амлалтын хүрээнд барьцаалахыг хориглоно.

6.4. Банк энэ хуульд заасан өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор гаргасан хувьцааг гадаад болон дотоодын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аливаа хуулийн этгээд, нийгмийн даатгалын сан, нутгийн өөрөө удирдах байгууллагад худалдахыг хориглоно.

7 дугаар зүйл. Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

7.1. Банк энэ хуулийн 5.3-т заасан хугацаанд бусад хөрөнгө оруулагчдаас өөрийн хөрөнгийн шаардлагыг бүрэн хангах боломжгүй гэж үзвэл дахин хөрөнгөжүүлэх хүсэлтийг банкны шинэчлэх төлөвлөгөөний хамт нэн даруй, эсхүл энэ хуулийн 5.3-т заасан хугацаанаас 30 хоногийн өмнө Монголбанканд гаргана.

7.2. Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах банк энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан шалгуурыг бүрэн хангасан байна.

7.3. Монголбанк банкныг шинэчлэх төлөвлөгөөг сайжруулах, шинэчлэх арга хэмжээ авах, нэмэлт баримт бичиг, мэдээлэл ирүүлэхийг тухайн банкнаас шаардаж болно.

7.4. Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах, банкныг шинэчлэх төлөвлөгөөний агуулга, загвар, тус төлөвлөгөөнд тавих нөхцөл, шаардлага, журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монголбанк батална.

7.5. Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргасан банк нь дунд хугацаанд банкны хэвийн үйл ажиллагаа явуулах боломжтой, банкны системд нөлөө бүхий, энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан шалгуурыг бүрэн хангасан эсэхийг Монголбанк нэг сарын дотор хянан баталгаажуулна.

7.6. Энэ хуулийн 7.5-д заасан шаардлага хангасан гэдгийг Монголбанкнаас

тодорхойлсон бол тухайн банкийг дахин хөрөнгөжүүлэх шаардлагатай эсэх талаарх саналыг энэ хуулийн 8.1.3-т заасан төлөвлөгөөний хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэн даруй хүргүүлнэ.

7.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төрөөс банкийг дахин хөрөнгөжүүлэх саналыг ажлын 3 өдрийн дотор Засгийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРӨӨС БАНКИЙГ ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ

8 дугаар зүйл. Төрөөс банкийг дахин хөрөнгөжүүлэх нөхцөл

8.1.Төрөөс банкийг дахин хөрөнгөжүүлэхээс өмнө банк доор дурдсан шаардлагыг хангасан байна:

8.1.1.банк бусад эх үүсвэр, хөрөнгө оруулагчаас энэ хуулийн 5.3-т заасан хугацааны дотор өөрийн хөрөнгийн шаардлагыг бүрэн хангах боломжгүй;

8.1.2.тухайн банкийг төрөөс дахин хөрөнгөжүүлэх нь банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай гэж Монголбанк дүгнэсэн;

8.1.3.Монголбанкнаас банкийг шинэчлэх төлөвлөгөөг зөвшөөрсөн;

8.1.4.банкны системд нөлөө бүхий, дунд хугацаанд банкны хэвийн үйл ажиллагаа явуулах, тогтвортой ашигтай ажиллах боломжтой гэж Монголбанк дүгнэсэн;

8.1.5.активын чанарын үнэлгээ, бусад холбогдох хяналт шалгалтын үр дүнд Монголбанкнаас шаардсаны дагуу эрсдэлийн тусгай болон ерөнхий санг байгуулсан;

8.1.6.активын чанарын үнэлгээ, бусад холбогдох хяналт шалгалтын үр дүнгээр тогтоосон банкны алдагдлыг банкны тухайн үеийн өөрийн хөрөнгөөр санхүүгийн хариуцлага хүлээлгэсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын хүчин төгөлдөр шийдвэр гарсан байх;

8.1.7.төрөөс банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг дахин хөрөнгөжүүлэх шаардлагатай бол хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд урьдчилан хөрвүүлсэн байх;

8.1.8.энэ хуулийн 8.1.6-д заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нэгдүгээр зэрэглэлийн болон хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг хангалттай хэмжээгээр бууруулсан болохыг Монголбанк тодорхойлсон;

8.1.9.банк хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд хөрвүүлэх үнийг Монголбанкнаас зөвшөөрсөн;

8.1.10.энэ хуулийн 7.1-д заасан хүсэлт гаргасан банк санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулахыг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан.

8.2.Банкны системд нөлөө бүхий, дунд хугацаанд банкны хэвийн үйл

ажиллагаа явуулах, тогтвортой ашигтай ажиллах боломжтой банк нь энэ хуулийн 5.3-т заасан хугацаанд энэ хуулийн 8.1-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд Монголбанк тус шаардлагыг нэг сарын дотор хангуулахаар Банкны тухай хуульд заасан албадлагын арга хэмжээг банканд авна.

8.3.Монголбанк энэ хуулийн 8.2-т заасан арга хэмжээг авч хэрэгжүүлж, энэ хуулийн 8.1-т заасан шаардлагыг бүрэн хангасан гэж үзсэн тохиолдолд энэ хуульд заасны дагуу төрөөс банкныг дахин хөрөнгөжүүлж болно.

8.4.Энэ хуулийн 8.2-т заасан албадлагын арга хэмжээ авсан банканд төрөөс банкныг дахин хөрөнгөжүүлэх сүүлийн хугацаа энэ хуулийн 5.3-т зааснаас хойш нэг сарын хугацаанд байна.

9 дүгээр зүйл.Төрөөс банкныг дахин хөрөнгөжүүлэх хэлбэр

9.1.Төрөөс банкныг дараах хэлбэрээр дахин хөрөнгөжүүлж болно:

9.1.1.зах зээлийн нөхцөлтэй Засгийн газрын үнэт цаас;

9.1.2.мөнгөн хөрөнгө.

10 дугаар зүйл.Төрөөс банкныг дахин хөрөнгөжүүлэх

10.1.Энэ хуулийн 7.1-д заасан хүсэлт гаргаж, шаардлага хангасан банк нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулна.

10.2.Төрөөс банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг энгийн хувьцаа, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг хэлбэрээр тухайн банкны өөрийн хөрөнгийн шаардлагыг хангахуйц хэмжээнд нэмэгдүүлнэ.

10.3.Энэ хуулийн 8.1-д заасан шаардлагыг хангасан банк нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдлыг бусад хөрөнгө оруулагчаас бүрдүүлж чадаагүй бол төр тухайн банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдсан хэсгийг бүрдүүлнэ.

10.4.Бусад хөрөнгө оруулагч нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдлын 50-аас багагүй хувийг бүрдүүлсэн тохиолдолд төрөөс тухайн банкны нэгдүгээр болон хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдлын үлдэх хэсгийг бүрдүүлнэ.

10.5.Бусад хөрөнгө оруулагч нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдлын 50-аас доош хувийг бүрдүүлсэн тохиолдолд төрөөс тухайн банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдлын үлдэх хэсгийг, харин хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдлын 50 хувийг энгийн хувьцаагаар, үлдэх 50 хувийг хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг хэлбэрээр бүрдүүлнэ.

10.6.Банк зөвхөн хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хүсэлт гаргасан бол төрөөс хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг хэлбэрээр нэмэгдүүлнэ.

10.7.Банк өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй хэлбэрээр хувьцаа гаргасан бол төрөөс нээлттэй зах зээл дээр арилжаалагдсан үнээр хөрөнгө оруулна.

10.8.Банк өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр хувьцаа хаалттай хэлбэрээр гаргаж бусад хөрөнгө оруулагчид хувьцааны 50-аас багагүй хувьд хөрөнгө оруулсан бол төр бусад хөрөнгө оруулагчтай тохиролцсон үнээр тухайн банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдлын үлдэх хэсэгт хөрөнгө оруулна.

10.9.Банк өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр хувьцаа хаалттай хэлбэрээр гаргаж бусад хөрөнгө оруулагчид хувьцааны 50-аас бага хувьд хөрөнгө оруулсан бол санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч хамтарч тогтоосон дээд үнээс илүү үнээр хөрөнгө оруулахгүй.

10.10.Энэ хуульд заасан хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг, давуу эрхийн хувьцааны нөхцөлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч хамтран баталсан журмаар тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ **БАНКАНД ТӨРӨӨС ОРУУЛСАН ХӨРӨНГИЙГ УДИРДАХ, ТӨРИЙН** **БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ**

11 дүгээр зүйл.Банканд төрөөс оруулсан хөрөнгийг удирдах

11.1.Банканд төрөөс оруулсан хөрөнгийн эрхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зах зээлийн зарчмыг баримтлан үр ашигтай хэлбэрээр удирдаж, хэрэгжүүлнэ.

11.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрөөс дахин хөрөнгөжүүлсэнтэй холбоотойгоор дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.2.1.энэ хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх зорилгоор төрөөс банкныг дахин хөрөнгөжүүлэхээс өмнө энэ хуулийн 10.1-д заасан гэрээг байгуулах;

11.2.2.Компанийн тухай хууль болон энэ хуульд заасны дагуу банкны хувьцаа эзэмшигчийн эрхийг эдлэх;

11.2.3.банканд төрөөс оруулсан хөрөнгийг хамтран ажиллах гэрээ, банкны дүрэм, зохих хууль тогтоомжийн дагуу хэсэгчлэн болон бүхэлд нь худалдах;

11.2.4.банканд төрөөс оруулсан хөрөнгийг худалдах, тус хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

11.2.5.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан банканд төрөөс оруулсан хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх;

11.2.6.дахин хөрөнгөжүүлсэн банкны үйл ажиллагааны болон оруулсан хөрөнгийн талаарх мэдээллийг хагас жил тутамд Засгийн газарт тайлагнаж, тайланг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд хүргүүлэх;

11.2.7.энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлага хангасан төрийг төлөөлөх нэг төлөөлөгчийг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд сонгуулахаар томилох;

11.2.8.тухайн банканд төрийн эзэмшиж байгаа хувьцааны хэмжээнээс хамааран төлөөлөн удирдах зөвлөлийн бусад гишүүнийг холбогдох хууль

тогтоомжийн дагуу Монголбанкны зөвшөөрлөөр сонгуулахаар томилох.

11.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуульд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн эзэмшлийн хувьцааны саналын эрхийг эдлэх бөгөөд төрийн эзэмшлийн хувьцаа банкны нийт хувьцааны 10 хувиас дээш тохиолдолд банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын дараах тогтоол, шийдвэрт хориг тавих эрхтэй:

11.3.1.банкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

11.3.2.банкны өөрийн хөрөнгийн хэмжээг өөрчлөх;

11.3.3.банкийг нэгтгэх, нийлүүлэх, хуваах, өөрчлөн байгуулах, татан буулгах;

11.3.4.банкийг шинэчлэх төлөвлөгөөний хэрэгжилт.

11.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Монголбанкттай төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банкны талаар мэдээлэл харилцан солилцох, мэдээллийн нууцыг задруулахгүй байх талаар гэрээ байгуулна.

12 дугаар зүйл. Дахин хөрөнгөжүүлсэн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төрийг төлөөлөх төлөөлөл

12.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дахин хөрөнгөжүүлсэн банканд төрөөс оруулсан хөрөнгийн бүрэн эрхийг өөрийн томилсон энэ хуулийн 11.2.7-д заасан төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлнэ.

12.2.Дахин хөрөнгөжүүлсэн банканд төрийг төлөөлөн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллах энэ хуулийн 11.2.8-д заасан бусад гишүүн нь доор дурдсан шалгуурыг хангасан байна:

12.2.1.Банкны тухай хуульд заасан банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, хараат бус гишүүнд тавих шалгуурыг хангасан;

12.2.2.сүүлийн таван жилийн хугацаанд төрийн улс төрийн болон захиргааны албан тушаалтан, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа банкны эрх бүхий албан тушаалтан байгаагүй;

12.2.3.тухайн банкны хувьцааг эзэмшдэггүй.

12.3.Дахин хөрөнгөжүүлсэн банканд энэ хуулийн 11.2.8-д заасан төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах гишүүнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэг хамаарахгүй.

12.4.Дахин хөрөнгөжүүлсэн банканд төрийг төлөөлөн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллах энэ хуулийн 11.2.7-д заасан төлөөлөгч нь доор дурдсан шалгуурыг хангасан байна:

12.4.1.Банкны тухай хуульд заасан банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, хараат бус гишүүнд тавих шалгуурыг хангасан;

12.4.2.сүүлийн таван жилийн хугацаанд төрийн улс төрийн албан тушаалтан, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа банкны эрх бүхий албан тушаалтан байгаагүй;

12.4.3. тухайн банкны хувьцааг эзэмшдэггүй.

12.5. Төр банкны нийт хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшдэг бол төлөөлөн удирдах зөвлөлд энэ хуулийн 12.1-т заасан төрийг төлөөлөх этгээд дараах нэмэлт тусгай эрхийг эдэлнэ:

12.5.1. төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулах санал гаргах;

12.5.2. энэ хуулийн 11.3-т заасан төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан аливаа шийдвэрт хориг тавих.

12.6. Банкны төлөөлөн удирдах зөвлөлд энэ хуулийн 12.1-т заасан төрийг төлөөлөх этгээд өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ тухайн банкны бие даасан байдлыг эрхэмлэнэ.

12.7. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монголбанкны төлөөллийн 5 гишүүн бүхий нэр дэвшүүлэх хорооноос банкны төлөөлөн удирдах зөвлөлд энэ хуулийн 11.2.8-д заасан төрийг төлөөлөх бусад гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалт хийх замаар санал болгоно.

12.8. Энэ хуулийн 11.2.7-д заасан төлөөлөгч нь банкны хэвийн үйл ажиллагаа, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашиг, банкны хөрвөх чадвар, төлбөрийн чадварыг алдагдуулах талаар төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан аливаа шийдвэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монголбанканд мэдээлэх үүрэгтэй.

12.9. Энэ хуулийн 11.2.8-д заасан бусад гишүүн нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас чиглэл авахгүй, бие даасан байдлаар банкны төлөөлөн удирдах зөвлөлд шийдвэр гаргана.

12.10. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хоёр жилийн хугацаатай томилох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг доор дурдсан тохиолдолд хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно:

12.10.1. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь банкны хувьцаа эзэмшигч, эсхүл банкны ажилтан болсон бол;

12.10.2. эрүүл мэндийн болон бусад шалтгааны улмаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

12.10.3. эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн;

12.10.4. ашиг сонирхлын зөрчил үүссэн.

12.11. Банкны гүйцэтгэх удирдлагыг Компанийн тухай хууль болон Банкны тухай хуульд заасны дагуу банкны төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр томилж, чөлөөлнө.

13 дугаар зүйл. Банканд төрөөс оруулсан хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэх

13.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн банканд төрөөс оруулсан хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэх төлөвлөгөөг Монголбанкны саналыг харгалзан баталж, хэрэгжүүлнэ.

13.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь

энэ хуулийн 13.1-д заасан төлөвлөгөөний дагуу тухайн банканд төрөөс оруулсан хөрөнгийг энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн дотор төсөвт буцаан төвлөрүүлнэ.

13.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь банканд төрөөс оруулсан хөрөнгийг нийтэд нээлттэй болон хаалттай хэлбэрээр худалдаж болно.

13.4.Энэ хуулийн 13.1-д заасан төлөвлөгөөний хүрээнд банканд төрөөс оруулсан хөрөнгийг худалдах үнийг төр тус банкны хувьцааг худалдаж авсан үнэ, эсхүл тухайн үеийн зах зээлийн үнээр тогтооно.

13.5.Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банканд төрөөс оруулсан хөрөнгийг удирдах, хянах, төсөвт буцаан төвлөрүүлэхтэй холбогдох журмыг Монголбанкны саналыг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

ТӨРӨӨС ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛСЭН БАНКАНД ХИЙХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ

14 дүгээр зүйл.Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банканд хийх Монголбанкны хяналт шалгалт

14.1.Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банканд Монголбанк дараах байдлаар хяналт шалгалт хийнэ:

14.1.1.банкийг шинэчлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах, хугацаатай үүрэг, даалгавар өгөх, хуульд заасан шаардлагатай арга хэмжээ авах, шийдвэр гаргах;

14.1.2.төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банк энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол Монголбанк хуульд заасан хяналт шалгалтын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, албадлагын арга хэмжээ авах.

14.2.Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банкны төлөөлөн удирдах зөвлөл банкныг шинэчлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх тайланг Монголбанканд хүргүүлээгүй, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, хэрэгжүүлэхээс татгалзсан бол Монголбанк, Банкны тухай хуулийн 48.1.12-48.1.14-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

14.3.Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банкнаас төрийн улс төрийн албан тушаалтан, улс төрийн нам, түүний холбогдох болон харилцан хамаарал бүхий этгээдэд шинээр зээл, санхүүжилт олгохыг хориглоно.

14.4.Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банканд Монголбанкнаас аливаа нэмэлт шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож болно.

14.5.Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банк хувьцааны ногдол ашгийг зөвхөн Монголбанкны зөвшөөрлөөр хуваарилж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

БУСАД

15 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

15.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтан, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

БАНКИН ДАХЬ МӨНГӨН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь банкны мөнгөн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий банкн дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоож, хадгаламжийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль тогтоомж

2.1.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай, Банкны тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“Хадгаламжийн даатгалын корпораци” гэж энэ хуульд заасан банкн дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулах тусгайлсан чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;

3.1.2.“хадгаламжийн даатгалын үйл ажиллагаа” гэж энэ хуульд заасны дагуу банкнаас харилцах болон хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгийг Хадгаламжийн даатгалын корпорацид даатгуулах, даатгалын тохиолдол бий болоход хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр төлөх, банкны актив, пассивыг шилжүүлэх, тусгай зориулалтын банк байгуулах үед шилжүүлэн авч байгаа банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг;

/Энэ заалтыг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3.1.3.“банк” гэж Банкны тухай хуулийн 3.1.1-д заасан хуулийн этгээдийг болон мөн хуульд заасны дагуу Монголбанкнаас зөвшөөрөл авч, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай банк, банкны салбарыг;

3.1.4.“хадгаламж” гэж банкин дахь харилцах болон мөнгөн хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгийг;

/Энэ заалтыг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3.1.5.“хадгаламжийн даатгалын сан” гэж энэ хуулийн 10.2-т заасан эх үүсвэрээс бүрдсэн, энэ хуулийн 11.1-д заасан зориулалтаар зарцуулах хөрөнгийг;

3.1.6.“даатгалын тохиолдол” гэж Банкны тухай хуульд заасны дагуу Монголбанк банкныг албадан татан буулгах тухай шийдвэр гаргасныг;

/Энэ заалтыг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3.1.7.“хамтарсан данс” гэж банкин дахь дангаар, эсхүл хамтран захиран зарцуулах эрхтэй хоёр буюу түүнээс дээш этгээдийн эзэмшлийн нэг дансыг.

3.1.8.“санхүүгийн дэмжлэг” гэж банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд банкны актив, пассивыг шилжүүлэн авч байгаа банкинд актив, пассивын зөрүүг нөхөх, эсхүл тусгай зориулалтын банкны өөрийн хөрөнгөд хөрөнгө оруулах зорилгоор Хадгаламжийн даатгалын корпорациас мөнгөн хөрөнгө шилжүүлэхийг;

/Энэ заалтыг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

4 дүгээр зүйл.Банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын зарчим

4.1.Банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгал /цаашид “хадгаламжийн даатгал” гэх/-ын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1.санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах;

4.1.2.энэ хуулийн 8.1-д заасан даатгалын нөхөн төлбөрийг төлөхдөө тухайн банкны хадгаламж эзэмшигч бүрийг хамруулах;

4.1.3.Банкны тухай хуулийн 6.1.1, 6.1.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий банк хадгаламжийн даатгалд хамрагдах;

4.1.4.ил тод, хариуцлагатай байх.

5 дугаар зүйл.Хадгаламжийн даатгал

5.1.Банкны тухай хуулийн 6.1.1, 6.1.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий банк хадгаламж эзэмшигчийн хадгаламжийг энэ хуульд заасны дагуу хадгаламжийн даатгалд заавал даатгуулж, даатгалын хураамж төлнө.

5.2.Монголбанк банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон тухай бүр энэ тухай Хадгаламжийн даатгалын корпорацид мэдэгдэнэ.

5.3.Хадгаламжийн даатгалын корпораци энэ хуулийн 5.1-д заасны дагуу хадгаламжийн даатгалын үйл ажиллагаанд оролцож байгааг нотолсон гэрчилгээг тухайн банкинд олгоно.

5.4.Дараах тохиолдолд хадгаламжийн даатгалын үйл ажиллагаанд банкны оролцох оролцоо дуусгавар болно:

5.4.1.даатгалын нөхөн төлбөрийг олгож дууссан;

/Энэ заалтад 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

5.4.2.банкийг улсын бүртгэлээс хассан.

5.4.3.Энэ хуулийн 11.1.2-т зааснаар шилжүүлэн авч байгаа банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

/Энэ заалтыг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

6 дугаар зүйл.Даатгалын тохиолдол

6.1.Энэ хуулийн 3.1.6-д заасан шийдвэр гарсан өдрийг даатгалын тохиолдол бий болсон өдөрт тооцно.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

6.2.Монголбанк нь энэ хуулийн 3.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэрийг гаргамагц энэ тухай Хадгаламжийн даатгалын корпорацид мэдэгдэх үүрэгтэй.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

6.3.Даатгалын тохиолдол бий болоход хадгаламж эзэмшигчид энэ хуульд заасны дагуу Хадгаламжийн даатгалын корпорациас даатгалын нөхөн төлбөр шаардах эрх үүснэ.

6.4.Энэ хуулийн 11.1.2-т зааснаар санхүүгийн дэмжлэг үзүүлсэн тохиолдолд хадгаламж эзэмшигчийн нөхөн төлбөрийг олгосонд тооцно.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

7 дугаар зүйл.Даатгалд үл хамаарах нөхцөл

7.1.Дараах хадгаламж хадгаламжийн даатгалд хамаарахгүй:

7.1.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан этгээдийн нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр нээсэн данс;

7.1.2.нэргүй хадгаламжийн сертификат болон бусад төрлийн нэргүй санхүүгийн хэрэгсэл;

7.1.3.нэрлэсэн үнээр эргэж төлөгдөхгүй хадгаламж.

7.2.Дараах этгээдийн хадгаламж хадгаламжийн даатгалд хамаарахгүй:

7.2.1.банк;

7.2.2.төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага;

7.2.3.эрүүл мэндийн, тэтгэврийн болон нийгмийн албан журмын даатгалын сан;

7.2.4.Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан банкны холбогдох этгээд;

7.2.5.даатгалын тохиолдол бий болохоос өмнөх гурван жилийн хугацаанд банкны санхүүгийн тайланд аудит хийсэн аудитор болон аудитын байгууллага;

7.2.6.Монголбанкны хяналт шалгалтын тайлангаар банкны санхүүгийн байдал муудахад нөлөөлсөн, банкны үйлчилгээ авахдаа санхүүгийн давуу эрх эдэлсэн нь тогтоогдсон дор дурдсан хадгаламж эзэмшигч.

7.2.6.а.гүйлгээний төрөл, эрсдэлийн түвшин, зээлдэгчийн төлбөрийн чадвар болон барьцааны төрөл зэргийг харгалзан үзэхэд бусад хадгаламж эзэмшигчээс онцгой нөхцөлтэй зээл авсан;

7.2.6.б.банкны бусад хадгаламж эзэмшигчээс илт бага хүүтэй зээл авсан;

7.2.6.в.даатгалын тохиолдол бий болох үед Монголбанкны статистик мэдээллээр хадгаламж эзэмшигчдийн авч байгаа хадгаламжийн дундаж хүүгээс 50 хувиас илүү хүү авсан.

7.3.Даатгалын тохиолдол бий болоход энэ хуулийн 7.2-т заасан этгээдэд даатгалын нөхөн төлбөр төлөхгүй.

7.4.Даатгалын тохиолдол бий болоход Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу битүүмжилсэн болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 11.1-д заасны дагуу гүйлгээг нь түдгэлзүүлсэн дансны хадгаламж эзэмшигчид зөвхөн битүүмжлэх болон гүйлгээг түдгэлзүүлэх шийдвэр хүчингүй болсон тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг олгоно.

/Энэ хэсэгт 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

8 дугаар зүйл. Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ

8.1.Даатгалын тохиолдол бий болоход Хадгаламжийн даатгалын корпораци хадгаламж эзэмшигчийн тухайн банкин дахь төгрөг ба валютын нийт 20 сая хүртэл төгрөгийн хадгаламжийг нөхөн төлнө.

9 дүгээр зүйл. Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох

9.1.Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг тооцохдоо хадгаламж эзэмшигч бүрийн тухайн банкинд эзэмшиж байгаа нийт хадгаламжийн дүн болон гэрээний дагуу хуримтлагдсан хүүгийн дүнг даатгалын тохиолдол бий болсон өдрийн байдлаар нэгтгэж, хадгаламж эзэмшигчээс тухайн банкинд төлбөл зохих 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн зээл, хүүгийн хамт хасч тодорхойлно.

/Энэ хэсэгт 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

9.2.Хадгаламж эзэмшигч даатгалын тохиолдол бий болсон банкинд хэд хэдэн хадгаламжийн данстай бол түүний бүх дансыг нэг дансанд энэ хуулийн 15.4-д заасан ханшаар тооцож нэгтгэн даатгалын нөхөн төлбөрийг тооцно.

/Энэ хэсэгт 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

9.3.Хамтарсан данс эзэмшигчдэд төлөх даатгалын нөхөн төлбөрийн нийт хэмжээ энэ хуулийн 8.1-д заасан хэмжээнээс илүүгүй байна.

9.4.Хамтарсан дансан дахь эзэмшлийн хувь нь тэнцүү биш гэдгийг нотолсон баримт гаргаснаас бусад тохиолдолд хамтарсан данс эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөрийг тэнцүү хувааж тооцно.

9.5.Насанд хүрээгүй хамтарсан данс эзэмшигчийн даатгалын нөхөн төлбөр авах эрх тухайн хадгаламжийг бусад этгээдтэй хамтран эзэмшиж байгаагаар хязгаарлагдахгүй.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

10 дугаар зүйл.Хадгаламжийн даатгалын сан, түүний эх үүсвэр

10.1.Хадгаламжийн даатгалын сан /цаашид “Сан” гэх/-гийн удирдлагыг Хадгаламжийн даатгалын корпораци хэрэгжүүлнэ.

10.2.Сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

10.2.1.Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийн 2.5-д заасны дагуу тухайн банкнаас Засгийн газрын Монголбанкн дахь тусгай дансанд төвлөрүүлсэн шимтгэл;

10.2.2.улсын төсвөөс Санд оруулсан эхлэлтийн хөрөнгө;

10.2.3.Монголбанкнаас Санд оруулсан эхлэлтийн хөрөнгө;

10.2.4.хадгаламжийн даатгалын хураамж;

10.2.5.Сангийн хөрөнгө оруулалтаас олсон орлого;

10.2.6.даатгалын тохиолдол бий болсон банкны актив хөрөнгийг борлуулсны орлого;

10.2.7.Засгийн газар, Монголбанк, олон улсын байгууллагаас олгосон зээл, тусламж, бусад санхүүжилт;

10.2.8.гадаадын банк болон олон улсын санхүүгийн байгууллагаас Хадгаламжийн даатгалын корпорацийн авсан зээл;

10.2.9.Хадгаламжийн даатгалын корпорацийн гаргасан бондын эх үүсвэр;

10.2.10.нөхөн төлбөр олгох хугацаа дууссаны дараа энэ хуулийн 16.1-д заасан банкинд үлдсэн нөхөн төлбөрийн хөрөнгө;

/Энэ заалтыг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

10.2.11.хуульд заасан бусад эх үүсвэр.

/Энэ заалтын дугаарт 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

11 дүгээр зүйл. Сангийн актив хөрөнгийн зарцуулалт

11.1. Сангийн актив хөрөнгийг дор дурдсанаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно:

11.1.1. хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр төлөх;

11.1.2. банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд банкны актив, пассивыг шилжүүлэн авч байгаа банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

/Энэ заалтыг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

11.1.3. Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх;

11.1.4. Хадгаламжийн даатгалын корпорацийн авсан зээл болон гаргасан бондын үндсэн өр, хүүгийн төлбөр төлөх.

11.2. Энэ хуулийн 11.1.2-т заасан санхүүгийн дэмжлэг, түүнтэй холбоотой гарах зардлын нийлбэр нь даатгалын нөхөн төлбөр олгоход шаардагдах хөрөнгө, түүнтэй холбоотой гарах зардлын нийлбэрээс бага байх тохиолдолд санхүүгийн дэмжлэгийг үзүүлнэ.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

11.3. Энэ хуулийн 11.1.2-т заасан санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх журмыг энэ хуулийн 22.1-д заасан Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батална.

12 дугаар зүйл. Сангийн хөрөнгө оруулалт

12.1. Хадгаламжийн даатгалын корпораци Сангийн актив хөрөнгийг аюулгүй, хөрвөх чадвартай, ашигтай байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд байршуулж болно:

12.1.1. Засгийн газраас гаргасан болон батлан даасан үнэт цаас;

12.1.2. Монголбанкны үнэт цаас;

12.1.3. зээлжих зэрэглэл тогтоодог нэр хүнд бүхий олон улсын байгууллагаас А-аас доошгүй үнэлгээ авсан гадаад улсын Засгийн газрын болон олон улсын санхүүгийн байгууллагын үнэт цаас;

/Энэ заалтад 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

12.1.4. олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банкинд нээсэн хадгаламж.

12.2. Хадгаламжийн даатгалын корпорацийн хөрөнгө оруулалтын журам, заавар болон хөрөнгө оруулалтын бодлогыг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР

13 дугаар зүйл. Хадгаламжийн даатгалын хураамж, түүнийг төлөх

13.1. Банк хадгаламжийн даатгалын хураамж /цаашид “хураамж” гэх/-ийг Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооноос баталсан хадгаламжийн даатгалын хураамжийн журмын дагуу Хадгаламжийн даатгалын корпорацид төлнө.

13.2. Энэ хуулийн 13.1-д заасан хураамж нь дор дурдсан хураамжаас бүрдэнэ:

13.2.1. эхлэлтийн хураамж;

13.2.2. улирлын хураамж;

13.2.3. онцгой хураамж.

13.3. Эхлэлтийн хураамж нь тухайн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний нэг хувьтай тэнцүү хэмжээтэй байна.

13.4. Банк эхлэлтийн хураамжийг Монголбанкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон өдрөөс хойш 30 хоногийн дотор төлнө.

13.5. Улирлын хураамж нь өмнөх улирлын сар бүрийн эцсийн өдрийн энэ хуулийн 7.1, 7.2.2, 7.2.3-т зааснаас бусад хадгаламжийн дундаж дүнг энэ хуулийн 14.1-д заасны дагуу тооцсон улирлын хураамжийн хувиар үржүүлсэн дүнтэй тэнцүү хэмжээтэй байна.

/Энэ заалтад 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

13.6. Улирлын хураамжийг төлөх хугацааг Хадгаламжийн даатгалын корпорацийн нэхэмжлэлд заана.

13.7. Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо жил бүрийн 11 дүгээр сарын 30-ны дотор дараа жилийн улирлын хураамжийн хувийг 0.125 хувиас хэтрүүлэхгүй хэмжээгээр тогтооно.

13.8. Сангийн хөрөнгө гишүүн банкуудын энэ хуулийн 7.1-д зааснаас бусад хадгаламжийн дүнгийн 10 хувьд хүрвэл Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо улирлын хураамжийг тооцох болон хуримтлуулахыг түр зогсоож болно.

13.9. Даатгалын нөхөн төлбөрийг төлөхөд Сангийн хөрөнгө хүрэлцэхгүй болсон тохиолдолд онцгой хураамжийг төлөх шийдвэрийг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо гаргаж болно.

13.10. Онцгой хураамжийн хувийг энэ хуулийн 7.1, 7.2.2, 7.2.3-т зааснаас бусад хадгаламжаас тооцох бөгөөд уг хувь нь жилийн 0.5 хувиас хэтрэхгүй байна.

/Энэ заалтад 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

13.11. Онцгой хураамжийг өмнөх улирлын сар бүрийн эцсийн өдрийн энэ хуулийн 7.1, 7.2.2, 7.2.3-т зааснаас бусад хадгаламжийн дундаж дүнг онцгой хураамжийн хувиар үржүүлэн тооцно.

/Энэ заалтад 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

13.12. Хэрэв банк хүсэлт гаргавал энэ хуулийн 13.6-д заасан хугацааг Хадгаламжийн даатгалын корпораци ажлын таван өдрөөр сунгаж болно.

13.13. Энэ хуулийн 13.12-т заасан хугацаанд банк хураамжийн төлбөрийг

гүйцэтгээгүй тохиолдолд Хадгаламжийн даатгалын корпораци Монголбанкинд энэ тухай мэдэгдэж, тухайн банкны Монголбанкин дахь харилцах данснаас төлбөл зохих хураамжийн дүнгээр суутган төлүүлэх хүсэлтийг Монголбанкинд хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

13.14.Монголбанкнаас албадан татан буулгасан банкны даатгалын хураамж төлөх үүрэг нь даатгалын тохиолдол бий болсон улирлын эцсийн өдрөөр дуусгавар болно.

13.15.Энэ хуулийн 13.1-д заасны дагуу банкнаас төлсөн хураамжийг буцааж олгохгүй.

14 дүгээр зүйл.Улирлын хураамжийн хувь

14.1.Хадгаламжийн даатгалын корпораци энэ хуулийн 13.2.2-т заасан улирлын хураамжийн хувийг тухайн банкны эрсдэлийн түвшингээс хамааруулан тогтоосон аргачлалын дагуу тооцно.

14.2.Хадгаламжийн даатгалын корпораци банкны эрсдэлийн түвшинг үнэлэхдээ Монголбанкны мэдээлэлд үндэслэнэ.

14.3.Хадгаламжийн даатгалын корпораци энэ хуулийн 14.2-т заасан мэдээллийн нууцлалыг хадгална.

14.4.Энэ хуулийн 14.1-д заасан аргачлалыг Монголбанк, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батлах бөгөөд банкны эрсдэлийн түвшинг тооцохдоо банкинд хийсэн хяналт шалгалтын үнэлгээ, банкны хадгаламжийн хүүг харгалзан үзэж болно.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

15 дугаар зүйл.Хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр олгох

15.1.Монголбанкнаас даатгалын тохиолдол бий болсон тухай мэдэгдлийг Хадгаламжийн даатгалын корпорацид ирүүлснээс хойш ажлын гурван өдөрт багтаан Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр олгох тухай шийдвэр гаргана.

15.2.Хадгаламжийн даатгалын корпораци даатгалын нөхөн төлбөр олгох хэлбэр, хугацааны талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр энэ хуулийн 15.1-д заасан шийдвэр гарснаас хойш 48 цагийн дотор мэдээлж, мэдээллийн хувийг Монголбанкинд хүргүүлнэ.

15.3.Хадгаламжийн даатгалын корпораци даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш даатгалын нөхөн төлбөрийг энэ хуулийн 16.1-д заасан банкаар дамжуулан ажлын 10 өдрийн дотор олгож эхэлнэ.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

15.4.Гадаад валютын хадгаламжийн даатгалын нөхөн төлбөрийг төгрөгөөр гүйцэтгэх бөгөөд түүний дүнг даатгалын тохиолдол бий болсон өдрийн Монголбанкнаас зарласан ханшаар тооцно.

15.5.Даатгалын нөхөн төлбөр олгох журмыг Хадгаламжийн даатгалын

Үндэсний хороо батална.

15.6.Хадгаламжийн даатгалын корпораци даатгалын нөхөн төлбөр олголтын явцын талаар хадгаламж эзэмшигчдэд мэдээлэх үүрэгтэй.

15.7.Энэ хуулийн 15.6-д заасан мэдээллийн агуулга, түүнийг түгээх журмыг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батална.

16 дугаар зүйл.Даатгалын нөхөн төлбөр олгох банк

16.1.Даатгалын нөхөн төлбөрийг банкаар дамжуулан олгоно.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан даатгалын нөхөн төлбөр олгох банкийг даатгалын тохиолдол бий болсон тухай бүр Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо Монголбанктай зөвшилцөн сонгон шалгаруулна.

16.3.Даатгалын нөхөн төлбөр олгох банкинд тавих шаардлага, сонгон шалгаруулах журмыг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батална.

16.4.Хадгаламжийн даатгалын корпораци энэ хуулийн 16.1-д заасан банктай гэрээ байгуулна.

17 дугаар зүйл.Хадгаламж эзэмшигчийн эрх

17.1.Хадгаламж эзэмшигч даатгалын тохиолдол бий болоход даатгалын нөхөн төлбөр авах эрхтэй.

17.2.Хадгаламжийн гэрээг гуравдагч этгээдийг төлөөлөн байгуулсан бол даатгалын нөхөн төлбөр авах эрхийг уг гуравдагч этгээд эдэлнэ.

17.3.Өв залгамжлалаар даатгалын нөхөн төлбөр авахад өвлөгч нь өөрийн нэр дээр хадгалуулсан хадгаламж, өвлөгдсөн хадгаламж тус бүрд даатгалын нөхөн төлбөр авна.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

17.4.Хадгаламж эзэмшигчийн даатгалын нөхөн төлбөр авах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа энэ хуулийн 6.3-т заасан шаардах эрх үүссэнээс хойш гурван жил байна.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

17.5.Банк нэгтгэх, нийлүүлэх, банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд банкны актив, пассивыг шилжүүлэх байдлаар өөрчлөн байгуулагдсан тохиолдолд ийнхүү өөрчлөн байгуулагдахаас өмнөх банк тус бүрд даатгалын нөхөн төлбөрт олгох хэмжээг тогтоох бөгөөд энэ нь өөрчлөн байгуулагдсанаас хойш зургаан сарын хугацаанд хүчинтэй байна.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

17.6.Энэ хуулийн 17.5-д заасан хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг банк тус бүрд тооцох хугацаа дуусч байгаа тухай хадгаламж эзэмшигчид хүлээж авсан, нэгдсэнээс үүссэн банк мэдэгдэнэ.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

18 дугаар зүйл. Шаардах эрх

18.1. Хадгаламжийн даатгалын корпорациас хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр олгосон хэмжээгээр хадгаламж эзэмшигчийн шаардах эрх Хадгаламжийн даатгалын корпорацид шилжинэ.

18.2. Хадгаламжийн даатгалын корпораци энэ хуулийн 8.1-д заасны дагуу олгосон даатгалын нөхөн төлбөрийг татан буугдсан банкны хөрөнгөөс Банкны тухай болон Дампуурлын тухай хуулийн дагуу нэхэмжилнэ.

18.3. Хадгаламж эзэмшигчийн Хадгаламжийн даатгалын корпорациас шаардах эрх энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан хадгаламж болон хадгаламж эзэмшигч, 8 дугаар зүйлд заасан нөхөн төлөх хэмжээнээс илүү гарсан хадгаламжид хамаарахгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

19 дүгээр зүйл. Хадгаламжийн даатгалын корпорацийн эрх зүйн байдал

19.1. Хадгаламжийн даатгалын корпораци /цаашид “Корпораци” гэх/ нь хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг эрхлэх тусгайлсан чиг үүрэг бүхий ашгийн төлөө бус, төрийн өмчит хуулийн этгээд байна.

19.2. Корпорацийн төв Монгол Улсын нийслэлд байрлана.

19.3. Корпорацийн дүрмийг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батална.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

19.4. Корпораци тогтоосон загвараар үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

19.5. Корпораци Монголбанкинд төгрөгийн болон валютын харилцах, хадгаламжийн данстай байна.

19.6. Корпораци өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулахтай холбоотойгоор банкинд харилцах данс нээж болно.

19.7. Корпораци дотоод аудитын албатай байх бөгөөд дотоод аудитын алба Хадгаламжийн даатгалын Үндэсний хороонд ажлаа тайлагнана.

/Энэ хэсэгт 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

19.8. Корпораци үйл ажиллагааныхаа ил тод байдлыг хангах чиглэлээр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд [10] заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

20 дугаар зүйл. Корпорацийн үйл ажиллагаа

20.1. Корпораци дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

20.1.1. даатгалын хураамжийг төвлөрүүлэх;

20.1.2. даатгалын тохиолдол бий болоход хадгаламж эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөр төлөх;

20.1.3. Сангийн хөрөнгийг энэ хуульд заасны дагуу удирдах;

20.1.4. Сангийн санхүүгийн эрсдэлийг үнэлэх зорилгоор банкны эрсдэлийг үнэлж, хянах.

20.2. Корпораци нь энэ хуульд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхгүй бөгөөд ашгийн төлөө хуулийн этгээд байгуулахыг хориглоно.

21 дүгээр зүйл. Корпорацийн бүрэн эрх

21.1. Корпораци дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1. хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хадгаламж болон хадгаламж эзэмшигчдийн талаарх сар, улирлын тайлан, бусад мэдээллийг банкнаас авах;

21.1.2. банкны санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт, санхүүгийн үзүүлэлт, бусад мэдээллийг банкнаас авах;

21.1.3. хадгаламжийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой, эсхүл даатгалын тохиолдлын магадлалыг үнэлэхэд шаардлагатай гэж үзвэл банкинд хяналт шалгалт хийлгэх хүсэлтийг Монголбанкинд тавих;

21.1.4. таган буугдсан банкны эрх хүлээн авах ажиллагаанд Корпорацийн төлөөллийг оролцуулах хүсэлтийг Монголбанкинд тавьж, гүйцэтгүүлэх;

21.1.5. хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд Сангийн хөрөнгө хүрэлцэхгүй бол Монголбанк, Засгийн газраас зээл, санхүүгийн дэмжлэг авч болно;
/Энэ заалтыг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

21.1.6. Корпораци өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар журам баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

/Энэ заалтад 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

21.1.7. энэ хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд банкинд хяналт шалгалт хийх;

/Энэ заалтыг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

21.1.8. энэ хуульд заасан мэдээллийг солилцоход шаардагдах программ хангамжийн бүрэн бүтэн, бэлэн байдлыг корпораци нь тогтмол шалгах.

/Энэ заалтыг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

22 дугаар зүйл. Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо

22.1. Корпорацийн удирдах дээд байгууллага нь Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо /цаашид “Үндэсний хороо” гэх/ байна.

22.2. Үндэсний хороо долоон гишүүнээс бүрдэх бөгөөд Үндэсний хорооны гишүүн дараах этгээд байна:

22.2.1. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Үндэсний хорооны гишүүн бөгөөд дарга;

22.2.2. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;

22.2.3. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос нэр дэвшиж томилогдсон Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн;

/Энэ заалтыг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

22.2.4. Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголын банкны холбооны ерөнхийлөгч тус тус нэр дэвшүүлж, Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар томилсон гурван гишүүн;

22.2.5. Корпорацийн гүйцэтгэх захирал.

22.3. Энэ хуулийн 22.2.4-т заасан Үндэсний хорооны гурван гишүүнийг дөрвөн жилийн хугацаагаар томилох бөгөөд тэдгээрийг нэг удаа улируулан томилж болно.

22.4. Энэ хуулийн 22.2.4-т заасан гишүүн дараах шаардлагыг хангасан байна:

22.4.1. зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

22.4.2. ял шийтгэлгүй;

22.4.3. ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь Корпорацийг удирдахад харшлахгүй байх;

22.4.4. банк, санхүү, даатгал, эрх зүй, эдийн засгийн аль нэг чиглэлээр мэргэшсэн;

22.4.5. банк, санхүү, даатгалын салбарт таваас доошгүй жил удирдах албан тушаал хашсан;

22.4.6. төрийн улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал хашдаггүй байх;

22.4.7. банк, санхүүгийн байгууллагад ажилладаггүй байх;

22.4.8. банк, санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигч болон бусад холбогдох этгээд бус байх;

22.4.9. эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс шалтгаалаагүй нь нотлогдсон байх.

22.5. Үндэсний хорооны дарга болон Корпорацийн гүйцэтгэх захирлаас бусад гишүүний урамшууллын хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

22.6. Үндэсний хорооны ажиллах журам, Үндэсний хорооны гишүүн, Корпорацийн гүйцэтгэх захирал болон ажилтны ёс зүйн дүрмийг Үндэсний хорооны тогтоолоор батална.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

22.7. Дараах тохиолдолд Үндэсний хорооны гишүүнийг энэ хуулийн 22.3-т заасан хугацаанаас өмнө Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан шийдвэрээр үүрэгт ажлаас чөлөөлнө:

22.7.1. үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан;

22.7.2. тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн;

22.7.3.өвчний улмаас цаашид үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гарсан;

22.7.4.үүрэгт ажлаа хоёр ба түүнээс дээш удаа хангалтгүй биелүүлсэн;

22.7.5.энэ хуулийн 22.4-т заасан шаардлагыг хангахгүй болсон;

22.7.6.ёс зүйн зөрчил гаргасан;

22.7.7.гэмт хэрэг үйлдсэн талаар шүүхийн эцсийн шийдвэр гарсан.

22.8.Энэ хуулийн 22.2.4-т заасан гурван гишүүнийг нэгэн зэрэг томилж, чөлөөлөхгүй байх зарчмыг баримтална.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

22.9.Үндэсний хорооны гишүүн үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд банкинд ажиллахыг хориглоно.

22.10.Үндэсний хорооны гишүүн үйл ажиллагаандаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдөнө.

23 дугаар зүйл. Үндэсний хорооны хуралдаан

23.1.Үндэсний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

23.2.Үндэсний хорооны дарга нь хуралдаан даргалагч байна.

23.3.Үндэсний хорооны даргын түр эзгүйд түүний үүргийг Үндэсний хорооны даргын томилсон аль нэг гишүүн гүйцэтгэх бөгөөд Үндэсний хорооны даргын үүрэг гүйцэтгэж байгаа гишүүн Үндэсний хорооны даргаас олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хариуцлага хүлээнэ.

23.4.Үндэсний хороо улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд хэлэлцэх асуудлаар гишүүдийн саналыг цахим болон бусад хэлбэрээр авч болох ба үндэсний хорооны гишүүн жилд хоёроос доошгүй удаа хуралд биечлэн оролцох үүрэгтэй.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

23.5.Үндэсний хорооны хоёроос доошгүй гишүүн, эсхүл Корпорацийн гүйцэтгэх захирлын бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн Үндэсний хорооны дарга ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

23.6.Үндэсний хорооны хуралдаан гишүүдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.

23.7.Үндэсний хорооны хуралдаанд Корпорацийн ажилтан, мэргэжлийн хүмүүсийг урилгаар оролцуулж болно.

23.8.Үндэсний хорооны хуралдааны явцад тэмдэглэл хөтөлж, түүнд хуралдаанд оролцсон бүх гишүүн гарын үсэг зурж, баталгаажуулна.

23.9.Үндэсний хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах ба уг шийдвэрт хуралдаан даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

23.10.Үндэсний хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

23.11. Үндэсний хорооны шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

23.12. Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаар ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй гэж Үндэсний хорооны дарга, гишүүн үзсэн бол энэ тухай хуралдаан эхлэхээс өмнө мэдэгдэх бөгөөд тухайн асуудлыг хэлэлцэх болон санал хураахад уг гишүүн оролцохгүй.

24 дүгээр зүйл. Үндэсний хорооны бүрэн эрх

24.1. Үндэсний хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1. Корпорацийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах;

24.1.2. бүрэн эрхийнхээ хүрээнд журам, заавар баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

24.1.3. Корпорацийн стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

24.1.4. Корпорацийн бүтэц, үйл ажиллагааны төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах, Корпорацийн үйл ажиллагаанд хяналт тавих;

24.1.5. Корпорацийн гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулж томилох, түүнтэй гэрээ байгуулах, чөлөөлөх;

24.1.6. хадгаламж эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөр төлөх, энэ хуулийн 11.1.2-т заасан санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай шийдвэр гаргах;

/Энэ заалтад 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

24.1.7. хадгаламжийн даатгалын хураамжийн хувь хэмжээг тогтоох;

24.1.8. аудитын байгууллагыг сонгох;

24.1.9. Корпорацийн санхүүгийн тайланг зөвшөөрөх эсэх талаар шийдвэр гаргах;

24.1.10. Корпорацийн дотоод аудитын тайлангийн дүнг хэлэлцэж, шийдвэр гаргах;

/Энэ заалтад 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

24.1.11. Корпорацийн үйл ажиллагааны үр дүнгийн тайланг хагас жил тутамд Монголбанкны Ерөнхийлөгч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх;

24.1.12. энэ хууль болон Корпорацийн дүрэмд заасан бусад эрх, үүрэг.

25 дугаар зүйл. Корпорацийн гүйцэтгэх захирал

25.1. Корпорацийн гүйцэтгэх захирал нь Корпорацийн дүрэм болон Үндэсний хороотой байгуулсан гэрээнд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Үндэсний хорооноос баталсан стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Корпорацийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

25.2. Үндэсний хороо Корпорацийн гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгон шалгаруулж, таван жилийн хугацаатай

томилно.

/Энэ хэсэгт 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

25.3.Корпорацийн гүйцэтгэх захирал нь энэ хуулийн 22.4-т заасан шаардлагыг хангасан байна.

25.4.Корпорацийн гүйцэтгэх захирлын эрх, үүргийг Корпорацийн дүрмээр тогтооно.

25.5.Корпорацийн гүйцэтгэх захирлыг энэ хуулийн 22.7-д заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө үүрэгт ажлаас нь чөлөөлнө.

25.6.Энэ хуулийн 22.7-д заасан үндэслэлээр Корпорацийн гүйцэтгэх захирлыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тохиолдолд дараагийн гүйцэтгэх захирал томилогдох хүртэл хугацаанд Үндэсний хорооноос үүрэг гүйцэтгэгчийг томилно.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

25.7.Ээлжийн амралт эдлэх, гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, удаан хугацаагаар өвчтэй байх зэрэг тохиолдолд Корпорацийн гүйцэтгэх захирал Үндэсний хорооны зөвшөөрсөн этгээдэд бүрэн эрхээ шилжүүлж болох бөгөөд ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

25.8.Корпорацийн гүйцэтгэх захирал үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд банкинд ажиллахыг хориглоно.

25¹ дүгээр зүйл. Корпорацийн хяналт

/Энэ зүйлийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

25¹.1. Корпораци хянан шалгагчтай байна. Хянан шалгагч нь улсын байцаагчийн дараахь бүрэн эрхтэй байна:

25¹.1.1. энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан тайлан, мэдээ, мэдээллийг банкнаас гаргуулан авах;

25¹.1.2. хадгаламжийн даатгалын хураамж төлөлтөд хяналт тавьж, биелэлтийг хангуулах;

25¹.1.3. даатгалын нөхөн төлбөр төлөх үйл ажиллагаанд хяналт тавих;

25¹.1.4. хяналт шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийг Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэх арга хэмжээ авах.

25¹.2. Корпорацийн гүйцэтгэх захирал нь улсын ахлах байцаагч байх бөгөөд улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Монголбанкны Ерөнхийлөгч олгож, цуцална.

26 дугаар зүйл. Дотоод мэдээллийн нууцыг хадгалах

26.1. Хуульд зааснаас бусад тохиолдолд Үндэсний хорооны гишүүн, Корпорацийн ажилтан, хянан шалгагч болон Корпорацид гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа этгээд албан үүргийнхээ дагуу олж мэдсэн, Корпораци, банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээ, мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

26.2. Үндэсний хорооны гишүүн, Корпорацийн ажилтан болон Корпорацид гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа этгээдийн энэ хуулийн 26.1-д заасны дагуу хүлээсэн үүрэг тэдгээрийн Корпорацитай холбогдсон үүрэгт ажил нь дуусгавар болсноос хойш хүчин төгөлдөр байна.

27 дугаар зүйл. Санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайлан

27.1. Корпорацийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу гаргаж, аудит хийлгэнэ.

/Энэ хэсгийг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

27.2. Корпорацийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.2-т заасан бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

27.3. Корпорацийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд хоёр жилд нэгээс доошгүй удаа Үндэсний хорооноос сонгосон, олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар аудит хийлгэж, дүгнэлтийг Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

27.4. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Корпорацийн гүйцэтгэх захирал хариуцна.

27.5. Корпораци энэ хуулийн 27.1-д заасан тухайн жилийн тайлан, аудитын дүгнэлтийг дараа жилийн 3 дугаар сарын 01-ний дотор Үндэсний хороогоор хэлэлцүүлж, тайланг батлуулна.

27.6. Энэ хуулийн 27.1-д заасан тухайн жилийн тайланг дараа жилийн 6 дугаар сарын 1-ний дотор Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнана.

/Энэ хэсэгт 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

27.7. Корпораци жилийн тайлан, тайлан тэнцэл, орлого зарлагын тайлан болон аудитын дүгнэлтийг нийтэд мэдээлнэ.

28 дугаар зүйл. Корпорациас төрийн байгууллага, бусад этгээдтэй харилцах

28.1. Корпорациас төрийн байгууллага, бусад этгээдтэй харилцах харилцааг Корпорацийн дүрмээр зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД

29 дүгээр зүйл.Тайлан, мэдээ, мэдээллээр хангах талаарх банкны үүрэг

29.1.Корпорацийг энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллийг банк тогтоосон хэлбэрээр, хугацаанд нь Корпорацид хүргүүлнэ.

29.2.Корпорацийн хүсэлтээр банк Корпорацийг хуулийн дагуу үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай нэмэлт мэдээллийг тухай бүр гаргаж өгнө.

29.3.Банкны тайлан болон мэдээ, мэдээлэл ирүүлэх журмыг Үндэсний хороо батална.

29.4.Корпорацид ирүүлсэн санхүүгийн тайлан, мэдээ, мэдээллийн үнэн зөвийг банк хариуцна.

29.5.Банк хадгаламжийн даатгалын тогтолцоо, даатгалын нөхөн төлбөрийн хэмжээний талаарх мэдээллээр Үндэсний хорооноос баталсан журмын дагуу хадгаламж эзэмшигчийг хангах үүрэгтэй.

29.6.Энэ хуулийн 29.5-д заасан мэдээллийг банк зар сурталчилгааны зорилгоор болон банкны салбарын тогтвортой байдал, хадгаламж эзэмшигчдийн итгэлд сөргөөр нөлөөлөх байдлаар ашиглахыг хориглоно.

30 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

30.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

30.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

31 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

31.1.Энэ хуулийг 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Үндэсний төлбөрийн системийн тухай хууль тогтоомж

2.1.Үндэсний төлбөрийн системийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд үндэсний төлбөрийн системийн тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсын үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд үйлчилнэ.

3.2.Хязгаарлагдмал хүрээнд үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийн төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа энэ хуульд хамаарна.

4 дүгээр зүйл.Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд баримтлах зарчим

4.1.Монгол Улсын үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

- 4.1.1.үндэсний төлбөрийн системийн нэгдмэл байдлыг хангах;
- 4.1.2.үндэсний төлбөрийн системийн тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлыг хангах;
- 4.1.3.төлбөр тооцоог үл саатуулах;
- 4.1.4.төлбөрийн эцэслэлт, төлбөрийн үл буцаагдах байдлыг хангах;
- 4.1.5.үндэсний төлбөрийн системийн эрсдэлийг зохистой удирдах;
- 4.1.6.хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах;
- 4.1.7.оролцогчдын тэгш, тэнцвэртэй оролцоог хангах;
- 4.1.8.үндэсний төлбөрийн системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах.

5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“үндэсний төлбөрийн систем” гэж төгрөг, гадаад валютаар хийгдэх шилжүүлэг болон төлбөрийн даалгаврын боловсруулалт хийх, илгээх, дамжуулах, хүлээн авахтай холбогдох үйлчилгээ, төлбөрийн хэрэгсэл гаргах үйл ажиллагаа, төлбөрийн, клирингийн болон төлбөр тооцооны систем, Монгол Улсын нутаг дэвсгэрт хэсэгчлэн болон бүхэлд нь үйл ажиллагаа эрхэлж байгаа системийн оператор, оролцогч, тэдгээрийн нэрийн өмнөөс төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч гуравдагч этгээд, тэдгээрийн цогц нэгдлийг;

5.1.2.“төлбөрийн систем” гэж оролцогч хооронд мөнгөн хөрөнгийн шилжүүлэг хийх, түүнтэй холбогдсон журам, дүрэм, техник технологи, программ хангамж, төлбөрийн хэрэгсэл бүхий цогц бүтцийг;

5.1.3.“төлбөр тооцооны систем” гэж оролцогч хоорондын мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны төлбөрийн, Монголбанкны зөвшөөрөл бүхий системийн, клирингийн системээс тодорхойлсон үр дүнгийн тооцооллын төлбөрийн үүргийг гүйцэтгэх зорилгоор Монголбанкнаас үүсгэн байгуулж, ажиллуулж байгаа дэд бүтцийг;

5.1.4.“клирингийн систем” гэж нэг оролцогчоос нөгөө оролцогчид мөнгөн хөрөнгө, эсхүл үнэт цаас шилжүүлэхтэй холбогдох мэдээллийг клирингийн төвөөр дамжуулан солилцох, оролцогчдын төлбөр тооцооны үр дүнг тооцоолох үйл ажиллагаа, техник технологи, программ хангамжийн шийдэл бүхий дэд бүтцийг;

5.1.5.“систем” гэж төлбөрийн, клирингийн болон төлбөр тооцооны системийг;

5.1.6.“оператор” гэж Монголбанк, систем ажиллуулах Монголбанкны зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

5.1.7.“оролцогч” гэж клирингийн, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх, системд шууд болон шууд бусаар төлбөр илгээх, хүлээн авах эрхтэй этгээдийг;

5.1.8.“шууд оролцогч” гэж харилцагчийн болон өөрийн, гэрээний үндсэн дээр шууд бус оролцогчийн төлбөр тооцоог хариуцан гүйцэтгэж байгаа оролцогчийг;

5.1.9.“шууд бус оролцогч” гэж төлбөр тооцоог гэрээний үндсэн дээр шууд

оролцогчоор дамжуулан гүйцэтгэж байгаа оролцогчийг;

5.1.10. “хэрэглэгч” гэж төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээс үйлчилгээ авч байгаа аливаа этгээдийг;

5.1.11. “арилжааны төлбөр тооцоог төвлөрүүлэн гүйцэтгэх эрх бүхий этгээд” гэж үнэт цаас болон санхүүгийн хэрэгслийн худалдагч бүрийн хувьд худалдан авагч, худалдан авагч бүрийн хувьд худалдагчийн үүргийг хүлээж, төлбөр тооцоог төвлөрүүлэн гүйцэтгэх төлбөр тооцооны системийн оролцогч хуулийн этгээд бөгөөд үүнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 43, 44 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааг эрхлэгч этгээд хамаарна;

5.1.12. “клирингийн төв” гэж Монголбанк, клирингийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл бүхий, оролцогчийн дансыг өөр дээрээ байршуулдаггүй хуулийн этгээдийг;

5.1.13. “төлбөр тооцооны төлөөлөгч” гэж оролцогч хоорондын төлбөр тооцоог хийх зорилгоор тэдгээрийн төлбөр тооцооны дансыг өөр дээрээ байршуулсан Монголбанкны зөвшөөрөл бүхий шууд оролцогчийг;

5.1.14. “төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч” гэж төлбөрийн үйлчилгээ үзүүлэх Монголбанкны зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

5.1.15. “гэрээт төлөөлөгч” гэж төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг;

5.1.16. “төлбөрийн үйлчилгээ” гэж бэлэн мөнгөний орлого, зарлага, шилжүүлэг хийх, төлбөр шилжүүлэх, төлбөрийн хэрэгсэл гаргах, хүлээн авах, мөнгөн гуйвуулга хийх, цахим мөнгө гаргах, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх болон Монголбанкнаас тодорхойлсон мөнгөн хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон бусад үйлчилгээг;

5.1.17. “төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа” гэж төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид техник технологи, мэргэжлийн боловсон хүчний болон Монголбанкнаас тодорхойлох бусад дэмжлэг үзүүлэх, Монголбанкны зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг;

5.1.18. “шилжүүлэг” гэж аливаа этгээдээс төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан мөнгөн хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагааг;

5.1.19. “кредит шилжүүлэг” гэж төлбөр шилжүүлэгчийн даалгаврын дагуу төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан төлбөр хүлээн авагчийн дансанд мөнгөн хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагааг;

5.1.20. “дебит шилжүүлэг” гэж төлбөр хариуцагчаас төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид олгосон зөвшөөрөлд үндэслэн төлбөр хүлээн авагчийн нэхэмжлэлийн дагуу эхлүүлж байгаа мөнгөн хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагааг;

5.1.21. “мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг” гэж харилцагчаас цахим төхөөрөмжийн тусламжтайгаар төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид хандаж эхлүүлсэн мөнгөн хөрөнгийн шилжүүлгийг;

5.1.22. “мөнгөн гуйвуулга” гэж төлбөр шилжүүлэгч, төлбөр хүлээн авагчийн нэр дээр данс үүсгэлгүйгээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан мөнгөн хөрөнгө шилжүүлэх Монголбанкны зөвшөөрөлтэй эрхлэх үйлчилгээг;

5.1.23. “төлбөрийн хэрэгсэл” гэж бэлэн мөнгө, мөнгөн хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах, төлбөр төлөх зориулалттай төлбөрийн карт, цахим мөнгө зэрэг Монголбанкны зөвшөөрөл бүхий биет, биет бус хэрэгслийг;

5.1.24. “төлбөрийн карт” гэж олон улсад зөвшөөрөгдсөн картын байгууллагын стандарт болон Монголбанкны шаардлагыг нэгэн зэрэг, эсхүл аль нэгийг нь хангасан карт эзэмшигчид төлбөр хийх боломж олгодог төлбөрийн хэрэгслийг;

5.1.25. “цахим мөнгө” гэж Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгтэй адил үнэ цэнэ бүхий Монголбанкны зөвшөөрөлтэй гаргасан бэлэн бус төлбөрийн хэрэгслийг;

5.1.26. “төлбөр тооцоо” гэж хоёр ба түүнээс дээш талын хооронд хийгдсэн мөнгөн хөрөнгө, үнэт цаасны төлбөрийг дансанд тусгах ажиллагааг;

5.1.27. “төлбөр тооцооны данс” гэж оролцогч хооронд төлбөр тооцоо хийхэд ашиглах Монголбанк, арилжааны төлбөр тооцоог төвлөрүүлэн гүйцэтгэх эрх бүхий этгээд, эсхүл төлбөр тооцооны төлөөлөгч дээр байршиж байгаа оролцогчийн дансыг;

5.1.28. “клиринг” гэж төлбөр тооцоо хийхээс өмнө мөнгөн хөрөнгийн, эсхүл үнэт цаасны шилжүүлгийн даалгаврыг дамжуулах, тохируулах, баталгаажуулах үйл явц бөгөөд үүнд шилжүүлгийн үр дүнгийн тооцоолол, төлбөр тооцооны эцсийн дүнг тодорхойлох ажиллагаа багтана;

5.1.29. “үр дүнгийн тооцоолол” гэж хоёр ба түүнээс дээш оролцогчийн харилцан хүлээсэн төлбөрийн үүргийн цэвэр дүн болох үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг тодорхойлох үйл ажиллагааг;

5.1.30. “үр дүнгийн тооцооллын хаалтын дүн” гэж төлбөр тооцооны дүрмийн дагуу оролцогч хоорондын өглөг, авлагын дүнг цэвэршүүлж, нэг цэвэр авлага, эсхүл өглөг болгох үйл ажиллагааны үр дүнд бий болсон төлбөр тооцооны дүнг;

5.1.31. “үр дүнгийн төлбөр тооцоо” гэж тухайн өдөр оролцогч хооронд хийгдсэн шилжүүлгийн үр дүнгийн тооцооллыг нэг ба түүнээс дээш удаа тогтоосон хугацаанд холбогдох дансанд тусгах ажиллагааг;

5.1.32. “үүрэг дуусгавар болох үеийн үр дүнгийн тооцоолол” гэж үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон оролцогчийн төлбөр тооцоог хийж дуусгах зорилгоор операторын гүйцэтгэх үр дүнгийн тооцооллын онцгой хэлбэрийн үйл ажиллагааг;

5.1.33. “үүрэг шилжих үеийн үр дүнгийн тооцоолол” гэж талуудын гэрээгээр хүлээсэн үүрэг дуусгавар болж, харилцан тооцох, шинэ үүрэг гүйцэтгэгчид шилжүүлэх замаар гүйцэтгэх үр дүнгийн тооцооллын үйл ажиллагааг;

5.1.34. “олон талын үр дүнгийн тооцоолол” гэж гурав ба түүнээс дээш талын хооронд үүсэх үүргийн үр дүнг тооцоолох үйл ажиллагааг;

5.1.35. “төлбөрийн эцэслэлт” гэж аливаа нөхцөлд үл буцаагдах төлбөр тооцоог;

5.1.36. “төлбөр тооцооны дүрэм” гэж төлбөрийн үүргийг тооцох, үр дүнгийн тооцоолол хийх, төлбөр тооцоог гүйцэтгэх суурь зарчмыг тодорхойлсон Монголбанкнаас баталсан дүрмийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМ ДЭХ МОНГОЛБАНКНЫ БҮРЭН ЭРХ, ОРОЛЦОО

6 дугаар зүйл. Монголбанкны бүрэн эрх

6.1. Монголбанк үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, зохицуулж, хяналт тавина.

6.2. Монголбанк энэ хуулийн 6.1-д заасны дагуу үндэсний төлбөрийн системийг бүхэлд нь болон түүний бүрэлдэхүүн хэсгийг зохицуулж, хяналт тавихдаа нийтийн болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, төлбөрийн үйлчилгээний зах зээл дэх өрсөлдөөнийг дэмжинэ.

6.3. Монголбанк үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, зохицуулахтай холбогдсон дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.3.1. үндэсний төлбөрийн системийн бодлогыг тодорхойлох;

6.3.2. энэ хуулийн 10.1-д заасан зөвшөөрөл олгох;

6.3.3. үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг зохицуулах, шинээр төлбөрийн хэрэгсэл гаргах, төлбөрийн үйлчилгээ нэвтрүүлэхтэй холбогдсон дүрэм, журам батлах, шийдвэр гаргах;

6.3.4. зөвшөөрөл авсан этгээд, түүний төлбөрийн системд хамаарах үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага, тэдгээрт холбогдох дүрэм, журам, заавар батлах, шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих;

6.3.5. төлбөрийн, клирингийн болон төлбөр тооцооны систем, төлбөрийн хэрэгсэл гаргахтай холбогдох бусад үйл ажиллагааг гүйцэтгэх.

7 дугаар зүйл. Монголбанкны оролцоо

7.1. Монголбанк төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор систем, системийн оператор болон оролцогчийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж болно.

7.2. Монголбанк энэ хуулийн 7.1-д заасан нөхцөлийг бүрдүүлэх тохиолдолд дараахь хэлбэрээр оролцоно:

7.2.1. системийг үүсгэн байгуулах, эзэмших, хамтран эзэмших, ажиллуулах, эсхүл системд оролцох;

7.2.2. Монголбанкны нээлттэй зах зээлийн үйл ажиллагаатай холбоотойгоор арилжааны төлбөр тооцоог төвлөрүүлэн гүйцэтгэх эрх бүхий этгээдийн үүрэг гүйцэтгэх;

7.2.3. оператор, оролцогчоос системд илгээсэн дебит, кредит шилжүүлгийн клирингийн болон төлбөр тооцооны дансыг өөр дээрээ байршуулах;

7.2.4. системийн үйл ажиллагаанд ашиглах үнэт цаасыг барьцаалах;

7.2.5. Монголбанкны үнэт цаасны хувьд дараахь үйл ажиллагааг гүйцэтгэнэ:

7.2.5.а. биет хэлбэртэй үнэт цаас эзэмшигчийн нэрийн шилжүүлгийг цахимжуулах, үнэт цаасыг биет бус хэлбэрт шилжүүлэх, биет бус хэлбэрээр гаргах

боломжийг бүрдүүлэх;

7.2.5.б.үнэт цаасны гүйлгээний бүртгэл хөтлөх;

7.2.5.в.үнэт цаасны кастодианы үйлчилгээ үзүүлэх;

7.2.5.г.үнэт цаасыг цахим, эсхүл биет хэлбэрээр өөр дээрээ байршуулах.

7.3.Монголбанк барьцаа хөрөнгөд үндэслэн оролцогчид өдрийн зээл олгож болно.

8 дугаар зүйл.Хамтын ажиллагаа

8.1.Монголбанк энэ хуулийн хүрээнд дараахь байгууллагатай хамтран ажиллаж болно:

8.1.1.төлбөрийн үйлчилгээ, түүний үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцогч этгээд;

8.1.2.төлбөрийн системийн бодлого тодорхойлох, хяналт тавих үүрэг бүхий гадаад улсын төв банк болон олон улсын бусад байгууллага.

8.2.Монголбанк энэ хуулийн 8.1-д заасан этгээдтэй харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж болно.

9 дүгээр зүйл.Үндэсний төлбөрийн системийн зөвлөл

9.1.Монголбанк үндэсний төлбөрийн системийн зөвлөлийг байгуулна.

9.2.Үндэсний төлбөрийн системийн зөвлөл нь системийн үйл ажиллагааны болон техникийн стандартыг тогтоох, төлбөрийн болон үнэт цаасны клиринг, төлбөр тооцоо, төлбөрийн үйлчилгээнд нөлөөлж болзошгүй бусад асуудлыг зохицуулах, хянах талаар зөвлөмж гаргана.

9.3.Үндэсний төлбөрийн системийн зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, дүрмийг Монголбанк батална.

9.4.Энэ хуулийн 9.3-т заасан зөвлөлийн бүрэлдэхүүнд оролцогчийн төлөөллийг оруулж болох бөгөөд Монголбанк, санхүүгийн байгууллагыг хянан зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг оролцуулсан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЗӨВШӨӨРӨЛ

10 дугаар зүйл.Монголбанкнаас олгох зөвшөөрөл

10.1.Монголбанк дараахь үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгоно:

10.1.1.төлбөрийн үйлчилгээ;

10.1.2.төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа;

10.1.3.систем ажиллуулах;

10.1.4.төлбөрийн хэрэгсэл гаргах;

- 10.1.5.төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх;
- 10.1.6.гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх;
- 10.1.7.аутсорсингийн үйлчилгээ авах;
- 10.1.8.мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх;
- 10.1.9.мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх;
- 10.1.10.цахим мөнгө гаргах;
- 10.1.11.Монголбанкнаас тодорхойлсон бусад.

10.2.Энэ хуулийн 10.1.1-д заасан зөвшөөрөл бүхий этгээдэд 10.1.4-10.1.11-д заасан үйл ажиллагааны зөвшөөрлийг, энэ хуулийн 10.1.2, 10.1.3-г заасан зөвшөөрөл бүхий этгээдэд 10.1.7-д заасан зөвшөөрлийг олгоно.

10.3.Оператор, оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд аудит хийх, Монголбанкны тавьсан нөхцөл, шаардлагыг хангасан аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн бүртгэлийг Монголбанк хөтөлнө.

11 дүгээр зүйл.Зөвшөөрөл авах хүсэлт гаргах

11.1.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагч дараахь баримт бичгийг Монголбанканд ирүүлнэ:

11.1.1.улсын бүртгэлийн гэрчилгээ, эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл;

11.1.2.үзүүлэх төлбөрийн үйлчилгээний талаархи танилцуулга, холбогдох баримт бичиг;

11.1.3.төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэхэд ашиглах хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт бичиг;

11.1.4.төлбөрийн үйлчилгээг зохистой, найдвартай, тогтвортой үзүүлэхэд шаардлагатай систем, нөөцтэй, тэдгээрийг ашиглах чадвартайг нотолсон баримт бичиг, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх эхний таван жилийн бизнес төлөвлөгөө, дүрэм, журам;

11.1.5.хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийг хамгаалахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай баримт бичиг;

11.1.6.зохистой засаглал, эрсдэлийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн аргачлал бүхий удирдлага зохион байгуулалт, дотоод хяналт зэргийг зохицуулсан баримт бичиг;

11.1.7.мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлснийг нотлох баримт бичиг;

11.1.8.байгууллагын бүтэц, зохион байгуулалт, шаардлагатай тохиолдолд гэрээт төлөөлөгч, аутсорсингийн үйлчилгээ авах тухай шийдвэр, үндэсний, эсхүл олон улсын төлбөрийн системд оролцохтой холбогдох баримт бичиг;

11.1.9.хүсэлт гаргагчтай холбогдох этгээдийн мэдээлэл;

11.1.10. удирдлагын болон төлбөрийн үйлчилгээг хариуцах нэгжийн удирдах ажилтны мэдээлэл;

11.1.11. үйлчилгээний хөлс төлсөн баримт;

11.1.12. Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

11.2. Төлбөрийн хэрэгсэл гаргах зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь Монголбанкнаас баталсан журамд заасан баримт бичгийг бүрдүүлж, Монголбанканд ирүүлнэ.

11.3. Систем ажиллуулах зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь дараахь баримт бичгийг Монголбанканд ирүүлнэ:

11.3.1. улсын бүртгэлийн гэрчилгээ, эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл;

11.3.2. ажиллуулах системийн танилцуулга, дүрэм;

11.3.3. систем ажилуулахад ашиглах хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт бичиг;

11.3.4. систем ажиллуулах эхний таван жилийн бизнес төлөвлөгөө;

11.3.5. зохистой засаглал, эрсдэлийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн аргачлал бүхий удирдлага зохион байгуулалт, дотоод хяналт зэргийг зохицуулсан баримт бичиг;

11.3.6. байгууллагын бүтэц, зохион байгуулалт, шаардлагатай тохиолдолд аутсорсингийн үйлчилгээ авах тухай шийдвэр, үндэсний болон олон улсын төлбөрийн системд оролцохтой холбогдсон баримт бичиг;

11.3.7. мэдээллийн технологийн систем болон техникийн тодорхойлолт, түүнд холбогдох дараахь баримт бичиг:

11.3.7.а. системийн бүтэц, ажиллагаа;

11.3.7.б. үндсэн системийн үйл ажиллагаа доголдсон нөхцөлд авч хэрэгжүүлэх онцгой байдлын болон тасралтгүй, найдвартай ажиллагааны төлөвлөгөө;

11.3.7.в. системд гүйлгээний мэдээллийг боловсруулах болон хадгалах явцад мэдээллийг задруулах, буруугаар ашиглах, устгах, өөрчлөх, хулгайлах, мэдээлэл алдагдах зэрэг аливаа хохирлоос хамгаалах арга хэмжээ.

11.3.8. оролцогч төлбөр түргэн гүйцэтгэх чадваргүй, эсхүл төлбөрийн чадваргүй болсны улмаас системд учруулах эрсдэлийг хязгаарлах, удирдах арга хэмжээ, эрсдэлийн дүн шинжилгээ;

11.3.9. хүсэлт гаргагчтай холбогдох этгээдийн мэдээлэл;

11.3.10. удирдлагын болон системийг хариуцах нэгжийн удирдах ажилтны мэдээлэл;

11.3.11. үйлчилгээний хөлс төлсөн баримт;

11.3.12. Монголбанкнаас шаардсан бусад мэдээлэл.

11.4. Энэ хуулийн 11.1, 11.2, 11.3-т заасны дагуу бүрдүүлж өгсөн баримт бичгийг дутуу буюу тодорхой бус гэж үзвэл Монголбанк нэмэлт баримт бичиг шаардах эрхтэй бөгөөд хүсэлт гаргагч, түүний үйл ажиллагаа, эрх бүхий албан тушаалтантай

холбоотой асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, лавлагаа гаргуулан авч болно.

12 дугаар зүйл.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагчид тавих шаардлага

12.1.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч дараахь шаардлагыг хангасан байна:

12.1.1.Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан;

12.1.2.Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангасан;

12.1.3.дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо бүхий төлбөрийн үйлчилгээ үзүүлэх шаардлагыг хангахуйц техникийн болон зохион байгуулалтын чадвартай;

12.1.4.хэрэглэгчээс, эсхүл бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр гүйцэтгэхийн тулд хүлээж авсан мөнгөн хөрөнгийг өөр зорилгоор ашиглах, гуравдагч этгээдийн мөнгөн хөрөнгөтэй нийлүүлэх зэргээс хамгаалсан, төлбөрийн чадваргүй болсон үед үйлчилгээ үзүүлэгчийн бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлээс тусгаарлах боломж бүхий тогтолцоотой;

12.1.5.таван жилийн стратеги болон бизнес төлөвлөгөөтэй;

12.1.6.төлбөрийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвар бүхий хүний нөөцтэй;

12.1.7.тухайн системд зөвшөөрөгдсөн гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэхэд шаардлагатай төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг баталгаажуулах, зээлийн эрсдэлээс хамгаалсан;

12.1.8.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөлийг хангах.

12.2.Монголбанк энэ хуулийн 12.1.2-т заасан өөрийн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг доор дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзэж тогтоох ба зөвшөөрөл авч байгаа этгээдийн зөвшөөрлийн нөхцөлд тодорхой тусгана:

12.2.1.үзүүлэх төлбөрийн үйлчилгээний төрөл;

12.2.2.төлбөрийн дундаж дүн;

12.2.3.холбогдох бусад хүчин зүйлс.

12.3.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд тавих нэмэлт шаардлагыг Монголбанкнаас баталсан журмаар тогтооно.

13 дугаар зүйл.Төлбөрийн хэрэгсэл гаргах хүсэлт гаргагчид тавих шаардлага

13.1.Төлбөрийн хэрэгсэл гаргах хүсэлт гаргагчид тавих шаардлагыг Монголбанк батална.

14 дүгээр зүйл. Систем ажиллуулах хүсэлт гаргагчид тавих шаардлага

14.1. Систем ажиллуулах хүсэлт гаргагч дараахь шаардлагыг хангасан байна:

14.1.1. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан;

14.1.2. Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангасан;

14.1.3. дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын зохистой арга хэрэгсэл бүхий систем ажиллуулахад шаардлага хангахуйц техникийн болон зохион байгуулалтын ур чадвартай;

14.1.4. үндэсний төлбөрийн системийн нэгдмэл байдал, системийн тасралтгүй, найдвартай, үр ашигтай ажиллагааг хангах;

14.1.5. төлбөр тооцоог үл саатуулах, төлбөр тооцоог эцэслэх, төлбөрийн үл буцаагдах байдлыг хангах чадвартай;

14.1.6. систем ажиллуулахад шаардлагатай мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвар бүхий хүний нөөцтэй;

14.1.7. өөрийн системийн оролцогчид эрх тэгш оролцох боломжийг хангасан;

14.1.8. зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, төлбөр тооцооны эрсдэлийг хянах эрсдэлийн удирдлагын тогтолцоотой;

14.1.9. үндсэн системийн үйл ажиллагаа доголдсон нөхцөлд авч хэрэгжүүлэх онцгой байдлын болон тасралтгүй, найдвартай ажиллагааны төлөвлөгөөтэй;

14.1.10. Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөлийг хангах.

14.2. Монголбанк энэ хуулийн 14.1.2-т заасан өөрийн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг доор дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзэж тогтоох ба зөвшөөрөл авч байгаа этгээдийн зөвшөөрлийн нөхцөлд тодорхой тусгана:

14.2.1. ажиллуулах системийн төрөл;

14.2.2. тус системээр боловсруулах төлбөрийн тоо ба дүнгийн урьдчилсан тооцоо;

14.2.3. холбогдох бусад хүчин зүйлс.

15 дугаар зүйл. Зөвшөөрөл олгох

15.1. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх, төлбөрийн хэрэгсэл гаргах болон систем ажиллуулах зөвшөөрөл авах хүсэлт гаргагч энэ хуулийн 12, 13, 14 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан тохиолдолд Монголбанк зөвшөөрөл олгоно.

15.2. Зөвшөөрөл авах хүсэлт гаргагч энэ хуульд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлж ирүүлснээс хойш зөвшөөрөл олгох эсэх асуудлыг 60 хоногийн дотор шийдвэрлэж, шийдвэр гарснаас хойш хүсэлт гаргагчид гурав хоногийн дотор мэдэгдэнэ.

15.3. Энэ хуулийн 15.1-д заасан зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэх нийт хугацаа зөвшөөрөл авах хүсэлтийг анх хүлээн авсан өдрөөс хойш 180

хоногоос хэтрэхгүй байна.

15.4.Энэ хуулийн 15.1-д заасны дагуу зөвшөөрөл олгох нь санхүүгийн тогтвортой байдал, нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгод нийцсэн байна.

16 дугаар зүйл.Зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох

16.1.Аливаа этгээд Монголбанкны зөвшөөрөлгүйгээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх, төлбөрийн хэрэгсэл гаргах, энэ хуулийн 5.1.5-д заасан систем ажиллуулахыг хориглоно.

17 дугаар зүйл.Зөвшөөрлийг бусдад шилжүүлэх

17.1.Монголбанк зөвшөөрснөөс бусад тохиолдолд энэ хуулийн дагуу олгогдсон зөвшөөрөл, эсхүл аливаа эрхийг бүхэлд нь буюу хэсэгчлэн бусдад шилжүүлэхийг хориглоно. Энэ хуулийг зөрчиж, бусдад шилжүүлсэн зөвшөөрлийг хүчингүйд тооцно.

17.2.Энэ хуулийн дагуу олгосон зөвшөөрлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн шилжүүлж авах тухай хүсэлт гаргагчид энэ хуулийн 12, 13, 14 дүгээр зүйл нэгэн адил хамаарна.

18 дугаар зүйл.Зөвшөөрлийн нөхцөл, зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага

18.1.Монголбанк энэ хуулийн 10.1-д заасан зөвшөөрлийн нөхцөлийг тогтооно.

18.2.Зөвшөөрөл эзэмшигчийн удирдах албан тушаалтан, ажилтан, зөвшөөрөл эзэмшигчийн гэрээт төлөөлөгч, аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд тухайн албан тушаал, үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвартай байх нөхцөлийг хангаж ажиллана.

18.3.Зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 12, 13, 14 дүгээр зүйлд заасан шаардлагыг тогтмол хангаж ажиллана.

18.4.Зөвшөөрөл эзэмшигч нь төлбөр гүйцэтгэх баталгааг хангах зорилго бүхий сан байгуулж, ажиллуулна.

18.5.Энэ хуулийн 18.4-т заасан санг байгуулах, удирдахтай холбогдсон харилцааг Монголбанкны баталсан журмаар зохицуулна.

19 дүгээр зүйл.Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

19.1.Монголбанк зөвшөөрлийг тухайн зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны онцлог, зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь үндэслэлээр түдгэлзүүлнэ:

19.1.1.зөвшөөрлийн нөхцөлд заасан өөрийн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 80 хүртэл хувиар хангаагүй;

19.1.2.энэ хуульд заасан бусад шаардлагыг хангаж ажиллаагүй.

19.2.Монголбанк зөвшөөрлийг дараахь үндэслэлээр хүчингүй болгож, нийтэд зарлана:

19.2.1.зөвшөөрөл эзэмшигчийг дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсныг зарласан, эсхүл татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;

19.2.2.зөвшөөрөл авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь зөвшөөрөл авснаас хойш илэрсэн;

19.2.3.Монголбанкнаас зөвшөөрөл авснаас хойш зургаан сараас дээш хугацаанд зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг эрхэлж эхлээгүй;

19.2.4.зөвшөөрлийн нөхцөлд заасан өөрийн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 80-аас дээш хувиар хангаагүй;

19.2.5.хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн.

19.3.Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох тухай Монголбанкны шийдвэрийн талаар зөвшөөрөл эзэмшигч 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд гомдол гаргасан нь Монголбанкны шийдвэрийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

АУТСОРСИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ, ГЭРЭЭТ ТӨЛӨӨЛӨГЧӨӨР ДАМЖУУЛАН ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

20 дугаар зүйл.Аутсорсингийн үйлчилгээ үзүүлэх этгээд болон гэрээт төлөөлөгчид тавих шаардлага, хариуцлага

20.1.Оператор нь үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх /цаашид “аутсорсингийн үйлчилгээ авах” гэх/ тохиолдолд энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулна.

20.2.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн үйлчилгээний тодорхой хэсэгт аутсорсингийн үйлчилгээ авах бол энэ хуулийн 12 дугаар зүйлд, гэрээт төлөөлөгчөөр дамжуулан үзүүлэх бол Монголбанкнаас баталсан журамд заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулна.

20.3.Оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээд болон гэрээт төлөөлөгчийн төлбөрийн системд холбогдох үйл ажиллагааны хариуцлагыг хүлээнэ.

21 дүгээр зүйл.Аутсорсингийн үйлчилгээ авах

21.1.Оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь Монголбанкны зөвшөөрлөөр аутсорсингийн үйлчилгээ авна. Аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа Монголбанкнаас шаардсан тухайн үйлчилгээнд хамаарах мэдээллийг гаргаж өгнө.

21.2.Монголбанк энэ хуулийн 21.1-д заасан хүсэлт, мэдээллийг хянаж, дараахь

үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ:

21.2.1.оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийн дотоод хяналт;

21.2.2.оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд энэ хуульд заасан шаардлага хангаж байгаа эсэхэд тавих Монголбанкны хяналт;

21.2.3.хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдал.

21.3.Оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь онцгой ач холбогдол бүхий үйл ажиллагааны аутсорсингийн үйлчилгээ авах тохиолдолд Монголбанк дараахь шаардлагыг тавина:

21.3.1.аутсорсингийн үйлчилгээ авснаар удирдлагын үүрэг, хариуцлага шилжихгүй байх;

21.3.2.хэрэглэгчийн өмнө хүлээсэн төлбөрийн хэрэгсэл гаргагчийн үүрэг, хариуцлага, тэдгээрийн хоорондын харилцаанд нөлөөлөхгүй байх;

21.3.3.оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд энэ хуульд заасан шаардлагыг тогтмол хангаж ажиллах;

21.3.4.төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, төлбөрийн хэрэгсэл гаргах болон систем ажилуулах зөвшөөрөл олгосон үндэслэл, нөхцөлийг өөрчлөхгүй байх.

21.4.Доголдол, саатал нь оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийн зөвшөөрлийн нөхцөл, санхүүгийн үзүүлэлт, үйлчилгээний тасралтгүй, найдвартай байдалд тавигдах шалгуур үзүүлэлтэд үлэмж хэмжээгээр нөлөөлөхөөр бол тухайн үйл ажиллагааг онцгой ач холбогдол бүхий гэж тооцно.

22 дугаар зүйл.Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх

22.1.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь гэрээт төлөөлөгчөөр дамжуулан хэрэглэгчид төлбөрийн үйлчилгээ үзүүлэх бол шаардагдах баримт бичгийг үйлчилгээний хөлс төлсөн баримтын хамт Монголбанканд ирүүлнэ.

22.2.Монголбанк энэ хуулийн 22.1-д заасан баримт бичгийг хянаж, гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

22.3.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь гэрээт төлөөлөгчийг Монголбанканд бүртгүүлнэ. Монголбанк гэрээт төлөөлөгчийн бүртгэлийг хөтөлж, нийтэд мэдээлнэ.

22.4.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь Монголбанкны зөвшөөрөлгүйгээр гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

22.5.Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан үзүүлсэн төлбөрийн үйлчилгээний хариуцлагыг төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч хүлээнэ.

22.6.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь тухайн гэрээт төлөөлөгч түүний өмнөөс үйлчилгээ үзүүлж байгааг хэрэглэгчид мэдээлэх үүрэгтэй.

ТАВДУГААР БҮЛЭГ СИСТЕМИЙН ДҮРЭМ

23 дугаар зүйл. Системийн дүрмийг тогтоох

23.1.Оператор нь системийн зохистой засаглал, удирдлага, үйл ажиллагааны дүрэмтэй байна. Дүрэмд дараахь зүйлийг тусгана:

23.1.1.төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, зээлийн болон төлбөр тооцооны эрсдэлийн удирдлага;

23.1.2.төлбөрийн даалгавар, төлбөр тооцоог эцсийн гэж тооцох нөхцөл, хугацаа;

23.1.3.оролцогч, операторын эрх, үүрэг, системийн үйл ажиллагааны эрсдэл, компанийн зохистой засаглал, системд оролцох болон учирч болзошгүй нөхцөл байдлын үед авах арга хэмжээний зохицуулалт.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан дүрэм нь энэ хуульд заасан шаардлага, системийн зохистой засаглал, удирдлага, үйл ажиллагаатай холбогдуулан Монголбанкнаас баталсан зөвлөмж, аргачлал, журам, дүрэмтэй нийцсэн байна.

23.3.Оператор энэ хуулийн 23.1-д заасан дүрмийг Монголбанкаар хянуулж, бүртгэлийн дугаар авснаар уг дүрэм хүчин төгөлдөр болно.

24 дүгээр зүйл. Систем, системийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

24.1.Монголбанк дараахь асуудлаар системийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хүчингүй болгуулах арга хэмжээ авна:

24.1.1.нийтийн ашиг сонирхлыг хамгаалах;

24.1.2.оролцогчийн ашиг сонирхлыг хамгаалах;

24.1.3.системд оролцох этгээдийн эрхийг хамгаалах;

24.1.4.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

24.2.Оператор доор дурдсанаас бусад тохиолдолд систем, системийн дүрэмд системийн бүтэц, үйл ажиллагаа, эсхүл удирдлагад нөлөөлж болохуйц нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно:

24.2.1.Монголбанкнаас бичгээр зөвшөөрөл авсан;

24.2.2.Монголбанкнаас бичгээр зөвшөөрөл авсны дараа нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болохоос 30 хоногийн өмнө оролцогчид мэдэгдсэн.

24.3.Монголбанк мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдал, эсхүл нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, системийн аюулгүй байдлыг хангах зорилгоор системд өөрчлөлт оруулах зөвшөөрлийг операторт өгч болох бөгөөд энэ нь энэ хуулийн 24.2.2-т хамаарахгүй.

25 дугаар зүйл. Системд оролцох

25.1. Системийн дүрэм нь оролцогчдын эрх тэгш, үл ялгаварласан, тэнцвэртэй байдлыг хангасан байна.

25.2. Оператор нь дараахь эрсдэлээс хамгаалахдаа оролцогчийн систем дэх оролцоог зайлшгүй шаардлагатай хэмжээнээс хэтрүүлэн хязгаарлаж үл болно:

25.2.1. зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын болон системийн;

25.2.2. төлбөр тооцооны;

25.2.3. мэдээллийн систем, эсхүл дотоод хяналтын доголдлын улмаас үүссэн, урьдчилан мэдэх боломжгүй байсан алдагдал хүлээх.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХ

26 дугаар зүйл. Үйлчилгээний нөхцөл, түүний ил тод байдал

26.1. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчтэй гэрээ, хэлцэл байгуулахдаа үйлчилгээний нөхцөл, талуудын хүлээх үүргийг хэрэглэгчид ойлгомжтой байдлаар танилцуулна.

26.2. Энэ хуулийн 26.1-д заасан үйлчилгээний нөхцөлд дараахь мэдээллийг тусгана:

26.2.1. төлбөрийн хэрэгсэл, түүний нууц код, дансны хандалтын нууц код зэргийг алдсан, үрэгдүүлсэн, гээгдүүлсэн, зөвшөөрөлгүй этгээд ашигласан, гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй гэж үзсэн, эсхүл хэрэглэгчийн зөвшөөрөлгүй төлбөрийн үйлчилгээ хийгдсэн тохиолдолд нэн даруй мэдэгдэх талаархи хэрэглэгчийн хүлээх үүрэг, хариуцлага;

26.2.2. хэрэглэгчийн зөвшөөрөлгүй төлбөрийн үйлчилгээ хийгдсэн, эсхүл хийгдсэн байж болзошгүй тухай мэдэгдлийг хэрэглэгчээс хүлээж авах, баталгаажуулах арга хэмжээ;

26.2.3. хэрэглэгчийн хийсэн төлбөрийг гүйцэтгэх хугацаа;

26.2.4. хэрэглэгчийн хийж болох төлбөрийн үйлчилгээний төрөл, давтамж болон үнийн дүнгийн хязгаарлалт;

26.2.5. төлбөрийн үйлчилгээний хөлс;

26.2.6. урьдчилж зөвшөөрөл олгосон төлбөрийн үйлчилгээний хүрээнд төлбөрийг зогсоох хэрэглэгчийн эрх, түүнд холбогдох зохицуулалт;

26.2.7. төлбөрийн үйлчилгээтэй холбогдох мэдээллийг авах хэрэглэгчийн эрх;

26.2.8. алдаа гарсан үед залруулга хийх зохицуулалт, түүнд холбогдох хэрэглэгчийн эрх;

26.2.9. хэрэглэгчийн өмнө хүлээх төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хариуцлага;

26.2.10. хэрэглэгч нууц гэж үзсэн аливаа мэдээллийг эрх бүхий гуравдагч

этгээдэд гаргаж өгөх нөхцөл;

26.2.11.төлбөрийн хэрэгсэл гаргагчаас бусад этгээдийн ажиллуулж байгаа цахим төхөөрөмжөөр шилжүүлэг хийсэн тохиолдолд шимтгэл төлж болох тухай мэдээлэл.

26.3.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, оператор нь хэрэглэгчээс үйлчилгээний шимтгэл, хөлс авдаг бол энэ хуулийн 26.4-т заасны дагуу нийтэд мэдээлнэ.

26.4.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн энэ хуулийн 26.3-т заасан шимтгэл, хөлстэй холбогдох мэдээллийг хэрэглэгчийн үйлчилгээ авч байгаа газарт ил тод, харагдахуйц байршуулна.

26.5.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн энэ хуулийн 26.3-т заасан мэдээлэл нь Монголбанкнаас тавих шаардлагыг хангасан байна.

26.6.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, оператор нь энэ хуулийн 26.3-т заасан шаардлагыг биелүүлээгүй бол харилцагчаас шимтгэл, хөлс авахыг хориглоно.

26.7.Үйлчилгээний нөхцөл энгийн, ойлгомжтой байна.

26.8.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн дансны нууцлалыг хангах нөхцөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Монголбанкнаас баталсан журамд заасан хэлбэр, хугацаанд хэрэглэгчид мэдэгдэнэ.

27 дугаар зүйл.Хязгаарлагдмал хүрээнд үзүүлэх үйлчилгээ

27.1.Доор дурдсан нөхцөлийг бүхэлд нь, эсхүл аль нэгийг хангасан этгээдийг хязгаарлагдмал хүрээнд үйлчилгээ үзүүлэгч гэж үзнэ:

27.1.1.өмнөх 12 сарын хугацаанд хийсэн гүйлгээний нийт дүн нь Монголбанкнаас тогтоосон дүнгээс хэтрээгүй;

27.1.2.хэрэглэгчийн нийт тоо Монголбанкнаас тогтоосон тооноос хэтрээгүй.

27.2.Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хязгаарлагдмал хүрээнд үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийн үйл ажиллагаанд Монголбанк хяналт тавина.

27.3.Энэ хуулийн 27.1-д заасан үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага, түүний үйл ажиллагаанд хяналт тавих журмыг Монголбанк тогтооно.

ДОЛДУГААР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ХЯНАЛТ

28 дугаар зүйл.Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд тавих хяналт

28.1.Монголбанк үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.

28.2.Монголбанк төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн хэрэгсэл гаргагч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд болон операторын зохистой засаглал, удирдлага, үйл ажиллагаа, хэрэглэгчтэй холбогдох харилцаа, систем хоорондын хамаарлыг зохицуулсан журам, дүрэм баталж, шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

28.3.Монголбанк үндэсний төлбөрийн системийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн хэрэгсэл гаргагч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, операторын үйл ажиллагааг хянан шалгах, энэ хуулийн 44.1-д заасан арга хэмжээг авах эрхтэй.

28.4.Монголбанкны хяналт шалгалтыг Монголбанкнаас томилсон хянан шалгагч хэрэгжүүлнэ.

28.5.Оператор, оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь Монголбанкнаас шаардсан тохиолдолд энэ хуулийн 10.3-т заасан, Монголбанканд бүртгэлтэй аудитын үйлчилгээ үзүүлэх этгээдээр аудит хийлгэнэ.

29 дүгээр зүйл.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх

29.1.Оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг дагаж мөрдөнө.

29.2.Оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь гэрээт төлөөлөгч, аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээдэд энэ хуулийн 29.1-д заасан хуулийг мөрдүүлэх үүргийг хүлээнэ.

30 дугаар зүйл.Зөвшөөрөл эзэмшигчийн төлбөрийн системд холбогдох үйл ажиллагааны баримт бичгийн хадгалалт, хамгаалалт

30.1.Оператор, оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь төлбөрийн системд холбогдох үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийг хүлээн авсан, эсхүл үүссэн өдрөөс хойш 15-аас доошгүй жил хадгална.

30.2.Энэ хуулийн 30.1-д заасан баримт бичгийг Монголбанк болон холбогдох төрийн байгууллагын хамтран баталсан журмын дагуу хадгалж, хамгаална.

31 дүгээр зүйл.Мэдээлэл авах

31.1.Оператор, оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь Монголбанк, түүний хянан шалгагчийн шаардсаны дагуу өөрийн үйл ажиллагаанд холбогдох баримт бичиг, данс бүртгэл, тайлан, тэнцэл, санхүүгийн баримт, тайлбар, лавлагаа, шаардлагатай бусад баримтыг тогтоосон хугацаанд гаргаж өгнө.

31.2.Оператор, оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь энэ хуулийн 31.1-д заасан мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.

32 дугаар зүйл.Мэдээллийн нууцлал

32.1.Монголбанк, Монголбанкны албан тушаалтан, ажилтан энэ хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэхдээ олж авсан мэдээллийн нууцлалыг доор дурдсанаас бусад тохиолдолд шууд болон шууд бусаар задруулахыг хориглоно:

32.1.1.энэ хуульд заасан чиг үүргийг гүйцэтгэх;

32.1.2.үндэсний төлбөрийн системийн үр ашигтай, найдвартай, аюулгүй байдал, санхүүгийн нэгдмэл байдлыг хангах шаардлагатай нөхцөл байдал үүссэн;

32.1.3.шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл авлигатай тэмцэх болон цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шаардлагаар, түүнчлэн тагнуулын байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах шаардлагаар тэдгээрийн удирдлагын хүсэлтийг прокурор зөвшөөрсөн;

32.1.4.шүүхийн шийдвэр гарсан;

32.1.5.Монгол Улсын олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүргийг биелүүлэх.

33 дугаар зүйл.Үйлчилгээний хөлс, шимтгэл

33.1.Монголбанк нь оператор, оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс үйлчилгээний хөлс, шимтгэл авна. Хөлс, шимтгэлийн хэмжээг Монголбанк тогтооно.

33.2.Үндэсний төлбөрийн системийн үйл ажиллагаатай холбогдох хөлс, шимтгэлийн нөхцөл, хувь хэмжээний дээд хязгаарыг Монголбанк батална.

НАЙМДУГААР БҮЛЭГ

МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЦАХИМ ШИЛЖҮҮЛЭГ, ЦАХИМ МӨНГӨ

34 дүгээр зүйл.Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлгийн хэрэгжилт, нотолгоо

34.1.Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлгийн бүртгэлийн бичилтийг холбогдох хууль, Монголбанкнаас баталсан журмын дагуу гүйцэтгэнэ.

34.2.Монголбанк цахим мэдээний дагуу хийгдсэн мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг, төлбөрийн даалгавартай холбогдох харилцааг зохицуулах журам, заавар баталж, шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

35 дугаар зүйл.Цахим мөнгө, цахим мөнгө гаргагчид тавих шаардлага

35.1.Төлбөрийн хэрэгсэл гаргах зөвшөөрөл бүхий этгээд нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу цахим мөнгө гаргана.

35.2.Цахим мөнгө дараахь шинжийг нэгэн зэрэг агуулсан байна:

35.2.1.мөнгөн дүн нь цахим хэлбэрээр хадгалагдсан;

35.2.2. мөнгөн хөрөнгөөр баталгаажсан;

35.2.3. цахим мөнгө гаргагч, түүний харилцагчаас бусад гуравдагч этгээд төлбөрт хүлээн зөвшөөрсөн;

35.2.4. цахим мөнгө нь мөнгөн хөрөнгөд, мөнгөн хөрөнгө нь цахим мөнгөнд чөлөөтэй хөрвөх.

35.3. Нэг цахим мөнгө нь нэг төгрөгтэй тэнцүү байна. Цахим мөнгөний доод нэгж нь нэг цахим мөнгө байна.

35.4. Хүсэлт гаргагч нь цахим мөнгө гаргах зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл хүссэн бол энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлагаас гадна дараахь нөхцөлийг хангасан байна:

35.4.1. цахим мөнгө нь зээлийн эх үүсвэр болохгүй;

35.4.2. цахим мөнгө гаргагч нь эргэлтэд оруулсан, буцаан татсан цахим мөнгөний дүнг санхүүгийн тайланд тусгах ба эдийн засаг дахь цахим мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ, эргэлтийн хурд зэрэгт хяналт тавьж, шинжилгээ хийхэд Монголбанканд шаардлагатай үнэн зөв мэдээллийг гаргаж өгнө;

35.4.3. клирингийн болон төлбөр тооцооны үйл ажиллагаа нь оролцогчийн төлбөр тооцооны системд төлбөр гүйцэтгэх даалгавар үүссэн даруй төлбөрийн эцэслэлт хийгдэх боломжтой байна;

35.4.4. хэрэглэгчийн анхны шаардлагаар цахим мөнгө болон төгрөгийг харилцан хөрвүүлэх үүрэг хүлээнэ.

35.5. Цахим мөнгөнд хөрвүүлэх зорилгоор хүлээн авсан, эсхүл цахим мөнгөнд хөрвөсөн мөнгөн хөрөнгийг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд тооцохгүй.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ТӨЛБӨР ТООЦОО, ҮР ДҮНГИЙН ТООЦООЛОЛ, ТӨЛБӨРИЙН ЭЦЭСЛЭЛТ

36 дугаар зүйл. Төлбөр тооцоо

36.1. Төлбөр тооцооны системээр дамжуулсан гүйлгээ бүрийн оролцогч хооронд хийгдэх төлбөр тооцоог төлбөр тооцооны дүрмийн дагуу хийнэ.

36.2. Төлбөр тооцооны дүрэмд оролцогчоос төлбөрийн систем, клирингийн төв, арилжааны төлбөр тооцоог төвлөрүүлэн гүйцэтгэх эрх бүхий этгээд, бусад оролцогчийн өмнө хүлээсэн төлбөр тооцооны аливаа үүргээ гүйцэтгэх, гүйцэтгэх боломжгүй болох, эсхүл ийм нөхцөл байдал үүсч болзошгүй үед авах арга хэмжээ зэргийг тусгана.

36.3. Шууд оролцогч нь төлбөр тооцооны дансыг Монголбанканд дээр байршуулна.

36.4. Оролцогч хоорондын төлбөр тооцоог Монголбанканд дахь төлбөр тооцооны дансаар дамжуулан гүйцэтгэнэ.

36.5. Төлбөр тооцооны төлөөлөгчид тавих шаардлагыг Монголбанк тогтооно.

36.6. Оролцогч нь энэ хуулийн 36.5-д заасан шаардлагыг хангасан шууд

оролцогчоор төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгүүлж болно.

36.7.Оролцогч нь энэ хуулийн 36.6-д заасны дагуу төлбөр тооцооны үүргээ төлбөр тооцооны төлөөлөгчөөр гүйцэтгүүлэх бол тухайн оролцогчийн өмнөөс аливаа төлбөр тооцооны үүргийг төлбөр тооцооны төлөөлөгч гүйцэтгэхээс өмнө түүнийг томилсон тухай мэдэгдэл болон зөвшөөрлийг операторт хүргүүлнэ.

36.8.Оролцогч нь тухайн төлбөр тооцооны төлөөлөгчөөс татгалзах тохиолдолд энэ тухай операторт 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

37 дугаар зүйл.Үр дүнгийн тооцоолол хийх

37.1.Оролцогчийн өглөг, бусад оролцогчоос хүлээж авах авлагын дүнг цэвэршүүлж, хоёр болон олон талын, үүрэг дуусгавар болгох үеийн, үүрэг гүйцэтгэх боломжгүй болох үеийн төлбөрийн үр дүнгийн тооцоолол, эсхүл эдгээрийн холимог хэлбэрийн үр дүнгийн тооцооллыг хийж, үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг тодорхойлно.

37.2.Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хийсэн шилжүүлэг, түүний үр дүнгийн тооцоолол нь гуравдагч этгээдийн өмнө хүчин төгөлдөр байна.

38 дугаар зүйл.Төлбөрийн эцэслэлт

38.1.Оролцогчийн төлбөр системд орсон тохиолдолд төлбөрийн эцэслэлт хүчин төгөлдөр болно.

38.2.Оператор нь төлбөрийн эцэслэлт, үл буцаагдах байдлыг хангах тухай системийн дүрэмд тусгана.

38.3.Төлбөрийн эцэслэлт энэ хуулийн 38.1-д заасны дагуу хүчин төгөлдөр болсон тохиолдолд буцаан дуудах, эргүүлэн татах, тусгаарлахыг хориглоно.

39 дүгээр зүйл.Төлбөр тооцооны барьцаа хөрөнгө

39.1.Төлбөрийн найдвартай, аюулгүй байдлыг хангах, системд хүлээсэн үүргээ гүйцэтгэх баталгаа болгох зорилгоор оператор, шууд оролцогч Монголбанканд барьцаа хөрөнгө байршуулна.

39.2.Засгийн газрын төлбөр, түүнтэй холбогдох төлбөр тооцоог гүйцэтгэгч санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад энэ хуулийн 39.1 дэх хэсэг хамаарахгүй.

АРАВДУГААР БҮЛЭГ **ТАТАН БУУЛГАХ, ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ ҮЕД** **АВАХ АРГА ХЭМЖЭЭ**

40 дүгээр зүйл.Шийдвэрийг Монголбанканд хүргэх

40.1.Оператор, оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь тэдгээрийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх шийдвэр гарсан буюу Иргэний хэрэг шүүхэд

хянан шийдвэрлэх тухай хуулийн 119.4-т заасны дагуу оролцогч шүүхийн шийдвэрийг гардан авсан даруй тухайн шийдвэрийн хувийг Монголбанканд хүргүүлэх үүрэг хүлээнэ.

41 дүгээр зүйл. Систем ажиллуулах, системд оролцохыг хязгаарлах, хориглох

41.1. Оператор, оролцогчийг татан буулгах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр гарсан тохиолдолд Монголбанк уг шийдвэрийг хүлээн авсан өдрөөс эхлэн оператор, оролцогчийг төлбөр тооцооны системд оролцохыг хориглоно.

41.2. Оператор, оролцогчийг дахин хөрөнгөжүүлэх шийдвэр гарсан тохиолдолд Монголбанк зөвшөөрөх хүртэл хугацаанд тухайн этгээдийг систем ажиллуулах, системд оролцохыг хориглоно.

42 дугаар зүйл. Татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх арга хэмжээ төлбөрийн эцэслэлтэд үл нөлөөлөх

42.1. Оролцогчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх арга хэмжээ авахтай холбогдсон шийдвэрийг Монголбанк хүлээн авахаас өмнө энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хийсэн төлбөрийн эцэслэлт, төлбөрийн үл буцаагдах байдалд уг шийдвэр нөлөөлөхгүй.

43 дугаар зүйл. Хэрэг гүйцэтгэгчийн авах арга хэмжээ

43.1. Оролцогч татан буугдсан, оролцогчийг дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхэлсэн, шүүхээс төлбөрийн чадваргүй гэж тооцсон тохиолдолд хэрэг гүйцэтгэгч нь бусад оролцогчийн өмнө системийн дүрмийн дагуу хариуцагчийн хүлээсэн төлбөрийн болон төлбөр тооцооны үүргийн гүйцэтгэлийг дараахь тохиолдолд хангана:

43.1.1. татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө, эсхүл төлбөрийн чадваргүйд тооцсон шүүхийн шийдвэрийг Монголбанк хүлээн авахаас өмнө тодорхойлсон үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг;

43.1.2. татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх шийдвэрийг Монголбанк хүлээн авсан өдөр, эсхүл түүний дараа өдөр биелүүлэх үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД

44 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага

44.1. Оператор, оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, түүний албан тушаалтан үндэсний төлбөрийн системийн тухай хууль тогтоомж зөрчсөн бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан Монголбанк дараахь арга хэмжээ авна:

44.1.1. албан бичгээр сануулга өгөх;

44.1.2. зөрчлийг арилгах талаар хугацаатай даалгавар өгөх;

44.1.3.энэ хуулийн 44.2-т заасан захиргааны хариуцлага ногдуулах;

44.1.4.оператор, оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийн гүйцэтгэх удирдлагыг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, эсхүл чөлөөлөх талаар төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэл өгөх;

44.1.5.оператор, оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийн үйл ажиллагааг хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, түдгэлзүүлэх;

44.1.6.оператор, оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийн зөвшөөрлийг хүчингүй болгох.

44.2.Үндэсний төлбөрийн системийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Монголбанкны хянан шалгагч Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулна.

44.3.Энэ хуулийн 44.2-т заасан шийтгэлийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ.

44.4.Үндэсний төлбөрийн системийн тухай хууль тогтоомж зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг Иргэний хуулийн дагуу нөхөн төлүүлнэ.

44.5.Энэ хуулийн 44.2-т заасан шийтгэлийг үндэслэлгүй гэж үзвэл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлүүлнэ.

45 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

45.1.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах эрх зүйн үндсийг тогтооход оршино.

2 дугаар зүйл.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж

2.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2¹ дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

2¹.1.Энэ хуульд заасан терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бүхий л зохицуулалтад үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх аливаа үйл ажиллагаа нэгэн адил хамаарна.

/Энэ зүйлийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг;

/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

3.1.2.“терроризмыг санхүүжүүлэх” гэж террорист байгууллага, террорист хүн, эсхүл террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг;

3.1.3.“бэлэн мөнгөний гүйлгээ” гэж үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглаж хийсэн гүйлгээг;

3.1.4.“бэлэн бус мөнгөний гүйлгээ” гэж олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, инкасс, төлбөрийн карт, цахим төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр хийсэн гүйлгээг;

3.1.5.“улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн3 20.2-г заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг;

/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

3.1.6.“эцсийн өмчлөгч” гэж:

/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

3.1.6.а.харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

3.1.6.б.харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

3.1.6.в.хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

3.1.7.“халхавч банк” гэж гүйцэтгэх удирдлага болон үйл ажиллагаа нь тухайн зөвшөөрөл авсан, эсхүл бүртгүүлсэн улсдаа бодитоор оршин байдаггүй, эсхүл тусгай зохицуулалттай ба нэгдсэн хяналт шалгалтад хамрагддаг санхүүгийн

байгууллагад хамаардаггүй банкийг банкийг;

/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

3.1.8. “харилцагч” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээдээр үйлчлүүлж байгаа этгээдийг;

3.1.9. “хөрөнгө” гэж Иргэний хуулийн 483 дугаар зүйлд заасныг;

/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

3.1.10. “гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 2-т заасныг;

/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

3.1.11. “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг;

/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

3.1.12. “үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч” гэж үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүнийг;

/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

3.1.13. “хөрөнгийг удирдах” гэж харилцагчийн хөрөнгийг түүний нэрийн өмнөөс ашиглах, эзэмших, захиран зарцуулахыг.

/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

ХОЁРДУГААР БҮЛЭГ

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4 дүгээр зүйл. Мэдээлэх үүрэгтэй этгээд

4.1. Дараах этгээд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний талаар энэ хуулийн 16.1-д заасан Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй:

4.1.1. банк;

4.1.2. банк бус санхүүгийн байгууллага;

4.1.3. даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;

4.1.4. хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;

/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

4.1.5. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;

4.1.6. хадгаламж, зээлийн хоршоо;

4.1.7. харилцагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;

/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

4.1.8. энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;

/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

4.1.9. нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь харилцагчийн нэрийн өмнөөс дараах ажиллагааг хийсэн бол:

4.1.9.а. үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;

4.1.9.б. харилцагчийн хөрөнгийг удирдах;

4.1.9.в. банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;

4.1.9.г. компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;

4.1.9.д. хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

4.2. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр данс нээх, гүйлгээ хийх, хаагдсан данс ашиглахыг хориглоно.

4.3. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх бөгөөд ийнхүү хэрэгжүүлэхдээ дараах эрсдэлийг харгалзан өөрийн аж ахуйн үйл ажиллагааны онцлог, хамрах хүрээнд нийцүүлэн бодитойгоор үнэлнэ:

4.3.1. харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл;

4.3.2. бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хамаарч үүсэх эрсдэл;

4.3.3. бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл;

4.3.4. газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэл.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

4.4. Энэ хуулийн 4.3-т заасан эрсдэлийг үнэлэхэд ашигласан баримт, мэдээллийг энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан хугацаанд хадгалах ба энэ хугацаанд эрх бүхий хянан шалгагч, улсын байцаагчийн шаардсан даруйд гарган өгөхөд бэлэн байлгана.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

4¹ дүгээр зүйл. Эцсийн өмчлөгчийг тогтоох

/Энэ зүйлийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

4¹.1. Эцсийн өмчлөгчийг дараах дарааллаар шалгаж тогтооно:

4¹.1.1. хувьцааны дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүнийг;

4¹.1.2. энэ хуулийн 4¹.1.1-д заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн

этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж байгаа, эсхүл өөрийн эрхээ бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хүнийг;

4¹.1.3.энэ хуулийн 4¹.1.1, 4¹.1.2-т заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэгч хүнийг.

4¹.2.Эцсийн өмчлөгчийг шалгаж тогтоох талаар авч хэрэгжүүлэх нарийвчилсан үйл ажиллагааг энэ хуулийн 5.14-т заасан журмаар зохицуулна.

5 дугаар зүйл.Харилцагчийг таньж мэдэх

5.1.Дараах тохиолдолд энэ хуулийн 4.1-д заасан этгээд харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүрэгтэй:

5.1.1.санхүүгийн харилцаа үүсгэхийн өмнө;

5.1.2.дансгүй, эсхүл санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээд тохиолдлын чанартайгаар 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;

5.1.3.харилцагчийн 24 цагийн дотор хийсэн, хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь энэ хуулийн 5.1.2-т заасан хэмжээнээс бага боловч нийт үнийн дүн нь 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй бол;

5.1.4.харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзсэн тохиолдолд;

5.1.5.тухайн харилцагч, тухайн гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэсэн тохиолдолд.

5.2.Энэ хуулийн 5.1-д заасны дагуу харилцагчийг таньж мэдэхийн тулд энэ хуулийн 4.1-д заасан этгээд дараах арга хэмжээ авна:

5.2.1.харилцагч нь иргэн бол түүний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, иргэний үнэмлэхийн, эсхүл гадаад паспортын хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргуулж авах;

5.2.2.харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, оршин байгаа газрын хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг гаргуулж авах;

5.2.3.эцсийн өмчлөгчийн нэрийн өмнөөс данс нээж, гүйлгээ хийж байгаа эсэхийг мэдэх, ойлгох зорилгоор тухайн бизнесийн харилцааны зорилго, гүйлгээний утга, эцсийн хүлээн авагчийн тухай мэдээллийг тодруулах;

5.2.4.харилцагч нь хуулийн этгээд бол түүний эцсийн өмчлөгчийн овог,

эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, эцсийн өмчлөгчийн талаар болон харилцагчийн өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхтэй холбоотой боломжит бүх арга хэмжээг авах;

5.2.5. харилцагч нь хуулийн этгээд, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч бол түүний нэрийн өмнөөс харилцах этгээд нь тийм эрхтэй эсэхийг нягталж уг этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, баримт бичигтэй нь тулгаж шалгах;

5.2.6. банк, санхүүгийн байгууллагын хоорондын шилжүүлэг хийгч, хүлээн авагчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, харилцах утасны дугаар, дансны дугаарыг авах.

/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

5.3. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь харилцагчийн эрсдэлийн түвшинг үнэлж, өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх ба уг үйл ажиллагааг энэ хуулийн 5.14-т заасан журмаар зохицуулна.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

5.4. Харилцагч энэ хуулийн 5.2, 5.3-т заасны дагуу шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзвал энэ хуулийн 4.1-д заасан этгээд түүнд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй.

/Энэ хэсэгт 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

5.5. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь дараах тохиолдолд харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг энэ хуулийн 5.2.1, 5.2.2-т заасан хүрээнд харилцагчийг таньж мэдэх хялбаршуулсан үйл ажиллагааг хийж болно:

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

5.5.1. харилцагч нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, эсхүл хөрөнгийн биржид бүртгэлтэй компани нь хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийг ил тод мэдээлэх үүрэгтэй бол;

5.5.2. ижил түвшний урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг мэдээлэх үүрэгтэй этгээд хоорондоо харилцахад.

5.6. Энэ хуулийн 4.1.1-д заасан этгээд нь гадаад гуйвуулга, шилжүүлэг, төлбөр тооцоо хийх зорилгоор гадаад улсын банктай корреспондент харилцаа тогтоохоос өмнө дараах мэдээллийг авсан байна:

5.6.1. тухайн банкны үйл ажиллагааны чиглэлийн талаарх мэдээлэл;

5.6.2. тухайн банк нь нийтэд танигдсан байдлын талаарх мэдээлэл;

5.6.3. корреспондент харилцааг тогтоох талаар гаргасан удирдлагын шийдвэр, уг харилцаанд оролцогч талуудын эрх, үүргийг харилцан тохирсон тухай мэдээлэл;

5.6.4. тухайн банк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, дотоод хяналтын хөтөлбөртэй эсэх;

5.6.5. тухайн банк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд холбогдон шалгагдсан, шалгагдаж байгаа эсэх талаарх мэдээлэл.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

5.7.Энэ хуулийн 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7-д заасан этгээдэд:

5.7.1.халхавч банктай харилцахыг;

5.7.2.халхавч банктай харилцаа тогтоосон банктай харилцахыг;

5.7.3.халхавч банктай өмнө нь харилцаа тогтоосон байсан бол харилцааг үргэлжлүүлэхийг хориглоно.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

5.8.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь шинэ бүтээгдэхүүн, технологи нэвтрүүлэхийн өмнө түүний мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдаж болох эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

5.9.Дараах харилцагчийг өндөр эрсдэлтэй харилцагчийн нэгэн адил авч үзнэ:

5.9.1.улс төрд нөлөө бүхий этгээд;

5.9.2.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд;

5.9.3.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

5.10.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн хийх, хүлээн авах, дамжуулах шилжүүлэг нь шилжүүлэгч, хүлээн авагчийн талаарх тодорхой мэдээллийг бүрэн агуулсан байх ба шилжүүлэгч, хүлээн авагчийн мэдээлэл тодорхой бус тохиолдолд шилжүүлэг хийх, хүлээн авах, дамжуулахаас татгалзана.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

5.11.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан мэдээлэлд байнгын хяналт тавьж, өөрчлөлт орсон тухай бүрд мэдээллийг шинэчилнэ.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

5.12.Энэ хуулийн 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7-д заасан этгээд нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр хийлгэх тохиолдолд тавигдах шаардлагыг энэ хуулийн 5.14-т заасан журмаар зохицуулна.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

5.13.Гуравдагч этгээдээр харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хийлгэх нь энэ хуулийн 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7-д заасан этгээдийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

5.14.Дараах нарийвчилсан үйл ажиллагааг тусгасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал

эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална:

5.14.1.эцсийн өмчлөгчийг шалгаж тогтоох талаар авч хэрэгжүүлэх нарийвчилсан үйл ажиллагаа;

5.14.2.харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа;

5.14.3.харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа;

5.14.4.харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр хийлгэх тохиолдолд тавигдах шаардлага;

5.14.5.эрсдэлийн үнэлгээний талаарх нарийвчилсан үйл ажиллагаа;

5.14.6.дотоод хяналтын хөтөлбөрийн талаар;

5.14.7.хориг арга хэмжээний жагсаалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээ;

5.14.8.холбогдох бусад арга хэмжээ.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

6 дугаар зүйл.Тусгай хяналт

6.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд дараах гүйлгээнд тусгайлан хяналт тавих үүрэгтэй:

6.1.1.огцом өөрчлөгдсөн их дүнтэй;

6.1.2.эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй;

6.1.3.улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийсэн;

6.1.4.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсаар дамжуулан хийсэн.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан гүйлгээний талаар энэ хуулийн 4.1-д заасан этгээд нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах, гүйлгээ, бизнесийн харилцааны зорилго, мөн чанарыг боломжийн хүрээнд шалгаж, үр дүнг бичгээр хадгална.

6¹ дүгээр зүйл.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл болон эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх

/Энэ зүйлийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

6¹.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад нийцүүлэн Терроризмтой тэмцэх тухай хуулийн 6.1.4-т заасны дагуу баталсан хориг арга хэмжээний жагсаалт /цаашид “хориг арга хэмжээний жагсаалт” гэх/-д орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлд аливаа үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

6¹.2.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь хориг арга хэмжээний жагсаалтад хамаарах хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийн нэр илэрсэн, мэдсэн даруйд урьдчилан мэдэгдэлгүйгээр холбогдох данс, хөрөнгийн хөдөлгөөнийг шууд зогсоож, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх эрхгүй

болгож, энэ тухай Санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдээлнэ.

6^{1.3}. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улс орон, нутаг дэвсгэрийн харилцагч нарт харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх ба шаардлагатай бол хууль, хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасан арга хэмжээг авна.

6^{1.4}. Хориг арга хэмжээний жагсаалтыг энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд хүргэх, хориг арга хэмжээ болон хуульд заасан бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх, эдгээр арга хэмжээний хэрэгжилтийн тайлан гаргахтай холбогдсон харилцааг энэ хуулийн 5.14-т заасан журмаар зохицуулна.

7 дугаар зүйл. Гүйлгээний талаар мэдээлэх

7.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.

7.2. Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.

/Энэ хэсэгт 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

7.3. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд мэдээллийг факс, цахим хэлбэрээр, эсхүл бичгээр Санхүүгийн мэдээллийн албанд түүний баталсан маягт, журмын дагуу хүргүүлэх үүрэгтэй.

7.4. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд Монголбанкны Ерөнхийлөгч, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан мэдээлэл өгөх журмын дагуу тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын тухай мэдээллийг эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад гаргаж өгнө.

8 дугаар зүйл. Харилцагчийн талаарх баримт, материалыг хадгалах

8.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд харилцагчийн хийсэн гүйлгээ, данс болон харилцагчийн талаар энэ хуулийн 5, 6 дугаар зүйлд заасны дагуу олж авсан мэдээлэл, баримт бичгийг тухайн данс хаагдсан, эсхүл гүйлгээ хийгдсэнээс хойш таваас доошгүй жилийн хугацаанд хадгална.

8.2. Энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэл, баримт бичгийг энэ хуулийн 4.1-д заасан этгээд эрх бүхий хууль сахиулах байгууллагын хүсэлтээр шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгална.

9 дүгээр зүйл.Сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл

9.1.Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл дараах агуулгатай байна:

9.1.1.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн нэр, оршин байгаа газрын хаяг болон мэдээлэл хүргүүлсэн албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

9.1.2.харилцагч, хүлээн авагчийн талаарх мэдээлэл;

9.1.3.тухайн гүйлгээний утга, үнийн дүн, гүйцэтгэсэн хэлбэр, он, сар, өдөр, дансны дугаар, гүйлгээний бусад оролцогч болон данс эзэмшигчийн талаарх мэдээлэл;

9.1.4.тухайн гүйлгээг сэжиглэх болсон үндэслэл, нөхцөл байдлын тухай товч тайлбар;

9.1.5.холбогдох бусад баримт бичиг.

9.2.Санхүүгийн мэдээллийн алба нь сэжигтэй гүйлгээтэй холбогдсон этгээдийн дансны хуулбар, данс нээхэд ашигласан бичиг баримтын хуулбар, банкны харилцагчийн эрсдэлийг үнэлсэн баримт бичиг зэрэг нэмэлт мэдээллийг энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс гаргуулан авах эрхтэй.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

10 дугаар зүйл.Дансанд хяналт тавих

10.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд ашиглаж байгаа гэж үзэх үндэслэл байгаа бол Санхүүгийн мэдээллийн алба энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн харилцагчийн дансанд хяналт тавьж болно.

11 дүгээр зүйл.Хөрөнгө битүүмжлэх, түдгэлзүүлэх

11.1.Хийгдэхээр хүлээгдэж байгаа гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой гэж үзэх үндэслэлтэй бол Санхүүгийн мэдээллийн албаны дарга тухайн гүйлгээг ажлын гурав хүртэл өдрийн хугацаагаар түдгэлзүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд шүүх уг хугацааг сунгаж болно.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан шийдвэрийг энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бичгээр, боломжгүй бол утсаар мэдэгдэж, шийдвэрийг 24 цагийн дотор хүргүүлнэ.

11.3.Энэ хуулийн 11.1-д заасны дагуу гүйлгээг түдгэлзүүлэх хугацаанд Санхүүгийн мэдээллийн алба дараах арга хэмжээ авна:

11.3.1.тухайн гүйлгээний талаар гадаад, дотоодын холбогдох байгууллагаас шаардлагатай мэдээлэл цуглуулах;

11.3.2.тухайн гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой байсан гэж үзэх баримт, үндэслэл тогтоогдсон бол энэ тухай эрх бүхий хууль сахиулах байгууллагад мэдэгдэж холбогдох баримт бичгийг нэн даруй шилжүүлэн шалгуулах;

11.3.3.тухайн гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсан гэдэг нь тогтоогдвол гүйлгээг түдгэлзүүлэх тухай шийдвэрийг цуцалж, энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд нэн даруй мэдэгдэх.

12 дугаар зүйл.Хариуцлагаас чөлөөлөх

12.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад энэ хуульд заасан журмын дагуу мэдээлэл өгснийг банкны, мэргэжлийн, мэргэжлийн үйл ажиллагааны, үйлчлүүлэгчийн, аж ахуйн нэгж, байгууллагын, бизнесийн болон бусад нууц задруулсан гэж үзэхгүй.

/Энэ хэсэгт 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

12.2.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсныг тогтоосон нь тухайн мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээдийг мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

/Энэ хэсэгт 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

12.3.Тодорхой гүйлгээг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан журмын дагуу түдгэлзүүлснээс иргэн, хуулийн этгээдэд гэм хор учирсан нь энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний удирдлага, ажилтан болон Санхүүгийн мэдээллийн алба, тус албаны албан хаагчийг Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

12.4.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд болон Санхүүгийн мэдээллийн албаны хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд гэм хор учирсан бол хохирлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

13 дугаар зүйл.Мэдээллийн нууцлалыг хадгалах

13.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний удирдлага, ажилтан нь Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг энэ хуулийн 7.4-т зааснаас бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглоно.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

13.2.Санхүүгийн мэдээллийн албаны дарга, хянан шалгагч, шинжээч, ажилтан албан үүргийнхээ дагуу олж авсан харилцагчийн гүйлгээтэй холбогдох мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хугацаанд болон ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш задруулахыг хориглоно.

14 дүгээр зүйл.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналт

/Энэ зүйлийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

14.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь түүний төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл түүнтэй адилтгах удирдлагаас баталсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байна.

14.2.Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр нь энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцсэн байх ба мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор үр дүнтэй арга хэмжээ авч

хэрэгжүүлэх боломжийг хангасан байна.

14.3.Дотоод хяналтын хөтөлбөрийг энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн харьяалагддаг санхүүгийн нэгдэл, тэдгээрийн бүх салбар нэгж, охин компани нь нэгэн адил хэрэгжүүлнэ.

14.4.Дотоод хяналтын хөтөлбөрт дараах асуудлыг тусгана:

14.4.1.харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх үйл ажиллагаанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх аргачлал;

14.4.2.өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам;

14.4.3.шинэ технологи болон өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний зохицуулалт;

14.4.4.харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааны журам;

14.4.5.харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхэд дагаж мөрдөх зохицуулалт;

14.4.6.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл, төрийн болон олон улсын холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт;

14.4.7.тусгайлан хяналт тавих үйл ажиллагааны журам;

14.4.8.корреспондент банкны харилцаа тогтоох журам;

14.4.9.мөнгөн гуйвуулга, цахим төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам;

14.4.10.сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх, хадгалах журам;

14.4.11.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх, үүрэг;

14.4.12.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөр;

14.4.13.хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасан бусад нөхцөл, шаардлага.

14.5.Дотоод хяналтын хөтөлбөрийг энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь өөрийн харьяалагддаг хяналт тавих эрх бүхий байгууллагад хүргүүлж бүртгүүлнэ.

14.6.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороо, эсхүл бие даасан дотоод хяналтын нэгжээр дамжуулан дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллана.

15 дугаар зүйл. Монгол Улсын хилээр бэлэн мөнгө оруулах, гаргах

15.1. Зорчигч 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлэх бол энэ тухай гаалийн мэдүүлэгт үнэн зөв мэдүүлнэ.

15.2. Энэ хуулийн 15.1-д заасны дагуу мэдүүлсэн бэлэн мөнгөний мэдүүлгийг гаалийн байгууллага нэгтгэж, сар бүр холбогдох журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлнэ.

15.3. Энэ хуулийн 15.2-т заасан мэдүүлгийн маягтын загварыг Санхүүгийн мэдээллийн албаны даргатай зөвшилцөж Гаалийн ерөнхий газрын дарга батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

16 дугаар зүйл. Санхүүгийн мэдээллийн алба

16.1. Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах гэмт хэрэг, түүнд холбогдох гэмт хэрэг, зөрчил болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээлэл, энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага байна.

/Энэ хэсэгт 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

16.2. Санхүүгийн мэдээллийн алба нь Монголбанкны дэргэд ажиллана.

16.3. Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг тус албаны дарга, үйл ажиллагааны төсвийг тус албаны даргын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална.

/Энэ хэсэгт 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

16.4. Санхүүгийн мэдээллийн албаны даргыг эрх бүхий хууль сахиулах байгууллагын даргатай зөвшилцөн Монголбанкны Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.

16.5. Санхүүгийн мэдээллийн албаны дарга дараах шаардлагыг хангасан байна:

16.5.1. банк, санхүү, эсхүл хууль зүйн салбарт таваас доошгүй жил ажилласан;

16.5.2. зээлийн болон баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй.

16.6. Санхүүгийн мэдээллийн албаны хянан шалгагч, шинжээч дараах шаардлагыг хангасан байна:

16.6.1. банк, санхүү, эсхүл хууль зүйн салбарт хоёроос доошгүй жил ажилласан;

16.6.2. зээлийн болон баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй.

16.7. Санхүүгийн мэдээллийн албаны дарга нь санхүүгийн мэдээллийн улсын

ахлах байцаагч, хянан шалгагч, шинжээч нь санхүүгийн мэдээллийн улсын байцаагч байна.

16.8.Санхүүгийн мэдээллийн албаны улсын ахлах байцаагчийн эрхийг Монголбанкны Ерөнхийлөгч, улсын байцаагчийн эрхийг улсын ахлах байцаагч олгоно.

16.9.Санхүүгийн мэдээллийн албаны дарга болон хянан шалгагч, шинжээч шаардлагатай тохиолдолд хяналт шалгалт хийх, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагаас лавлагаа гаргуулж авах бүрэн эрхтэй.

16.10.Санхүүгийн мэдээллийн албаны дотоод үйл ажиллагаатай холбогдох бусад журам, зааврыг Санхүүгийн мэдээллийн албаны дарга батална.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

17 дугаар зүйл. Эрх бүхий хууль сахиулах байгууллагын чиг үүрэг

17.1.Санхүүгийн мэдээллийн албанд эрх бүхий хууль сахиулах байгууллагын төлөөллийг ажиллуулна.

17.2.Эрх бүхий хууль сахиулах байгууллагын төлөөлөл нь энэ хуулийн 16.9-д заасны дагуу хяналт шалгалт хийх, санхүүгийн лавлагаа гаргуулж авах эрхтэй.

17.3.Энэ хуулийн 17.1-д заасан төлөөллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагын даргын саналыг үндэслэн Санхүүгийн мэдээллийн албаны дарга томилж, чөлөөлнө.

17.4.Шаардлагатай тохиолдолд эрх бүхий хууль сахиулах байгууллага, Санхүүгийн мэдээллийн алба хамтарсан ажлын хэсэг гарган ажиллаж болно.

18 дугаар зүйл. Санхүүгийн мэдээллийн албаны чиг үүрэг

18.1.Санхүүгийн мэдээллийн алба энэ хуулийн 10, 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.1.энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх;

18.1.2.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй гүйлгээ байна гэж үзсэн тохиолдолд тухайн мэдээллийг хуульд заасан журмын дагуу эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад шилжүүлэх, шилжүүлсэн сэжигтэй бэлэн ба бэлэн бус мөнгөний гүйлгээний талаар мэдээллийн сан бүрдүүлэх;

18.1.3.сэжигтэй бэлэн ба бэлэн бус мөнгөний гүйлгээний талаар ирүүлсэн мэдээллийн дагуу авсан арга хэмжээний тухай энэ хуулийн 4.1-д заасан этгээд болон эрх бүхий хууль сахиулах байгууллагад тухай бүр мэдээлэх;

18.1.4.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах, сэжигтэй гүйлгээг хянах, илрүүлэх аргачлал боловсруулж энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах;

18.1.5.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан

сэргийлэх талаар олон нийтийн дунд мэдээлэл, сурталчилгаа явуулах;

/Энэ заалтад 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

18.1.6.хориг арга хэмжээний жагсаалтыг энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах;

/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

18.1.7.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын талаар нэгдсэн статистик гаргах, хяналт шалгалт хийх, эрх бүхий бусад этгээдээр хяналт шалгалт хийлгэх;

/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

18.1.8.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд суурилсан үндэсний стратеги боловсруулах, уг стратегийг Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;

/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

18.1.9.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулах.

/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

18.2.Санхүүгийн мэдээллийн албаны хянан шалгагч мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, илэрсэн зөрчлийг арилгахыг энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс шаардах, эсхүл эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлж шалгуулах буюу тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгуулах талаар санал боловсруулж эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх эрхтэй.

18.3.Санхүүгийн мэдээллийн алба энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний албан тушаалтныг хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавина.

18.4.Санхүүгийн мэдээллийн алба өөрийн үйл ажиллагааны талаарх тайланг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд жил бүр танилцуулна.

18.5.Санхүүгийн мэдээллийн албаны дарга, ажилтан хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор иргэний, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн бүртгэл, нийгмийн даатгалын бүртгэл, хилээр нэвтэрсэн тухай бүртгэл, хөрөнгө оруулалтын бүртгэл, татвар төлөлтийн бүртгэл, банк, санхүүгийн байгууллага хоорондын гүйлгээний бүртгэлийн лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулж авах эрхтэй.

/Энэ хэсэгт 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

19 дүгээр зүйл.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналт

/Энэ зүйлийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

19.1.Энэ хуулийн 4.1.1-д заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Монголбанк, энэ хуулийн 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7-д заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах

ажлыг Санхүүгийн зохицуулах хороо, энэ хуулийн 4.1.8, 4.1.9-д заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг тухайн төрлийн үйл ажиллагааны зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих эрх бүхий байгууллага эрсдэлд суурилсан хэлбэрээр тус тус хэрэгжүүлнэ.

/Энэ хэсэгт 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан эрх бүхий байгууллага, Санхүүгийн мэдээллийн алба дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

19.2.1.энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд газар дээрх шалгалт хийх, зайнаас хяналт тавих, шалгалтын удирдамж, журам, заавар, зөвлөмж гаргах;

19.2.2.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, шалгалт хийх зорилгоор баримт, тайлан, мэдээлэл, тайлбар гаргуулан авах;

19.2.3.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэл, гүйцэтгэх удирдлага, ажилтанд тавигдах шаардлагыг тодорхойлох;

19.2.4.санхүүгийн нэгдлийн оролцогч нь өөр улсад бүртгэгдсэн, эсхүл байршдаг бол холбогдох хяналт тавих эрх бүхий байгууллага нь тухайн улсын хяналт тавих эрх бүхий байгууллагатай гэрээ, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан мэдээлэл солилцох, хамтарсан шалгалт хийх хэлбэрээр хамтран ажиллах;

19.2.5.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалтын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зорилгоор холбогдох хяналт тавих эрх бүхий байгууллага хоорондоо болон Санхүүгийн мэдээллийн албатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах;

19.2.6.энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авч байгаа арга хэмжээ болон хариуцлагын талаарх статистик мэдээг нийтэд түгээх;

19.2.7.санхүүгийн нэгдлийн хэмжээнд хуулийн хэрэгжилтийг шалгах шаардлагатай гэж үзвэл Монголбанк, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороотой хамтран нэгдсэн хяналт шалгалтыг хийх.

19.3.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний удирдлага, ажилтан нь хянан шалгагчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааг бие даасан, хараат бусаар явуулах нөхцөлөөр хангана.

19.4.Санхүүгийн мэдээллийн алба шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 4.1-д заасан этгээд хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг энэ хуулийн 19.1-д заасан этгээдтэй хамтран хэрэгжүүлж болно.

20 дугаар зүйл.Мэдээллийн сан

20.1.Санхүүгийн мэдээллийн алба энэ хуульд заасан журмын дагуу цуглуулсан мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн сантай байна.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан мэдээллийн санд мэдээлэл хадгалах, түүнийг ашиглах журмыг Санхүүгийн мэдээллийн албаны дарга батална.

21 дүгээр зүйл. Гадаад улсын ижил төстэй байгууллагатай харилцах

21.1. Санхүүгийн мэдээллийн алба ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг, нууцлалын байдлаар ижил түвшний, гадаад улсын болон олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

21.2. Санхүүгийн мэдээллийн алба энэ хуулийн 21.1-д заасан байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн түүнд шаардлагатай мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн өгч болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

22 дугаар зүйл. Хамтын ажиллагааны зөвлөл

22.1. Санхүүгийн мэдээллийн албаны дэргэд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хамтын ажиллагааны зөвлөл ажиллана.

22.2. Хамтын ажиллагааны зөвлөлд гадаад харилцаа, санхүүгийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, прокурорын байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, татвар, гаалийн байгууллага, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл ажиллана.

22.3. Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг Санхүүгийн мэдээллийн алба хэрэгжүүлнэ.

22.4. Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүн, түүний удирдлагыг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

22¹ дүгээр зүйл. Үндэсний зөвлөл

/Энэ зүйлийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

22¹.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, түүний хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөл ажиллах бөгөөд уг зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайд батална.

22¹.2. Үндэсний зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлэх бөгөөд бүрэлдэхүүнд прокурорын байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий хууль сахиулах болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, татвар, гаалийн байгууллага, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөллийг оролцуулна.

22¹.3. Үндэсний зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг Санхүүгийн мэдээллийн алба хэрэгжүүлнэ.

23 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

23.1. Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

23.2. Энэ хууль, хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон, тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол энэ хуулийн 19.1-д заасан байгууллагын эрх бүхий албан тушаалтан үүссэн нөхцөл байдал, дутагдлыг харгалзан дараах арга хэмжээг авна:

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

23.2.1. дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх, хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

23.2.2. энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;

23.2.3. энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, зогсоох, түдгэлзүүлэх, үйл ажиллагааны зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал гаргах;

/Энэ заалтад 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

23.2.4. энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн эрх бүхий албан тушаалтныг албан тушаалаас чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөрчлөхийг үүрэг болгох.

23.3. Эрх бүхий албан тушаалтнаас энэ хуулийн 23.2-т заасны дагуу өгсөн хугацаатай үүрэг, даалгавар, сануулга, шаардлагыг биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ хэсгийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн./

24 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

24.1. Энэ хуулийг 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

